



**АЛТАИСТИКА,  
ТҮРКОЛОГИЯ,  
МОНГОЛИСТИКА**

Халықаралық ғылыми журнал

**АЛТАИСТИКА,  
ТҮРКОЛОГИЯ,  
МОНГОЛИСТИКА**

Международный научный журнал

**ALTAISTICS,  
TURCOLOGY,  
MONGOLISTICS**

International Scientific Journal

**2020**

**№1**



# **АЛТАИСТИКА, ТҮРКОЛОГИЯ, МОНГОЛИСТИКА**

ХАЛЫҚАРАЛЫҚ ҒЫЛЫМИ ЖУРНАЛ



# **АЛТАИСТИКА, ТЮРКОЛОГИЯ, МОНГОЛИСТИКА**

МЕЖДУНАРОДНЫЙ НАУЧНЫЙ ЖУРНАЛ



# **ALTAISTICS, TURCOLOGY, MONGOLISTICS**

INTERNATIONAL SCIENTIFIC JOURNAL

2020/1

# АЛТАИСТИКА, ТҮРКОЛОГИЯ, МОҢҒОЛИСТИКА

## Халықаралық ғылыми журнал / №1, 2020

### Редакцияның мекен-жайы:

Тәуелсіздік даңғылы, 57, Бейбітшілік пен келісім сарайы, 7-қабат, Нұр-Сұлтан,  
010000, Қазақстан Республикасы, тел.: +7 (7172) 744785  
e-mail: napilbaz@gmail.com, aasem-dariya72@mail.ru

*Журнал Қазақстан Республикасы Ақпарат және коммуникациялар министрлігінде  
4 маусым 2018 жылы тіркеліп, №17132-Ж куәлік берілген.*

*Меншік иесі: Халықаралық Түркі академиясы,  
Алтаистика, түркология, моңғолистика ассоциациясы (АТАМ)*

*2018 жылдан бастап шыға бастаған журнал жылына 4 рет жарияланады.*

### Бас редактор

**Қыдырәлі Дархан Қуандықұлы** - т.ғ.д., профессор, ҚР ҰҒА корр.-мүшесі

### Редакциялық алқа

**Ахметов Әділ Құрманжанұлы** – ф.ғ.д., профессор (Қазақстан); **Берталан Агнеш** - филология докторы, профессор (Мажарстан); **Габиббейли Иса** – ӘР ҰҒА академигі, ф.ғ.д., профессор (Әзербайжан); **Дыбо Анна Владимировна** - ф.ғ.д., профессор, РФА корр.-мүшесі (Ресей); **Жолдасбеков Мырзатай** – ф.ғ.д., профессор, ҚР ҰҒА академигі (Қазақстан); **Келлнер-Хейнкеле Барбара** - филология докторы, профессор (Германия); **Кожаоғлу Тимур** – филология докторы, профессор (АҚШ); **Конкобаев Кадыралы** – ф.ғ.д., профессор (Қырғызстан); **Көмеков Болат Ешмұхамбетұлы** - т.ғ.д., профессор, ҚР ҰҒА академигі (Қазақстан); **Минуллин Ким Мугаллимович** - ф.ғ.д., профессор (Татарстан); **Түймебаев Жансейіт Қансейітұлы** - ф.ғ.д., профессор (Қазақстан); **Чулуун Сампилдондовын** - т.ғ.д., профессор (Моңғолия); **Хисамитдинова Фирдаус Гильмитдиновна** - ф.ғ.д., профессор (Башқұртстан)

### Редакциялық кеңес

**Бабаяров Ғайбулла Боллиевич** – т.ғ.д. (Өзбекстан); **Бира Шағдарын** - т.ғ.д., профессор, МҒА академигі (Моңғолия); **Бутанаев Виктор Яковлевич** - т.ғ.д., профессор (Хакасия); **Васильев Дмитрий Дмитриевич** - т.ғ.к., профессор, РЖҒА корр.-мүшесі (Ресей); **Ержиласун Ахмет Бижан** – филология докторы, профессор (Түркия); **Иваныч Мари** - доктор, профессор (Мажарстан); **Кузьмина Евгения Николаевна** - ф.ғ.д., профессор (Ресей); **Кызласов Игорь Леонидович** – т.ғ.д., профессор (Ресей); **Попова Ирина Федоровна** – т.ғ.д., профессор (Ресей); **Райхл Карл** - филология докторы, профессор (Германия); **Солонгод Хурибаатар** - ғылым докторы, профессор (Германия); **Тажимаева Сәуле Жақсылықбаевна** - ф.ғ.д., профессор (Қазақстан); **Худяков Юлий Сергеевич** – т.ғ.д., профессор (Ресей); **Цэвээндорж Дамдинсүрэнгийн** - т.ғ.д., профессор, МҒА академигі (Моңғолия); **Чой Хан Ву** - филология докторы, профессор (Корея); **Шамильоглу Юлай** - филология докторы, профессор (АҚШ); **Янковский Генрик** - филология докторы, профессор (Польша)

### Жауапты редакторлар

**Абаева Әсем-Дария Әскербекқызы** – ф.ғ.к.; **Базылхан Нәпіл** – ф.ғ.к.; **Козырев Тимур Анатольевич** – ф.ғ.к.; **Қалжанова Эльмира Шакиздаевна** – PhD докторы; **Тойшанұлы Акеділ** – ф.ғ.к.

### Компьютерде беттеген

**Сқакова Асерке**

© Халықаралық Түркі академиясы, 2020

© Алтаистика, түркология, моңғолистика  
ассоциациясы - АТАМ, 2020

© “Ғылым” баспасы, 2020

# АЛТАИСТИКА, ТЮРКОЛОГИЯ, МОНГОЛИСТИКА

## Международный научный журнал / №1, 2020

### Адрес редакции:

пр.Тәуелсіздік, 57, Дворец мира и согласия, 7-этаж, Нур-Султан,  
010000, Республика Казахстан, тел.: +7 (7172) 744785  
e-mail: napilbaz@gmail.com, aasem-dariya72@mail.ru

*Журнал зарегистрирован в Министерстве информации и коммуникации Республики Казахстан  
от 4 июня 2018 года, выдано свидетельство №17132-Ж.*

*Собственник: Международная Тюркская академия,  
Ассоциация алтаистики, тюркологии, монголистики (АТАМ)*

*Журнал издается с 2018 года с периодичностью четыре раза в год.*

### Главный редактор

**Кыдырали Дархан Куандыкулы** - д.и.н., профессор, член-корр. НАН РК

### Редакционная коллегия

**Ахметов Адил Курманжанович** – д.ф.н., профессор (Казахстан); **Берталан Агнеш** - доктор филологии, профессор (Венгрия); **Габиббейли Иса** – д.ф.н., профессор, академик НАНА (Азербайджан); **Дыбо Анна Владимировна** - д.ф.н., профессор, член-корр. РАН (Россия); **Жолдасбеков Мырзатай** – д.ф.н., профессор, академик НАН РК (Казахстан); **Келлнер-Хейнкеле Барбара** - доктор филологии, профессор (Германия); **Кожаоглу Тимур** – доктор филологии, профессор (США); **Конкобаев Кадыралы** – д.ф.н., профессор (Кыргызстан); **Кумеков Болат Ешмухамбетович** - д.и.н., профессор, академик НАН РК (Казахстан); **Минуллин Ким Мугаллимович** - д.ф.н., профессор (Татарстан); **Туймебаев Жансейит Кансейитович** - д.ф.н., профессор (Казахстан); **Чулуун Сампилдондовын** - д.и.н., профессор (Монголия), **Хисамитдинова Фирдаус Гильмитдинована** - д.ф.н., профессор (Башкортостан)

### Редакционный совет

**Бабаяров Гайбулла Боллиевич** – д.и.н. (Узбекистан); **Бира Шагдарын** - д.и.н., профессор, академик АН МНР (Монголия); **Бутанаев Виктор Яковлевич** - д.и.н., профессор (Хакасия); **Васильев Дмитрий Дмитриевич** - к.и.н., профессор, член-корр. РАН (Россия); **Ержиласун Ахмет Бижан** – доктор филологии, профессор (Турция); **Иваныч Мари** - доктор, профессор (Венгрия); **Кузьмина Евгения Николаевна** - д.ф.н., профессор (Россия); **Кызласов Игорь Леонидович** – д.и.н., профессор (Россия); **Попова Ирина Федоровна** – д.и.н., профессор (Россия); **Райхл Карл** – доктор филологии, профессор (Германия); **Солонгод Хурцбаатар** – доктор наук, профессор (Германия); **Тажимаева Сауле Жаксылыкбаевна** - д.ф.н., профессор (Казахстан); **Худяков Юлий Сергеевич** – д.и.н., профессор (Россия); **Цэвэндорж Дамдинсүрэнгийн** - д.и.н., профессор, академик АН МНР (Монголия); **Чой Хан Ву** – доктор филологии, профессор (Корея); **Шамильоглу Юлай** – доктор филологии, профессор (США); **Янковский Генрик** – доктор филологии, профессор (Польша)

### Ответственные редакторы

**Абаева Асем-Дария Аскербекевна** – к.ф.н.; **Базылхан Напил** – к.ф.н.; **Калжанова Эльмира Шакизадаевна** – доктор PhD; **Козырев Тимур Анатольевич** – к.ф.н.; **Тойшанулы Акедил** – к.ф.н.

Компьютерная верстка  
Скаковой Акерке

© Международная Тюркская академия, 2020  
© Ассоциация алтаистики, тюркологии, монголистики -АТАМ, 2020  
© Издательство “Ғылым”, 2020

# ALTAISTICS, TURCOLOGY, MONGOLISTICS

## International Scientific Journal / №1, 2020

### Editorial office address:

Tauelsizdik street 57, Palace of Peace and Reconciliation, 7<sup>th</sup> Floor, Nur-Sultan, 010000, Republic of Kazakhstan  
Tel: +7 (7172) 744785  
E-mail: napilbaz@gmail.com, aasem-dariya72@mail.ru

This journal registered on the Ministry of Information and Communication of the Republic of Kazakhstan on **June 4, 2018** and issued the certificate №7132-Ж.

**Ownership:** International Turkic Academy,  
Association for Altaistics, Turkology, Mongolistics (ATAM)

*The journal has been published since 2018, 4 issues a year.*

### Editor-in-Chief:

**Darkhan Kydyrali** - PH.D in History, Professor, Corresponding member of National Academy of Sciences of the Republic of Kazakhstan

### Editorial Board:

**Adil Ahmetov**- PH.D in Philology, Professor (Kazakhstan); **Anna Dybo** - PH.D in Philology, Professor, Corresponding member of Russian Academy of Sciences (Russia); **Barbara Kellner-Heinkele** - PH.D in Philology, Professor (Germany); **Birtalan Agnes** - PH.D in Philology, Professor (Hungary); **Bolat Komekov** - PH.D in Philology, Professor, Academician of National Academy of Sciences of the Republic of Kazakhstan (Kazakhstan); **Chuluun Sampildondovin** - PH.D in History, Professor (Mongolia); **Firdaus Khisamitdinova** - PH.D in Philology, Professor, (Bashkortostan); **Isa Gabibbeili** - PH.D in Philology, Professor, member of National Academy of Science of the Republic of Azerbaijan (Azerbaijan); **Kim Minullin** - PH.D in Philology, Professor (Tatarstan); **Konkobaev Kadyrali** - PH.D in Philology, Professor (Kyrgyzstan); **Myrzatai Zholdasbekov** - PH.D in Philology, Professor, member of National Academy of Sciences of the Republic of Kazakhstan (Kazakhstan); **Timur Kocaoglu** - Doctor of Philology, Professor, (USA); **Zhanseyit Tuymebaev** - PH.D in Philology, Professor (Kazakhstan)

### Editorial Council:

**Ahmet Bican Ercilasun** - Doctor of Philology, Professor (Turkey); **Bira Shagdarly** - PH.D in History, Professor, member of National Academy of Sciences of Mongolia (Mongolia); **Choi Khan Wu** - PH.D in Philology, Professor (Korea); **Dimitry Vasilyev** - PH.D in History, Professor, Corresponding member of Russian Academy of Natural Sciences (Russia); **Gaybolla Babayrov** - PH.D in History, (Uzbekstan); **Henryk Jankowski** - Doctor of Philology, Professor (Poland); **Igor Kyzylasov** - PH.D in History, Professor (Russia); **Irina Popova** - PH.D in History, Professor (Russia); **Karl Reichl** – Doctor of Philology, Professor (Germany); **Mary Ivanic** - Doctor, Professor (Hungary); **Saule Tazhibaeva** - PH.D in Philology, Professor (Kazakhstan); **Solonggod Hurcabaatar** - PH.D in History, Professor (Germany); **Tsevendorzh Damdinsuren** - PH.D in History, member of National Academy of Sciences of Mongolia (Mongolia); **Uli Schamiloglu** - Doctor of Philology, Professor (USA); **Viktor Butanayev** - PH.D in History, Professor (Russia); **Yevgenia Kuzmina** - PH.D in Philology, Professor (Russia); **Yuliy Khudyakov** - PH.D in History, Professor (Russia);

### Managing Editors

**Akedil Toishanulu** – Candidate of Philological Sciences; **Asem-Darya Abaeva** – Candidate of Philosophy Sciences; **Napil Bazykhan** – Candidate of Philological Sciences; **Kalzhanova Elmira** – PH.D; **Timur Kozyrov** – Candidate of Philological Sciences.

### Designer

**Akerke Skakova**

© International Turkic Academy, 2020  
© Association for Altaistics, Turkology,  
Mongolistics – ATAM, 2020  
© “Gylym” publishing house, 2020

## М А З М Ү Н Ы C O N T E N T S

Қыдырәлі Д. *Алғысөз* ..... 6

### АРХЕОЛОГИЯ ARCHEOLOGY

**Қыдырәлі Д., Сүхбаатар Д., Одбаатар Ц., Тойшанулы А.,  
Цогтбаатар Б., Будбаяр И., Баяндэлгэр Ч., Бүрэнтөгс Л.**  
*Олон улсын Түрэг академи, Монголын үндэсний музейн хамтарсан  
археологийн хээрийн судалгааны ангийн 2019 оны товч тайлан  
(Гүнбүрд тахилын онгон цогцолборын судалгаа)* .....7

**Мөнхтулга Р.** *Билгэ хааны онгоны хавтант хашилага хэнийх вэ?* .....41

### ТАРИХ ЖЭНЕ ДЕРЕКТАНУ HISTORY AND HISTORICAL SOURCE

**Пилипчук Я.В.** *Миграции огурских племен (V-VII ВЕК)* .....52

**Батболд Г.** *Шивэй аймгийн нэрийн тухайд* .....77

**Өлзийбаяр С.** *Хан Хэнтий уулын нэрийн үүслийн асуудалд* .....93

### ЭТНОГРАФИЯ ENTHOGRAPHY

**Рэгдэл Д., Энхтуяа Б.** *Бэлчээрийн монгол малын мах* .....104

**Муканов М. Ф., Досжанов Б. Т., Сулейменов М. Ш.**  
*Художественные образы архетипов моделей тюрского мироздания  
в искусстве современного казахского гобелена* .....116

### ТҮЛ ЖЭНЕ ЭДЕБИЕТ LINGUISTICS AND LITERATURE

**Бадамдорж Д.** *Монгол хэлний тогтолцооны гурвал бүрэлдүүлбэр* .....135

## АЛҒЫСӨЗ

### Құрметті оқырман!

«Алтаистика, түркология, моңғолистика» халықаралық журналының 2020 жылғы кезекті № 1 санында ортағасырлық түрк археологиясына, түрк, моңғол тілдеріне, этнографиясына қатысты бірқатар жаңа ғылыми зерттеулер қамтылды.

Атап айтқанда, Академияның Моңғолия ұлттық музейімен бірлескен археологиялық экспедициясының «Гүнбүрд» ғұрыптық кешенінде 2019 жылы жүргізілген қазба зерттеулерінің қорытындысы», Р.Мөнхтулга «Білге қаған ғұрыптық кешені тас қаптал кімдікі», Я.В. Пиллипчуктің «Огур тайпаларының көштері (V-VII ғғ.)», Г. Батболд «Шивэй тайпасының атауы», С.Өлзийбаяр «Хан Хэнтий тау атауының этимологиясы», Д. Рэгдэл, Б. Энхтуяа «Моңғол жайылымдық малдың еті» , М.Мұқанов, Б.Досжанов, М.Сүлейменова «Қазіргі қазақ гобелен өнеріндегі түрк дүниетаным архетиптік моделінің көркем образдары», Д.Бадамдорж « Моңғол тілі құрылымдық үш тұғыры» атты зерттеу мақалалары жарияланып отыр.

Журналға тың материалдар мен соны мақалалар күтеміз!

*Құрметпен,*  
Бас редактор

Дархан Қыдырәлі

---

**АРХЕОЛОГИЯ  
ARCHEOLOGY**

---

МРНТИ 03.41

УДК 902.2

**Кыдырали Д<sup>1.</sup>, Сүхбаатар Д<sup>2.</sup>, Одбаатар Ц<sup>3.</sup>, Тойшанулы А<sup>4.</sup>,  
Цогтбаатар Б<sup>5.</sup>, Будбаяр И<sup>6.</sup>, Баяндэлгэр Ч<sup>7.</sup>, Бүрэнтогс Л<sup>8.</sup>**

<sup>1</sup>Олон улсын Түрэг Академийн ерөнхийлөгч, түүхийн ухааны доктор, профессор

<sup>2</sup>Монголын үндэсний музейн захирал, түүхийн ухааны доктор

<sup>3</sup>Монголын Үндэсний музейн Археологи-Антропологи-секторын эрхлэгч, доктор

<sup>4</sup>Олон улсын Түрэг Академийн шинжээч, Казахстан дахь Монгол улсын соёлын элч, хэл бичгийн ухааны доктор, аман зохиол судлаач, угсаатны зүйч

<sup>5</sup>ШУА-ийн Түүх-Археологийн хүрээлэнгийн тэргүүлэх ажилтан, түүхийн ухааны доктор

<sup>6</sup>Монголын үндэсний музейн Бодлого төлөвлөлт удирдлагын хэлтсийн дарга

<sup>7</sup>Монголын үндэсний музейн эрдэм шинжилгээний ажилтан, магистр

<sup>8</sup>Хэнтий аймгийн музейн эрдэм шинжилгээний ажилтан, археологич

**ОЛОН УЛСЫН ТҮРЭГ АКАДЕМИ, МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ  
МУЗЕЙН ХАМТАРСАН «ГҮНБҮРД» ТАХИЛЫН ОНГОН ЦОГЦОЛ-  
БОРТ ГҮЙЦЭТГЭСЭН АРХЕОЛОГИЙН ХЭЭРИЙН СУДАЛГААНЫ  
АНГИЙН 2019 ОНЫ ТОВЧ ТАЙЛАН**

Тус өгүүлэлд Олон улсын Түрэг академи, Монголын үндэсний музейн хамтарсан «Гүнбүрд» тахилын онгон цогцолборт гүйцэтгэсэн археологийн хээрийн судалгааны ангийн 2019 оны урьдчилсан үр дүн хамрагдсан болно. Энэхүү төсөл 2017 оноос эхэлсэн бөгөөд уг дурсгалуудыг хамгаалах тусгай хашаа байгуулсан юм. Хамтарсан экспедици 2019 онд малтлага судалгаагаа үргэлжлүүлэн гүйцэтгэгдсэн бөгөөд Гүн бүрдийн тахилын онгон нь Монголын зүүн бүс нутгийн түрэгийн үеийн тахилын онгон дотор томоохонд тооцогдох дурсгал бөгөөд ангилалын хувьд Түрэгийн язгууртны тахилын онгон байх бололцоотой юм.

**Түлхүүр үг:** Монгол улс, Хэнтий аймаг, Гүнбүрд, дундад зууны тахилын онгон, түүх, музей.

FTAMP 03.41

ЭОЖ 902.2

Кыдырали Д<sup>1</sup>., Сүхбаатар Д<sup>2</sup>., Одбаатар Ц<sup>3</sup>.,  
Тойшанулы А<sup>4</sup>., Цогтбаатар Б<sup>5</sup>., Будбаяр Иб., Баяндэлгэр Ч<sup>7</sup>.,  
Бүрэнтөгс Л<sup>8</sup>.

<sup>1</sup>Халықаралық Түркі академиясының Президенті,  
тарих ғылымдарының докторы, профессор

<sup>2</sup>Моңғолия ұлттық музейінің директоры, тарих ғылымдарының докторы

<sup>3</sup>Моңғолия Ұлттық музейінің Археология-антропология  
секторының меңгерушісі, доктор

<sup>4</sup>Халықаралық Түркі академиясының аға сарапшысы,  
Моңғолияның мәдени елшісі, филология ғылымдарының кандидаты,  
этнограф, фольклортанушы

<sup>5</sup>Моңғолия Ғылым академиясы Тарих-археология институтының  
ғылыми қызметкері, тарих ғылымдарының докторы

<sup>6</sup>Моңғолия ұлттық музейінің Жобалау, жоспарлау, басқару  
бөлімінің меңгерушісі

<sup>7</sup>Моңғолия ұлттық музейінің ғылыми қызметкері, магистр

<sup>8</sup>Хэнтий аймағы музейінің ғылыми қызметкері, археолог

## ХАЛЫҚАРАЛЫҚ ТҮРКІ АКАДЕМИЯСЫ МЕН МОҢҒОЛИЯ ҰЛТТЫҚ МУЗЕЙІНІҢ БІРЛЕСКЕН АРХЕОЛОГИЯЛЫҚ ЭКСПЕДИЦИЯСЫ «ГҮНБҮРД» ҒҰРЫПТЫҚ КЕШЕНІНДЕ ЖҮРГІЗІЛГЕН ҚАЗБА ЗЕРТТЕУЛЕРІНІҢ 2019 ЖЫЛҒЫ ҚЫСҚАША ЕСЕБІ

Бұл мақалада Моңғолияның Хэнтий аймағы Дэлгэрхаан сұмынында орналасқан Гүнбүрд ортағасырлық түрк ғұрыптық кешенінде жүргізілген археологиялық зерттеулердің алғашқы нәтижелері баяндалды. Бұл жоба 2017 жылдан бастап Халықаралық Түркі академиясы мен Моңғолияның Ұлттық музейі бірлескен археологиялық экспедициясы тарапынан жүзеге асырылып келеді. Сонымен қатар, екі тарап кешендерді қорғау үшін арнайы қоршаулар орнатты. 2019 жылы археологиялық қазба жұмыстары жалғасып жүргізілді, бұл кешен көне түрк дәуіріне тиесілі ірі кешендердің бірі.

**Кілт сөздер:** Моңғолия, Хэнтий, Гүнбүрд, ортағасырлық түрк ғұрыптық кешені, ортағасыр тарихы, музей.

IRSTI 03.41

UDC 902.2

**Kydyrali D<sup>1</sup>., Sukhbaatar D<sup>2</sup>., Odbaatar Y<sup>3</sup>., Toishanuly A<sup>4</sup>., Tsogtbaatar B<sup>5</sup>.,  
Budbayar I<sup>6</sup>., Bayandelger C<sup>7</sup>., Burentegs L<sup>8</sup>.**

<sup>1</sup>President of the International Turkic Academy, Doctor of Historical Sciences,  
Professor

<sup>2</sup>Director of the National Museum of Mongolia, Doctor of History

<sup>3</sup>Dr., Head of the Archeology and Anthropology Sector at the National Museum  
of Mongolia

<sup>4</sup>Expert of the International Turkic Academy, Mongolian Cultural Ambassador  
to Kazakhstan, Doctor of Literature, Oral Studies, Ethnologist

<sup>5</sup>Leading Fellow of the Historical and Archeological Institute of the Academy  
of Sciences, Doctor of Historical Sciences

<sup>6</sup>Head of the Planning and Management Division of the National Museum  
of Mongolia

<sup>7</sup>Researcher and Master of National Museum of Mongolia

<sup>8</sup>Research Scientist and Archeologist at Khentii Province Museum

**REPORT OF THE ARCHEOLOGICAL EXCAVATION STUDY OF  
2019 Y. COMPLETED BY THE GÜNBURD SACRIFICIAL COMPLEX IN  
COLLABORATION WITH THE INTERNATIONAL TURKIC ACADE-  
MY AND THE NATIONAL MUSEUM OF MONGOLIA**

In this article we introduce the preliminary findings of archeological researches conducted in medieval Turkic complex of Gunburd which located in Hantai and Dalgerhaan region of Mongolia. This project conducted in 2017 by International Turkic Academy and National Museum of Mongolia. Moreover, two parties build iron curtain outside of two complexes to protect them. And conducted archaeological excavation in 2019.

**Keywords:** Mongolia, Hantai, Gunburd, Medieval Turkic complex, History, Museum.

Монголын Үндэсний музей, Олон улсын Түрэг Академи 2016 оны 8 дугаар сарын 26-ны өдөр санамж бичигт гарын үсэг зурснаар археологийн судалгааны салбарт хамтран ажиллах болсон юм.

2017 оноос тус хоёр байгууллага хамтран Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын нутагт байрлах Гүн бүрд, Хаяа худаг хэмээх газруудад байх түрэгийн тахилын онгоны цогцолборт археологийн судалгааны ажил эхлүүлжээ.

2017 оны 8 дугаар сарын 15-аас 9 дүгээр сарын 15-ны өдрийн хугацаанд Гүн бүрд, Хаяа худагийн дурсгалт газруудад 2D, 3D зураглал, ургамалжилт, өндөршилийн зураг болон геофизикийн тандалт судалгааны ажлыг гүйцэтгэсний дараа хамгаалалтын төмөр хашаа барьж, тайлбарт самбар байршуулан орон нутагт хүлээлгэн өгсөн байна.

2018 онд Хаяа худагийн Түрэгийн тахилын онгоны малтлага судалгааг бүрэн хэмжээгээр хийж, Гүн бүрдийн дурсгалт газарт сорилтын малтлага ажлыг эхлүүлээ.

2019 онд Монголын Үндэсний музей, Олон улсын Түрэг академи хамтран 7 дугаар сарын 3-ны өдрөөс 7 дугаар сарын 24-ний өдрийг хүртэл Гүн бүрдийн дурсгалт газар өмнө жил хийсэн сорилын малтлагыг үргэлжлүүлэн малтан судлахаар төлөвлөн ажиллав.

Тус судалгаа нь VI-VII зууны үед Төв азийн нутагт төр улсаа мандуулж байсан Түрэгийн хаант улсын газар нутгийн хүрээ хязгаарыг нарийвчлан тогтооход нэмэр болохуйц мэдээ материалыг олж илрүүлэх, малтлагаар гарсан археологи, антропологи хэрэглэгдэхүүнд түшиглэн тухайн бүс нутагт амьдарч байсан язгууртан болон энгийн ард иргэдийн амьдрал ахуйг тодруулахыг зорьж байна. Тухайн үедээ тахилга шүтээний газар байсан Гүн бүрдийн малтлага судалгааны үр дүнг байгалийн болон түүхийн хавсрага ухаанаар нарийвчлан судлах, олдсон олдвор хэрэглэгдэхүүнийг сэргээн засварлах, хадгалж хамгаалах, музейн үзмэрт шилжүүлэх зэрэг ажлыг хэрэгжүүлэх бидний төлөвлөгөөний эхний шатны ажлууд тодорхой хэмжээгээр биелж эхэлсэн хэмээн үзэж болно. Иймд бид судалгааны үр дүнд шинэ олдвор, баримт материал илрүүлэн, олдвор хэрэглэгдэхүүн болон дурсгалт газрын он цагийг байгалийн ухааны аргаар багтай тогтоож, учир холбогдлыг шинжлэх ухааны үндэслэлтэй тайлбарлах нь чухал юм. Дурсгалт газарт түшиглэн ил музей байгуулах болон байгаль, нүүдэлчдийн уламжлалт соёлыг хослуулан аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгох судалгаа, сурталчилгааны ажилд нь идэвхтэй оролцож орон нутагтай хамтран ажилласандаа бид баяртай байх болно.

### **Судалгааны ажлын зорилго**

Энэ жилийн малтлага судалгаагаар Гүн бүрдийн тахилын онгоныг судалгааны хугацаандаа тааруулан сорилтын малтлага хийх, малтлагын нийт талбайг тодорхойлох, сувгийн бүтэц хэмжээг тодруулах зорилготой ажиллав. Тус төслийн хэтийн зорилго нь Түрэгийн үеийн онгон шүтээн, тахилга тайлгын газар болох Гүн бүрдийн үл хөдлөх дурсгалуудын хадгалалт хамгаалалтыг сайжруулах, Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын нутаг дахь Хэрлэн мөрний хойд эрэг дагуу орших Түрэгийн үеийн археологийн дурсгалуудыг шинээр нээн илрүүлэх, зэргэлдээ орших түүх, соёлын дурсгалуудыг цогц байдлаар судлахад оршино. 2019 онд археологийн малтлага судалгаа хийж гүйцэтгэсний дараа тайлбарт самбарыг шинэчлэн, Дэлгэрхаан сумын аялал жуулчлалын маршрутад шинээр оруулах, гадаад дотоодын аялагчдын үзэх

нэгэн дурсгал болгохоор ажиллаж байна. Судалгааны анги 2019 оноос Гүн бүрд, Хаяа худаг дахь археологийн дурсгалд малтлага судалгаа явуулахын зэрэгцээ Хэнтий аймгийн нутаг дахь Түрэгийн үеийн (VI-VII зуун) зарим дурсгалууд, Монголын үндэсний музейд хадгалагдаж буй Түрэгийн үед холбогдох үзмэрүүдийг багтаасан каталог ном болон хээрийн судалгааны ажлын тайлан, өгүүлэл зэрэг хамтын бүтээлүүдийг монгол, казак, англи хэлээр нийтлүүлэхээр төлөвлөж байна.

### **Судалгааны ангийн бүтэц, зохион байгуулалт**

Гүн бүрдийн түрэгийн тахилын онгон цогцолборт ажилласан тус хээрийн шинжилгээний ангид төслийн удирдагчаар МҮМ-н захирал доктор, Д.Сүхбаатар, МҮМ-н ЭШТ-ийн Археологи-Антропологийн секторын эрхлэгч, доктор Ц.Одбаатар, төслийн зөвлөхөөр ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэнгийн Археологийн судалгааны төвийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан доктор, дэд профессор Б.Цогтбаатар, Төслийн зохицуулагчаар МҮМ-н Бодлого төлөвлөлт удирдлагын хэлтсийн дарга И.Будбаяр судлаачаар МҮМ-н эрдэм шинжилгээний ажилтан, археологич, магистр Ч.Баяндэлгэр нар ажиллав. Олон улсын Түрэг академийн талаас Төслийн удирдагчаар доктор, Дархан Кыдыралы, судлаач, угсаатан зүйч, доктор Акедил Тойшанулы оролцон ажиллав.

Хээрийн судалгааны ажлын туслах ажилтнаар, археологич Э.Балжинням, МУИС-ийн Антропологи, археологийн тэнхимийн 3-р дамжааны оюутан О.Сосорбарам, УБИС-ийн Түүх, археологийн тэнхимийн 3-р дамжааны оюутан А.Намсрайжамц, 2-р дамжааны оюутан Б.Цэндбаяр, Б.Төгсжаргал, Б.Очирхуяг, О.Наранбаатар, МУИС-ын Санхүү эдийн засгийн сургуулийн 3-р дамжааны оюутан Э.Лхагва-Очир, сурагч Э.Энхбаяр, Б.Улсболд болон ШУТИС-ын Инженерийн сургуулийн оюутан Н.Асылбек нар ажиллав.

Мөн МҮМ-н жолооч Ш.Ням-Осор болон МҮМ-н дизайнер Ц.Гансүлд нарын 2 жолооч, Н.Цэдэвсүрэн, Э.Даваадулам нарын 2 тогоочтой ажиллав.

Мөн МҮМ-н захирал, гавьяат багш, доктор Д.Сүхбаатар болон Олон улсын Түрэг академийн ерөнхийлөгч, профессор, академич Дархан Кыдырالی, ШУА-ын тэргүүлэх ажилтан Б.Цогтбаатар нар бидний малтлага судалгааг дэмжиж, зөвлөж ажилласан юм.

2019 онд Монголын Үндэсний музей, Олон улсын Түрэг Академи хамтран Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын сайдын 2019 оны 4 дугаар сарын 22-ны өдрийн А/233 тоот тушаал, Палеонтологи, Археологийн хайгуул, малтлага судалгаа хийлгэх мэргэжлийн зөвлөлийн 2019 оны 4 дугаар сарын 22-ны өдөр гаргасан №64 тоот зөвшөөрөл, Монголын Үндэсний музейн үр дүнгийн гэрээний 1.3.2 дахь заалт, 2019 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн А/122 тоот тушаалын дагуу Гүн бүрдэд орших Түрэгийн тахилын онгон, цогцолборт малтлага судалгааны ажлыг эхлүүлэв.

## ГҮН БҮРДИЙН ДУРСГАЛТ ГАЗАРТ ХИЙСЭН СУДАЛГАА

### Гүн бүрдийн дурсгалт газар

Хэнтий аймгийн Дэлгэрхаан, Баянмөнх сумдын зааг нутаг Гүн бүрд хэмээх жижиг цөөрмийн захаас зүүн тийш 350 м зайд, N46°58,279' E109°28,912' цэгийн огтлолцол дээр байрлах, эртний Түрэгийн үед хамаарах намхан шороон далан, гурван ширхэг тахилгын хавтан чулуу, толгой, гар нь хугарсан 2 ширхэг хүн чулуу буйг нутгийхан “Чингисийн гүүн зэл” хэмээн домоглон нэрлэдэг. Эдгээр дурсгалууд нь анхны байрлалаас хөдөлж, эмх замбараагүй болсон бөгөөд 24-30х26-32 м орчим хэмжээтэй дөрвөлжин бололтой шороон далантай (Зураг 1,2). Хоёр хүн чулууны нэг нь хавтан чулууудын хамт шороон далангийн дотор байгаа бол нөгөөх нь хойд зүгт нэлээд хол зайд дэрсэн дотор байна. Гурван хавтан чулууны хувьд хоёр нь адил хийц, хээ чимэгтэй, үлдсэн нэг нь огт өөр товойлгон сийлсэн хээ чимэгтэй, хийсэн чулуу нь ч өөр байна

Тахилын хавтан чулууны хоёрыг нэг ижил төрлийн чулуугаар, адил хээ чимэгтэй хийж, нөгөө нэгийг өөр төрлийн чулуугаар хийж, хээг товойлгон сийлсэн байна. 2011 онд Монголын Үндэсний музейн судалгааны багийг анх очиход хавтан чулууудын хоёр нь ил, нэг нь газарт хагас булаатай, ил буй хоёр хавтан чулууны нэг нь гэмтэж хагарсан байдалтай байжээ. Судалгааны багынхан хагас булагдсан хавтан чулууг эгцэлж босгожээ<sup>1</sup>(Зураг 1). Хавтан чулууд дээр буй бүдэгхэн цэцгэн хээг нутгийн ардууд “адуун туурайн тамга” хэмээн ташааран ойлгож, өөр хоорондоо ярьж ирсэн байна.



*Зураг 4.1-1 Гүн бүрдийн дурсгалт газрын ерөнхий байдал /хойноос/*

<sup>1</sup> Ж.Баярсайхан, С.Энхболд, Д.Шинэсаран. Монголын Үндэсний Музейн Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын нутагт хийсэн археологийн судалгааны тайлан. УБ.,2011. Тал.17-25.

### Судлагдсан байдал

Гүн бүрдийн дурсгалт газар анх 1992-1993 оны Монгол-Японы хамтарсан “Турван гол” шинжилгээний ангийн тайланд тусгагдсан<sup>4</sup>. 1999 он, 2006 онд хэвлэгдсэн “Монгол улсын нутаг дахь түүх соёлын дурсгал” номонд дурдагдсан байна.<sup>5</sup> 2010 онд хэвлэгдсэн Монгол нутаг дахь түүх соёлын үл хөдлөх дурсгал 1-р дэвтэр Хэнтий аймаг сэдэвчилсэн лавлах номонд хэвлэгдсэн байдаг.<sup>6</sup>

2011 онд Монголын Үндэсний музейн “Хэнтий-Дэлгэрхаан” төслийн баг дурсгалт газрын хүн чулуун хөшөөд, тахилгын хавтан чулуудын хэмжилтийг хийж, гар зураг, бүрэн тодорхойлолтыг үйлдэн, тайландаа хэвлүүлжээ<sup>7</sup>. 2017 онд Монголын Үндэсний музей Олон улсын Түрэг Академитай хамтарсан судалгааны баг Гүн бүрдийн дурсгалт газарт геофизикийн судалгааг хийж, бүрэн хэмжээний баримтжуулалтыг гүйцэтгэсэн юм. 2018 онд Монголын Үндэсний музей Олон улсын Түрэг академитай хамтарсан судалгааны баг тахилын онгоны зүүн хэсэгт сорилтын малтлага хийж олон тооны дээврийн тосгуур болон нөмрөг ваарны хагархайнуудыг олсон байна.



*Дурсгалын хажууд орших Гүн бүрд нуур*

## ГҮН БҮРДИЙН ДУРСГАЛТ ГАЗАРТ ХИЙСЭН АРХЕОЛОГИЙН СУДАЛГАА

### Хүн чулуу

Гүн бүрдийн 1-р хүн чулуу: 81 см өндөр, 61 см өргөн, 30 см зузаан хэмжээтэй. Чулуун хөшөөний биеийн ерөнхий галбирыг хүн биеийн бодит байдалтай дөхүү урласан. Завилан суугаад, баруун гартаа аяга барьж, зүүн гараа зүүн өвдгөн дээрээ тавьсан хүн чулууг саарал боржин чулуугаар сийлжээ. Дээлний зүүн энгэр гадагш эргэсэн гурвалжилсан захтай, буруу энгэртэй дээлтэй, гэдэс нь бага зэрэг ургааш түрж гарч ирсэн маягтай, бүсэлхий орчмоор цэцгэн товруутай бүстэй, баруун ташаан дээр нь хагас дугуй хэлбэртэй хавтагатай. Бүсний өргөн 3,5 см хэмжээтэй. Уг хөшөөний толгой, баруун гар нь бүтэнээрээ, зүүн гар нь дундуураа хугарч байхгүй болсон, өвдөгний хэсэг, бөсөн бие нь эмтэрч унасан байдалтай хадгалагдан үлджээ (зураг 4.3-1).



*Зураг 4.3-1 Гүн бүрдийн 1-р хүн чулуу (Урд, хойд, хажуу талаас)*

Гүн бүрдийн 2-р хүн чулуу: Саарал боржин чулуугаар хийсэн. 80 см өндөр, 60 см өргөн, 43 см зузаан. Чулуун хөшөөний биеийн ерөнхий галбирыг хүн биеийн бодит байдалтай дөхүү урласан. Завилан суугаа байдалтай хүн чулууг саарал боржин чулуугаар хийжээ. Дээлний зүүн энгэр гадагш эргэсэн гурвалжилсан захтай, буруу энгэртэй дээлтэй. Уг хөшөөний толгой, баруун гар, зүүн гар нь угаараа хугарч байхгүй болсон, он цагийн уртад элэгдэж мөлийсөн байдалтай болжээ (зураг 4.3-2)



Зураг 4.3-2 Гүн бүрдийн 2-р хүн чулуу

### Гүн бүрдийн тахилгын хавтан чулууд

Гүн бүрдийн 1-р хүн чулууны зүүн талд буй тахилгын онгоны гурван хавтан чулууг 1-3 хүртэл дугаарлаж, тодорхойлолт хийж, гар зураг үйлдэн, гэрэл зургаар баримтжуулав.

**Тахилгын хавтан чулуу № 1:** 210 см урт, 146 см өргөн, 14 см зузаан, тэгш өнцөгт хэлбэртэй. Хавтан чулууны нэг талд дөрвөн дэлбээтэй цэцэгнээс гадагшаа ижил давтамжтай дэлбээлсэн найман /8/ дэлбээтэй хос цэцгийг орон зайд таацуулан уран гоёмсогоор хонхойлгон сийлжээ. Цэцгэн хээний завсар, булангийн зайд эвэр угалз, үүлэн хээг багтааж өгчээ. Дээд ирмэгийг дагуулан нэг шулуун гурви татаж, түүнээс доош 12 см зайд хоорондоо 3 см зайтай зэрэгцээ хоёр шулуун гурви татаж өгсөн байна. Зэрэгцээ хоёр гурви болон дээд ирмэг дагуух шулуун гурвийн хооронд угалзарсан үүлэн хээг долоон удаа дүрсэлсний зүүн талын нэг үүлэн хээний ихэнх хэсэг хагарч гэмтэсний улмаас үгүй болжээ. Түүнчлэн зүүн талын цэцгэн хээний зүүн дээд хэсэг хийгээд зүүн булангийн хээ хагарч үгүй болсон байна. Хавтан чулуунаа сийлсэн гоёмсог хээнүүдийн доод талд болхидуухан тахиралдуулан хагас дутуу дүрсэлсэн зэрэгцээ хоёр гурви байгаа нь үл ялиг мэдэгдэнэ.

Дээрх хавтан чулуун нилээд муудсан байна. Түүний зүүн дээд булангийн том хэсэг эрт үед хагарч үгүй болсон болотой, харин зүүн доод булангаас хагарсан хэсэг хамт байгааг эвлүүлж үзэхэд эвээрээ нийлж байв. Нутгийн уугуул Л.Доржпүрэв гуай "... энэ хавтан чулууг Их засаг их сургуулийн захирал Ням-Осор амралтын газар руугаа ачиж явахаар нь би араас нь очиж буцаан авчирсан юм. Тэгээд машинаас буулгах явцад хавтан чулууны энэ



Зураг 4.3-3 Гүн бүрдийн тахилын хавтан чулуу №1 /гар болон фото зураг/

**Тахилгын хавтан чулуу №2:** 190 см урт, 146 см өргөн, 22 см зузаан тэгш өнцөгт хэлбэртэй. 1-р хавтан чулууны урд хүн чулууны зүүн талд газарт налж унаад хагас булагдсан байдалтай байхад нь бид ил гарган, тодорхойлолт хийж, гар зураг үйлдсэн юм. Энэ хавтан чулуунд дүрслэгдсэн хээ дээрх хавтан чулуутай адил ажээ. Хавтан чулуу №2 зүүн доод булангаас бага зэрэг хагарсан. Он цагийн уртад хээнүүдийн зарим хэсэг ихэд бүдгэрсэн нь харахад бэрх болжээ. (зураг 4.3-4).



Зураг 4.3-4 Гүн бүрдийн тахилын хавтан чулуу №2 /гар болон фото зураг/

**Тахилгын хавтан чулуу №3.** 210 см урт, 150 см өргөн, 21 см зузаан, тэгш өнцөгт хэлбэртэй. Дээрх хоёр хавтан чулууны зүүн талд газрын гадарга дээр ил гарсан байдалтай хэвтэж байв. Хавтан дээр сийлсэн хээний үндсэн зохиомж өмнөх хоёр хавтан дээрх хээтэй ижил боловч гагцхүү хээнүүдийг товойлгон гаргаж дүрсэлснээрээ ялгаатай агаад ихээхэн хөдөлмөр зарж үйлдсэн нь тодорхой харагдана.

<sup>1</sup> Ж.Баярсайхан, С.Энхболд, Д.Шинэсаран. Монголын Үндэсний Музейн Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын нутагт хийсэн археологийн судалгааны тайлан. УБ., 2011.

Хавтан чулууны ирмэгүүд бага зэрэг эмтэрч хагарсан, мөн хавтан чулуу дунд хэсгээр хагас ташуу цуурч, цав гарсан. Нутгийн өндөр настан Л.Доржпүрэв гуайн хэлснээр Их засаг их сургуулийн захирал Л.Ням-Осор амралтын баазаасаа бууцааж авч ирж байрлуулсан гэх боловч анхны байрлалыг нь яг хэлж мэдэхгүй байна, ямар ч байсан энд байгаагүй гэх ажээ<sup>5</sup> (зураг 4.3-5). Ийнхүү түүхийн дурсгалыг анхны байрлалаас нь хөдөлгөж, хараа хяналтгүй болгох зэрэг зүй бус үйлдэл гарсаар буйг хууль хяналтын байгууллагууд анхааралдаа авах буйзаа.



*Зураг 4.3-5 Гүн бүрдийн тахилын хавтан чулуу №3 /гар болон фото зураг/*

### **Гүнбүрдийн тахилын онгонд хийсэн сорилын малтлага**

2018 онд Гүн бүрдийн Түрэгийн тахилын онгоныг **GB-1** хэмээн дугаарлан малтлага судалгааны ажлыг эхлүүлэв. 2017 онд Тахилын онгоны байгууламжийг тойруулан, геофизикийн дохио өгсөн зарим газрыг багтаан 40x26 метрийн хэмжээтэй төмөр хашаа барьжээ. Гүн бүрдийн дурсгалт газар нь тоногдож, сүйтгэгдсэн бололтой анхны байрлалаасаа хөдөлсөн нэг хүн чулуу, гурван тахилын хавтан чулуу, барилгын материал, ваар савны хагархайд хучигдсан бага зэрэг овгор дэрстэй хэсэг зэрэг газрын өнгөн хөрсөн дээр мэдэгдэнэ.

Бид дурсгалт газрын баруунаас зүүн тийш 42 метр, хойноос урагш 28 метр талбайд 2x2 метрийн хэмжээтэй 21 өрөг үүсгэн латин үсгээр А-У хүртэл дугаарлан, уртрагийн дагуу мөн адил 2 харьцах 2 метрийн хэмжээтэй 14 талбай үүсгэн 1-14 хүртэл дугаарлаж, нийт 2 м<sup>2</sup> хэмжээтэй 294 өрөг бүхий талбайд ажиллахаар болов. Нийт талбай тэгш бөгөөд баруунаас зүүн тийш 50 орчим см налуу газар юм.

Гүн бүрдийн тахилын онгоны зүүн хэсэгт дэрс ургасан ялимгүй өндөрлөг газар ялгарч харагдана. Тухайн хэсэгт барилгын дээврийн ваарны жижиг хагархай бороо орсны дараа цөөн тоогоор олдох бөгөөд бид тухайн хэсэгт сорилтын малтлага хийж шалгав. 2018 онд бид сорилтын малтлагыг N3-

N14, K10-S10 хүртэл талбайнд газрын хэвгий болон шороон далан орсон өргөөс шалтгаалан 2-20 см гүн явуулав. Бид тахилгын онгоны гол хэсэгт байрлах чулуун хавтанг дайруулан хойноос урагш (N3-N14) 50 см өргөнтэй, баруунаас зүүн тийш (B9-T9 эгнээний хойд ханад (K10-S10) 50 см өргөнтэй хамрыг тус тус үлдээж малтлагын ажлыг эхлүүлэв. Малтлагын талбай төв хэсэгтээ өндөр. N3 талбайд 5 см, N4 талбайд 5 см, N5 талбайд 5 см, N6 талбайд 7 см, N7 талбайд 12 см, N8 талбайд 15 см, N9 талбайд 19 см, N10 талбайд 18 см, N11 талбайд 15 см, N12 талбайд 5 см, N13 талбайд 5 см, N14 талбайд 4 см, K10 талбайд 3 см, L10 талбайд 10 см, M10 талбайд 12 см, O10 талбайд 18 см, P10 талбайд 12 см, R 10 талбайд 8 см, S10 талбайд 10 см гүнтэй малтаж шалгав.

Малтлагын эхний үед O10 талбайгаас 21 ширхэг дээврийн тосгуур ваарны хагархай, N10 талбайгаас 11 ширхэг дээврийн тосгуур болон нөмрөг ваарны хагархай, P10 талбайгаас 2 ширхэг нүүр ваарны хагархай, N6 талбайгаас 4 ширхэг нүүр ваарны хагархай, харин бусад талбайгаас жижиг хэмжээтэй дээврийн тосгуур, нөмрөг ваарны хагархайнууд илэрч олдсон юм. Тухайн талбайнуудад орчин үеийн өнгөн хөрснөөс доош 30-40 см гүн малтахад L10, M10, N10, O10, N7-N11 талбайгаас дээврийн тосгуур, нөмрөг ваарны хагархай хэсгүүд их хэмжээгээр олдов. Бид өнгөн хөрснөөс доош 60 см гүн, 50 см өргөн малтлага хийж, зүсэлтийн зураг хийсний дараа талбайг гялгар уутаар бүтээж, гаргасан шороогоор эргүүлэн булсан байжээ.

Бид цаг хугацааны давчуу байдлаас шалтгаалан сорилтын малтлагаыг үргэлжлүүлэн хийлээ. Сорилтын малтлагыг өмнө жил малтсан талбайдыг үргэлжлүүлэн өргөрөгийн дагуу A9-S9 хүртэл талбайд хойд хэсэгт 50 см өргөнтэй хамар үлдээн 150 см өргөн, 38 м хэмжээтэй 20 см гүн сорилтын малтлагыг хийхэд бор хар хөрс үргэлжлэн гарч байсан тул талбайн хойд хамрыг дагуулан 50 см өргөнтэй талбайд байгалын хөрсийг хөөж гарган малтлагыг үргэлжлүүлэв. Уртрагийн дагуу O2-2-013 хүртэл талбайд баруун хэсэгт 50 см өргөнтэй хамар үлдээн 150 см өргөн, 24 м хэмжээтэй 20 см гүн сорилтын малтлагыг хийхэд бор хар хөрс үргэлжлэн гарч байсан тул талбайн хойд хамрыг дагуулан 50 өргөнтэй талбайд байгалын хөрсийг хөөж гарган малтлагыг үргэлжлүүлэв. Сорилтын малтлагын үр дүнд гүн бүрдийн тахилын онгоны зарим бүтэц тодорхой болов.

Гүн бүрдийн тахилын онгон нь 41x32 м орчим хэмжээтэй, 2 м орчим өргөнтэй, хоёр тийш 3.7 м налж унасан 10 см зузаан намхан шороон бололтой далантай, түүний дотор талд 32 м урт, 16 м өргөнтэй тэгш өнцөгт хэлбэртэй шуудуу суваг мэдэгдэв. Суваг доош нарийссан трапец хэлбэртэй. Сувгийн хойд хэсэг малтлагын талбайн O4-O5 талбайн баруун зүүн хананд сувгийн ул мөр болох бор хар хөрсөөр байгалийн хатуу цагаан хөрснөөс ялгарч мэдэгдэнэ. Суваг дээд хэсэгтээ 250 см өргөн, дунд хэсэгтээ 100 см гүнд 100

см орчим өргөн, ёроолдоо 170 см гүнд 50 см өргөнтэй байлаа. Малтлагын үеэр 65 см гүнд адууны дээд эрүүний ясны хугархай яс, 135 см гүнд бог малын бололтой сүүжний яс 1 ширхэг олдсон бөгөөд баруун талын ханад бог малын амьтны урт яс цухуйсан байдалтай олдсон тул О4 талбайд 140 см гүн малтаж шалгахад толгойг чанх хойд зүг хандуулан, нүүрийг баруун тийш тавьсан байдалтай бог малын яс анатомийн байрлалаараа олдов. Бид талбайг 215 см гүн хүртэл малтаж шалгахад байгалийн хөрс үргэлжлэн гарч байлаа.

Сувгийн баруун хэсэг малтлагын талбайн С9-D9 талбайг хамран гарсан бөгөөд бор хар хөрсөөр байгалийн хатуу цагаан хөрснөөс ялгарч мэдэгдэнэ. Сувгийн дээд хэсэг 2.3 м өргөн, 70 см гүнд 2 м өргөн, ёроолдоо буюу 150 см гүнд 50 см өргөн байлаа. Сувгийн ёроолоос 130 см гүнд адууны дагзны яс олдов. Сувгийн өмнөд хэсэг малтлагын талбайн О10-О11 талбайд бор хар хөрсөөр байгалийн хатуу цагана хөрснөөс ялгарч танигдана. Суваг дээд хэсэгтээ 2.6 м өргөн, 1 м гүнд 1.7 м өргөн, ёроолдоо буюу 195 см гүнд 90 см өргөнтэй. Сувгийн зүүн хэсэг Q9-R9 талбайг хамарч мэдэгдлээ. Суваг дээд хэсэгтээ 2.4 м өргөн, 1 м гүнд 1.3 м өргөн, ёроолдоо буюу 140 см гүнд 60 см өргөнтэй байв. Сувгийн сорилтын малтлагаас 120 см гүнд 1 ширхэг барилгын тоосго, 136 см гүнд адууны эрүүний яс олдов.

Малтлагын явцад талбайн төв хэсэг буюу G5, G6, H5, H6 талбайд малтлага хийж өнгөн хөрсийг 10 см гүнтэй хуулан авахад элсэрхэг бор хөрс гарсан бөгөөд H5, H6 талбайн огтлолцол дээр тахилын хавтан чулууны хугархай хэсэг олдов. Тахилын хавтан чулуун дээр ямар нэгэн хээ сийлбэр байхгүй цулгай бөгөөд 1.5x1.3 м орчим хэмжээтэй. Талбайн төв хэсэгт 20 см-ийн өргөнтэй хамар үлдээн малтлагыг үргэлжлүүлэн 20 см гүн болоход тахилын хавтан чулууны хугарч унасан жижиг хэсгүүд болон G6-аас H6 талбайд баруунаа зүүн тийш эгнүүлэн өрж тавьсан хүрмэн чулуунууд олдсон юм. Малтлагын үеэр элсэрхэг, хайргатай хөрс гарч байлаа. Мөн H6 талбайн урд хэсэгт 180 см орчим голчтой дугуй хэлбэртэй элсэрхэг шаргал хөрсний толбоны хойд хэсэг мэдэгдлээ.

Цаг хугацааны байдлаас шалтгаалан тахилын онгоны зүүн хэсэгт сорилтын малтлагын баруун хэсэг буюу L6, L7, L8, M6, M7, M8 талбайг бүтэн хэмжээгээр, N6, N7, N8 талбайн зүүн талд 50 см өргөн хамар үлдээн малтлагыг эхлүүлэв. Малтлагын үр дүнд L6 талбайд 10 см гүнд элсэрхэг шаргал хөрс, L7 талбайд 10 см гүнд дагтаршуулсан цагаан шороо болон дээврийн тосгуур, нөмрөг ваарны хагархай хэсэг 62 ширхэг олдов. L8 талбайд 10 см гүнд дагтаршуулсан цагаан шороо үргэлжлэн гарсан бөгөөд шар өнгөтэй тоосгоны хагархай 2 ширхэг, дээврийн нүүр ваарны хагархай 3 ширхэг, дээврийн нөмрөг болон тосгуур ваарны хагархай 200 ширхэг, шатсан яс 1 ширхэг олдсоноос гадна төв хэсэгт бага зэрэг галын ором мэдэгдэж байлаа. Мөн тус талбайн баруун болон урд хэсэгт элсэрхэг бор

хөрс ялгарч гарсан байлаа. М6 талбайд 10 см гүн малтахад эргэн тойрны элсэрхэг бор хөрс гарсан бөгөөд 25 ширхэг дээврийн нөмрөг болон тосгуур ваарны хагархай олдов. М7 талбайд 10 см гүн малтахад зэргэлдээ талбайгаас гарч байсан дагтаршуулсан цагаан шороо үргэлжлэн гарсан юм. М8 талбайд 18 см гүн малтахад элсэрхэг бор хөрс гарч, 30 ширхэг дээврийн ваарны хагархай хэсэг олдов. N6 талбайд 15 см гүнд дагтаршуулсан цагаан хөрс гарсан бөгөөд амьтны ясны хугархай 1 ширхэг, дээврийн нүүр ваарны хагархай 1 ширхэг, тоосгоны хагархай 1 ширхэг, дээврийн тосгуур болон нөмрөг ваарны хагархай 102 ширхэг олдлоо. N7 талбайд 20 см гүн малтахад дагтаршуулсан цагаан хөрс үргэлжлэн гарч 85 ширхэг дээврийн ваарны хагархай олдов.


Сорилтын малтлагын зүүн талд тахилын онгоны үүд байх боломжтой хэсэгт малтлагыг үргэлжлүүлэв. Тухайн хэсэгт малтлагын талбайн P6, P7, P8, Q6, Q7, R6, R7, R8, S6, S7 талбайнууд хамарсан бөгөөд газрын хэвгийгээс шалтгаалан 10-15 см өнгөн хөрсийг хуулан авахад зөөлөн бор хөрс нийт талбайд гарлаа. Малтлагыг цааш P6, P7, P8 талбайнуудад явуулсан бөгөөд P6 талбайд 13 см гүнд дээврийн нүүр болон нөмрөг ваарны хагархай 55 ширхэг, P7 талбайд 25 см гүнд дээврийн нүүр болон нөмрөг ваарны хагархай 219 ширхэг, P8 талбайд 31 см гүнд дээврийн нүүр болон нөмрөг ваарны хагархай 182 ширхэг тус тус олдов.

Мөн талбайн зүүн урд хэсэгт P11, P12, P13, Q11, Q12, Q13, R11, R12, R13, S11, S12, S13, T11, T13 талбайд өнгөн хөрсний цэвэрлэгээг газрын хэвгийгээс шалтгаалан 5-15 см гүнд хийв. Өнгөн хөрсний цэвэрлэгээний явцад P13 талбайн урд хэсэгт 8 см гүнээс 183 ширхэг дээврийн ваарны хагархай, Q13 талбайн урд хэсэгт 11 см гүнээс 34 ширхэг дээврийг ваарны хагархай олдов. Мөн тахилын онгоны шороон далангийн дагтаршсан цагаан хөрс T11, S12, R12, R13, P13, Q13 талбайд 2 м орчим өргөнтэй зөөлөн бор хөрснөөс ялгарч харагдана. Мөн сорилын малтлагын баруун урд хэсэгт L10, L11, L12, L13, M10, M11, M12, M13 N10, N11, N12 талбайд өнгөн хөрсний цэвэрлэгээ хийж газрын хэвгийгээс шалтгаалан 5-15 см гүн малтав. Малтахдаа сорилтын малтлага дагуух хананд 50 см хэмжээтэй хамар үлдээв. Малтлагын үр дүнд зөөлөн бор хөрс гарсан бөгөөд L12, M12, N12 талбайд шороон далангийн дагтаршсан цагаан хөрс мэдэгдэж байлаа. Малтлагын үр дүнд N10 талбайгаас 14 см гүнд 40 ширхэг дээврийн ваарны хагархай, N12 талбайд 8 см гүнд 10 ширхэг дээврийн ваарны хагархай, M10 талбайд 15 см гүнд 19 ширхэг дээврийн ваарны хагархай, M13 талбайд 8 см гүнд 22 ширхэг дээврийн нүүр ваарны хагархай гарлаа. Бид тухайн малтсан талбайнуудын малтлагыг зогсоож гаргасан шороог шуудайнд хийж, малтсан талбайн шал, ханыг хулдаасаар хамгаалан дотор нь шуудайтай шороо хийж, ирэх жил малтахаар төлөвлөн буллагааны ажлыг гүйцэтгэв.

### ХАВСРАЛТ




*2019 оны судалгааны багийн бүрэлдэхүүн*




*Гүн бүрдийн тахилын онгоны гурван хэмжээст зураг /3D/*



*Гүн бүрдийн дурсгалт газрын хоёр хэмжээст /2D агаарын зураг*



*Гүн бүрдийн дурсгалт газрын өндөршилийн зураг*



*Гүн бүрдийн дурсгалт газрын  
план зураг*



*Гүн бүрдийн дурсгалт газрын  
ургамалжилтын зураг*



*Гүн бүрдийн дурсгалын хаяалбар зураг*



*Зураг Гүн бүрдийн дурсгалын байршил зүй, хаяалбар, план зураг*



*Гүн бүрдийн тахилын онгон /дээрээс/*



*Гүн бүрдийн тахилын хавтангууд /  
дээрээс/*



*Сорилын малтлага 1-р үе  
/Агаарын зураг/*



*Сорилын малтлага 1-р үе  
/Өмнө талаас/*



*Сорилын малтлага 2-р үе  
/Агаарын зураг/*



*Сорилын малтлага 2-р үе  
/Агаарын зураг/*




*Сорилын малтлагаас илэрч буй дээврийн ваарны хагархай*



*Дурсгалыг 2018 онд буцаан булсан байдал*



*Дээврийн нүүр ваарны хагархай*



*Дээврийн нүүр ваарны хагархай /гар зураг/*



*Гүн бүрдийн 1-р хүн чулууны гурван хэмжээст /3D/ зургууд*



*Маллагын өмнөх байдал*



*Өмнө жилийн малтсан талбайг гаргасан байдал*



*Өмнө жилийн малтсан талбайг гаргасан байдал /Урд талаас/*



*Өнгөн хөрсний цэвэрлэгээний үеэр*



*Талбайн төв хэсэгт өнгөн хөрсийг хуулж авсан байдал*



*Сорилын малтлагыг хийх талбайн өнгөн хөрсийг хуулж авсан байдал*



*Сорилын малтлагыг хийж дуусгасан байдал /Зүүн талаас/*



*Сорилын малтлагыг хийж дуусгасан байдал /Дээд талаас/*



*Тахлын онгоны довжоо хэсгийг малтаж гаргасан нь*



*Тахилын онгоны төв хэсэгт хийсэн малтлага*



*2019 оны малтлага*



*2019 оны маллага зүүн талаас*



*Маллагын талбай*



*О4 талбай, сувгийн ёроолоос олдсон бог мал*



*О4 талбай, адууны эрүүний хугархай*



*Q9 талбай, адууны эрүүний яс сувгийн ёроолоос олдож байгаа нь*



*S3 талбай, сувгийн ёроолоос адууны дагзны яс олдож байгаа нь*



*Зүүн талын сувгийн толбо*



*Дээврийн нүүр ваарны хагархай*



*Дээврийн тосгуур ваарны хагархай*



*Тоосго болон дээврийн ваарны хагархай олдсон байдал*



*Дээврийн нөмрөг ваар олдож байгаа нь*



*Гаргасан шороог булсан байдал*



*Булсан байдал /Зүүн талаас/*



*Маллагын үеэр*



*Өнгөн хөрсний цэвэрлэгээний явц*

## УРЬДЧИЛСАН ДҮГНЭЛТ

Монголын Үндэсний Музей – Олон улсын Түрэг Академитай хамтран гурав дахь жилдээ үргэлжлүүлж буй “Хэрлэн” төслийн 2019 худагт явуулсан судалгааны үр дүнд түүний зохион байгуулалт хийгээд тахилын зан үйлийн зарим онцлогийг тодрууллаа. Энэхүү тахилын онгон нь Түрэгийн үеийн тахилын онгонуудтай зарим талаар төстэй боловч мөн тахилын онгоны судалгаанд шинэ хэрэглэгдэхүүн бий болгож байна. 50 см-ийн өргөнтэй сорилын малтлагын үр дүнд адууны толгойгоор тахилын зан үйл үйлдсэн нь ихээхэн өвөрмөц бөгөөд тухайн үеийн адууны биеийн өсөлт, хөгжилт, уналга эдэлгээний шинж тэмдэгийг судлахаас гадна тахилгын зан үйлийг тодруулан судлах хэрэглэгдэхүүн болно. Түүнчлэн тахилын онгоноос илэрч олдож буй малын ясанд палеозоологийн судалгаа явуулж, ямар малын аль хэсгээр тахилга өргөснийг тогтоохоос гадна он цаг тогтоох C14-ийн дээж хэрэглэгдэхүүн хангалттай хуримтлуулав.

Уг дурсгал газрын өнгөн хөрсөн дээр гурван тахилын хавтан чулуу, 1 хүн чулуу бүхий цогцолбор тахилын онгон бөгөө зүүн талд овгор дэрстэй хэсгээр танигдана.

Сорилтын малтлагын үр дүнд 2-3,7 м өргөн 41х32 м хэмжээтэй тэгш өнцөгт хэлбэрийн шороон далантай, түүний дотор 32х16 м хэмжээтэй тэгш өнцөгт хэлбэртэй, дотогш огцом нарийссан трапец хэлбэртэй, дээд хэсэгтээ 2.5 орчим метр өргөн, ёроолдоо 0.5 м орчим өргөн, 1.5-2 м орчим гүн сувагтай, түүний дотор талд 25.4 м тахилын хэсэгтэй, зүүн хэсэгтээ үүдтэй, үүдний дотор талд 8.5х5.4 м орчим хэмжээтэй довжоо бүхий вааран дээвэртэй сүмийн барилгатай тахилын онгон болох нь урьдчилсан байдлаар тогтоогдов.

Малтлагын үр дүнд бог малын бүтэн араг яс 1 ширхэг, адууны эрүү 2 ширхэг, адууны дагзны яс 1 ширхэг, дээврийн нүүр ваарны хагархай 5 ширхэг олдов. Цаашид малтлага судалгааг үргэлжлүүлэн бүтэн хэмжээгээр малтахад олдвор хэрэглэгдэхүүний олборлолтын хувьд ахиц дэвшил гарах магадлалтай.

Гүн бүрдийн тахилын онгон нь зүүн бүс нутгийн Түрэгийн үеийн тахилын онгон дотор томоохонд тооцогдох дурсгал бөгөөд ангилалын хувьд Түрэгийн язгууртны тахилын онгон байх бололцоотой юм. Язгууртны тахилын онгоныг үйлдэхдээ хавтан чулууг өнгөлж засаад ургамал, амьтан болон геометр дүрст хээ угалз товойлгон сийлж газарт хайрцаглан суулгаж хашлага” хийгээд зүүн талд нь нэлээд бодитой уран хийцтэй хүн чулуу босгох ба хүн чулууны өмнөөс дорно зүг цуварсан “балбалын” тоо дээрхээс илүү олон байна. Эдгээр байгууламжийг тойрон хүрээлсэн шавар шороон хэрэм, усны шуудуу, зарим тохиолдолд мод буюу тоосгоор барьсан тахилын сүмийн үлдэгдэл ч тохиолддог. Дурдсан хэлбэрийн тахилын онгон Монгол нутагт нэн олон тоотой байхаас гадна түрэгүүдийн нутаглан сууж байсан Евразийн бусад нутгуудаас

ч олддог байна. Язгууртны тахилын ийм байгууламжийг том хэмжээтэйгээр, нарийн зохион байгуулалт, төлөвлөлтийн дагуу олон бүрдэл хэсэгтэйгээр цогцлоон байгуулдаг байжээ. Эдгээрийн онцлог нь тахилын сүм байгуулж, шавар хэрэм, усан сувгаар хүрээлсэн, тахилга үйлдэхэд зориулсан хээтэй чулуун "хашлага" буюу тахилын дөрвөлжин чулуу байна. Мөн сүмийг тойруулан хэрмийн доторхи бүх талбайг тоосгоор шалласан байхаас гадна эзэн ноён болон түүний хатны хөрөг дүрсийг чулуугаар урлан хийж сүмийн дотор байрлуулдаг. Шадар дагалт хүмүүсийн хөрөг дүрсийг мөн үйлдэж сүмийн өмнөх талбайд эрэмбэ дараалалтай байрлуулан хэрмийн орох хаалгын хоёр хатавчинд чулуун хонь буюу арслангийн хос дүрсийг тавина. Хэрмийн хаалгын дотор талд яст мэлхий хэлбэртэй буюу жирийн чулуун сууринд суулгасан бичигт хөшөөг байрлуулах бөгөөд байгууламжийн үүднээс дорно зүгт цувуулж тавьсан "балбал" чулууг босгодог зэрэг үндсэн шинжүүд бий.

Томоохон тахилын онгоны байгууламжийн тоонд Хөшөө Цайдам дахь Билгэ хаан болон Куль-Тегин, Налайх дахь Тоньюкук, Төв аймгийн Дэлгэрхаан сумын нутаг Их Хөшөөт, Алтанбулаг сумын нутаг Өнгөт, Өвөрхангай аймгийн Уянга сумын нутагт буй Онгийн гол, Хануй Хүнүй голуудын бэлчир дэх Шивээт Улаан, Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Донгойн ширээ зэрэг дурсгалууд ордог.

#### Номзүй:

Ж.Баярсайхан, С.Энхболд, Д.Шинэсаран. Монголын Үндэсний Музейн Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын нутагт хийсэн археологийн судалгааны тайлан. -Улаанбаатар, 2011. -85.

#### References:

J.Bayarsaikhan, S.Enkhbold, D.Shinesaran. Mongolyn Ündesnii Muzyein Khentii aimgiin Delgerkhaan sumyn nutagt khiisen arkhyeologiin sudalgaany tailan. -Ulaanbaatar, 2011. -85.

**МРНТИ 03.41****УДК 902.2****Мөнхтулга Р.**

Монгол улсын ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн  
эрдэм шинжилгээний ажилтан, доктор,  
mongkari@gmail.com

**БИЛГЭ ХААНЫ ОНГОНЫ ХАВТАНТ ХАШЛАГА ХЭНИЙХ ВЭ?**

2001 онд Монгол-Туркийн хамтарсан шинжилгээний анги Архангай аймгийн Хашаат сумын нутаг дахь Билгэ хааны онгоны тураас, гадна талдаа цэцэг хээ бүхий дөрвөн чулуун хавтанг босгон байгуулсан хашлага илрүүлсэн юм. Уг хашлагыг чухам хэнд зориулан хэн, хэзээ босгосныг мөшгөн тодруулахыг хичээснийхээ үр дүнг энэ удаа товчийн төдий толилуулахыг зорилоо.

Мөн үед холбогдох археологийн болон бичгийн сурвалжийн баримтад тулгуурлан, Билгэ хааны онгоноос илрүүлсэн хашлагыг түүний хүү И-рань хаанд зориулан Тэнгри хаан 735 онд байгуулсан хэмээх саналыг дэвшүүлж байна.

**Түлхүүр үг:** Билгэ хааны тахилын онгон, Тэнгри хаан, И-рань хаан, Эртний Түрэгийн хавтант хашлага

**ҮТАМР 03.41****ЭОЖ 902.2****Мөнхтулга Р.**

Моңғолия Ғылым академиясы Археология институтының  
ғылыми қызметкері, доктор  
mongkari@gmail.com

**БІЛГЕ ҚАҒАН ҒҰРЫПТЫҚ КЕШЕНІ БАРЫҚ  
ҚАПТАЛЫ КІМДІКІ ?**

2001 жылы Моңғолия-Түркия бірлескен зерттеу тобы Архангай аймағының Хашаат сұмынындағы Білге қаған ғұрыптық кешені алаңынан сырты гүл өрнегі бар төрт тастан тұрғызылған қаптал орнын тапты. Мақала мақсаты - аталмыш төрт қапталды барық кімге және қашан тұрғызылғанын анықтау бойынша қысқаша баяндалды.

Сонымен бірге, тиісті археологиялық және жазбаша деректерге сүйене отырып, Білге қаған ғұрыптық кешені жаңадан табылған төртбұрыш қап-

талды барық оның ұлы И-рань қағанға арнап Тәңір қаған 735 жылы салған деген ұсыныс жасалды.

**Түйін сөздер:** Білге қаған ғұрыптық кешен, Тәңір қаған, И-рань қаған, көне түрк барық қапталы

IRSTI 03.41

UDC 902.2

**Munkhtulga R.**

PhD, Research Fellow, Institute of Archeology,  
Academy of Sciences of Mongolia, mongkari@gmail.com

## AN ENCLOSURE AT THE BILGE KHAGAN'S MEMORIAL COMPLEX: WHOSE IS IT?

Монголын түүхэнд Шивэй хэмээх аймгийн нэр VI-XII зууны мэдээ баримттай холбоотойгоор гардаг. Судалгааны бүтээлээс харахад уг нэрийг зүүсэн 30 шахам аймаг байна хэмээн үздэг. Мэнгү Шивэй аймаг болон бас бус Шивэй аймгуудыг монгол хэлт аймаг байсан хэмээн үздэг. Зарим аймгуудын түүхэн газар зүйн байрлалаар нь Манж-Түнгүс хэлтэн байсан гэх мэтээр судалгааны талбарт маргасаар өнөөдрийг хүрсэн байдаг.

Эдгээр олон аймгууд чухам яагаад Шивэй нэрийн дор бүгдийг нь хамруулах болов. Угсаа гарвалын хамаадал хоорондоо байна уу эсвэл тэдний байгаль орчны ижил төстэй байдлаас болж ийнхүү нэрлэв үү. Шивэй аймгуудын талаарх сурвалжийн мэдээнд зарим Шивэй нар хоорондоо хэл ус нэвтрэлцэхгүй хэмээн тэмдэглэсэн байдаг. Судлаачид Шивэй хэмээх үгийн талаар хийсэн судалгааны тоймыг юун түрүүнд авч үзэх шаардлагатай хэмээн үзлээ.

Судлаачид Шивэй бол Сяньби-гийн хойч хэмээн үздэг бөгөөд тэд Шивэй хэмээх үгийг сэргээхдээ Сяньби-гийн нэртэй холбон “Serbi, Sirbi, Sirui” гэх мэтээр сэргээн уншдаг бөгөөд судлаачдын дунд нилээд түгээмэл хэрэглэгддэг. Судлаач Б.Батсүрэн Сяньби-гийн Сэрби хэмээх сэргээлтийг илт дэмжиж өөрийн бүтээлдээ Сяньби-Сэрби хэмээсэн байдаг бөгөөд Шивэй, Сяньби-гийн судлаачдын ерөнхий үзлийг дэлгэрэнгүй дурдсан байдаг [Батсүрэн: 2016] тул дахин нуршилгүй орхисон болно. Түүхч Г.Сүхбаатар сяньби, тоба нар тав гээгтэй монгол хэлний serbeg (сэрвэгэр, модны салаа саглагар, сэрвээ сэртэнг) арсгар барсгар зүйлтэй холбон тайлбарлаж сяньби нь монголын “шивээ, сүв” гэсэн үг байх магадтай гээд Сяньби-г Сүмбэ хэмээн сэргээсэн

байдаг [Сүхбаатар, 1971: 76-77]. Японы судлаач К.Ширатори Шивэй хэмээх үгийг монгол хэлний “Sera” ба “šara” буюу түрэг хэлний “Sari” хэмээгээд хойд талын Вэй хэмээх дуудлагыг “Kha” хэмээн сэргээж “Sarakha” буюу Шар ус өнөөгийн Өвөр Монголын нутаг дахь (Xila mulun he) буюу Шар мөрөн гол хэмээн сэргээсэн байдаг. Бидний үзэж буйгаар Шивэй олон аймгийн нутаг ус зөвхөн Шар мөрнөөр хязгаарлагдахгүй тул уг сэргээлттэй санал нийлэхгүй байна. Энэхүү нэр арай нийтлэг олныг хамарсан нэр болов уу хэмээн таамаглаж байна. Мөн Сяньби хэмээх үгийг нилээд сонирхолтой тайлбарласан нэгэн жишээ байна. Хятадын судлаач И Тие Чао Сяньби хэмээх нэрийн тухайд хэмээх өгүүлэлдээ Сяньби бол Манж-Түнгүс хэлний үг байх ёстой гээд Сяньби гэдэг нь Бэлгэт амьтан буюу Чилин юм бол манж хэлэнд “Sabi” хэмээдэг. Хоёрт Ульчи хэлэнд “Sabi” гэдэг нь гутал мөн өлзий билэгт гэсэн утга агуулдаг. Мөн (saxej, sabe болон sav) мөн бусад ойролцоо хэлний үгс дунд адил дуудлагатай үгнүүдэд sarbu, sabu, sarkı, saq зэрэг нь Ульчи, Эвенки, Хэжэ, Шибө хэлэнд “Савх” хэмээх үг юм. Хэрвээ Sabi-гийн гийгүүлэгч адил эгшиг сэлгэхтэй холбож үзвэл Ульчи хэлний “Səbu” (багш), Хэжэ хэлэнд “сэрэ” (багш) хэмээх утгатай аж. Түнгүс хэлний билгэт, өлзийт хэмээх үгсийн санд Ульчи хэлний “rixı”, Хэжэ хэлний “agdənə”, Эвенки хэлний “dziggalan” болон Шибө хэлний “sayin” зэрэг хувилбарууд байна. Тиймээс билгэт гөрөөс буюу чилин хэмээн үзвэл “sabi” хэмээх хувилбар тохирохоор байна[朱学渊, 2000:75] үндэслэн Хятадын судлаач И Тие Чао (尹铁超) Сяньби-гийн “鲜” — “卑” би-д тайлбар хийж манж-түнгүс хэлний “бие” хэмээх үг байж болох юм гээд (bəjə, bəi, bei) буюу бие хүн Сянь-хүн хэмээх үг гэж үзэх санал дэвшүүлээд Сяньби уулын буюу “Билэгт уулын хүн” гэсэн “Xian bəiə” хэмээн үзсэн байна [尹铁超, 2008: 351].

Дээрх сэргээлтүүдээс харахад дийлэнх сэргээлт “S” үсгээр эхлэх бөгөөд хоёр юм уу гуравдугаар үед “B” үсэг заавал оролцсон манж-түнгүс юм уу монгол, эсвэл бусад хэлний үг байх шаардлагатай бололтой. Тиймээс Тал нутгийн өндөрлөг болон Хянганы уулс зэрэг зүүн хойд Ази болон хил залгаа хэлний баримтанд учиг тайлах үг байх нь дамжиггүй юм.

Тэдний аж ахуй, амьдралын хэв маягийн талаарх сурвалжид буй тэмдэглэлийг харьцуулан үзэхэд тэдний ялгаа, оршин байсан газрын байц зэрэг нилээд тодорхой харагддаг боловч аж ахуйн онцлог нилээд ойролцоо харагддаг. Бидэнд Шивэй нарыг аж ахуйн адил төстэйгээр нь нэрлэж байсан юм биш биз гэсэн нэгэн сэжиг байна.

Сурвалжид тэдний аж ахуй, амьдрал ахуйн талаар дурдсан байдлыг ажиглавал, Бэй ши-д “Нань шивэйгээс хойш 11 өдрийн замд Бэй шивэй байдаг. 9 аймагтай, Түгэ уулыг хүрээлэн нутагладаг. Ахлагчдыг Ци инь, Бага Чур (мохэ дуо) гэнэ. Аймаг болгон ахлагчийн туслах гурван Бага Бэг (мохэфу) бий. Уур амьсгал тэсгим хүйтэн, морь мал шигдээд далдрахуйц гүнзгий их цас унадаг. Өвөл болохоор хүмүүс нь ууланд газар нүхэн гэрт амьдардаг. Хүйтнээс болж цөөнгүй үхэр хөлдөж үхдэг. Гөрөөс буга элбэг тул тэднийг

авлаж амь зуудаг. Ангийн мах идэж арьсаар нь хувцасладаг. Мөс цоолон усанд орж тороор загас, дун шүүрддэг. Цас их унаж газрыг дарахаар нүхэнд унахаас сэргийлэн хавтгай нимгэн мод углаж явдаг. Бүгд булга агнаж чаддаг. Малгай үнэг булганы арьсаар, хувцас хунараа загасны арьсаар оёдог. Хойд зүг мянган газар явахад Хубу уулын дэргэд суух Бо шивэйд хүрнэ. Энэ аймаг Бэй шивэйгээс олон гэх боловч хэдэн овогтойг үл мэднэ. Хусны үйсээр орон гэр барьдаг, бусад нь Бэй шивэйтэй адил. Бо шивэйгээс баруун өмнө дөрвөн өдөр яваад голын нэрээр хочилдог Шэньмода шивэйд ирнэ. Өвлийн саруудад тэднийг хүйтнээс хамгаалдаг нүхэн сууцанд суудаг. Наран ээвэр байдаг. Түүнээс баруун хойш хэдэн мянган ли газарт Да шивэй бий. Хэл яриа адилгүй, онцгой сайн булга, хэрэм ихтэй” гэжээ.

Шивэй нарын гэр орон, унаа хөсөг, хувцас зүүсгэлийн талаар харьцуулан үзэхэд орон сууц, мал хөрөнгө, хэл яриа зэргийн ялгаа харагдах бөгөөд судлаачид арван гурван дэд сэдэвт ялгаж зарим нэгэн саналуудыг дэвшүүлсэн байдаг [Билэгт, 2004: 47-54]. Бидний ажиглаж буйгаар бүгд анчин хэмээх тодотгол нь адил байна. Тиймээс Шивэй нар анчин түүвэрлэгч, мал аж ахуй хосолсон байдал нь нилээд нийтлэг харагдаж байна. Мэдээж Шивэй гэдэг бол тэдэнтэй харьцаж байсан хэсэг бүлгийн өгсөн нэр тиймээс ямар хоч зүүж байсан байж болох вэ? гэсэн асуулт зүй ёсоор гарна. Тэдний аж ахуйн талаар дурдсан хэсэгт бүгд булга, хэрэм агнадаг хэмээн гарах юм. Тиймээс Монгол хэлний хэрэмчин, булгачин гэсэн эрхэлдэг аж ахуйгаар нь нэрлэсэн утга бүхий үг биш биз. Булга бол ерөнхий овгоороо суусрын төрлийн амьтан учир “Suwsar, Suusar” хэмээх үгтэй холбоотой юм биш биз.

Ойн иргэд буюу булгачин, суусарчингууд мал аж ахуйн болон суурин иргэдийн бараа бүтээгдэхүүний хэрэгцээ үргэлж байх нь тодорхой юм. Гэхдээ малчин нүүдэлчид ав хийдэггүй байсан гэж үзэж болохгүй. Нүүдэлчид намар үслэг ангийн арьс боловсроход одоо ч авд морддог бөгөөд тэд мал хуйгаа арвилах үүднээс авын хишгээр аж ахуйдаа нэмэр болгодог байсан нь тодорхой юм. Анчин ойн иргэд ч махны төлөө жилийн дөрвөн улирал ав хийж болох ч арьс үсийг нь үнэ хүргэж зарахад заавал намрын сүүлээс өвлийн саруудад л дагнан ав хийх боломжтой юм. Тиймээс тэд олон биш ч хонь, ямаатай байх боломжтой. Шивэйн талаар хятад хэл дээрх мэдээг хэн тэмдэглэж авсан бэ гэдэг нилээд сонирхолтой. Бидний үзэж буйгаар нэгт шивэй нартай худалдаа арилжаа хийж байсан худалдаачдаас, хоёрт: хил залгаа шивэй болон бусад аймгаас мэдээ авч тэмдэглэсэн байх магадлалтай. Шивэй аймгууд нийт хорь байж, хорин хоёр байж гэдэг үзэл бол сурвалжид тулгуурлан гаргасан тоо бөгөөд бодит түүхэн аймгуудын тоог бүрэн илтгэх мэдээ биш юм. Тэд хоорондоо ямар ялгаатай хэнтэй харилцдагыг нь л тэмдэглэж авахаас Сибирийн их ойг хүрээлэн бүчсэн аж ахуйн төстэй хэдэн зуун жижиг овог, аймаг байсныг тогтоох боломжгүй юм.

Монголын Нууц Товчоон-д (МНТ) булгачин, хэрэмчин хэмээх бүлгүүд тэмдэглэгдэх бөгөөд аж ахуйгаар нь аймаг бүлгийг хочлон нэрлэдэг бай-

сны баримт юм. Ер нь МНТ-д буй булгатай холбогдох баримтаас харахад нилээд тансаг эд байсныг нотлохуйц хэд хэдэн баримт байна. МНТ-ы §8: “... Баргужин гоо нэрт охиныг Хорь Түмэдийн ноён Хорилардай мэргэнд өгсөн ажээ. Хорь Түмэдийн газар Ариг уснаа Хорилардай мэргэний Баргажун гогоос төрсөн Алангоо нэрт охин тэр болно.” §9: “Хорилардай мэргэн Хорь Түмэдийн нутагтаа булга, хэрэм ан гөрөөст газраа хориглолдож муудалцаж Хорилар овогтон болжээ...” хэмээн Хорилар овогтон булга, хэрэмт газраа хамгаалан хориг тавьж муудалцаж нутаг сэлгэж буй тухай дурддаг. Энэ нь магадгүй нүүдэлчидтэй хамгийн ойр бүс нутаг болж намартаа аваар ирэгсэд ихсэж хоорондын зөрчил болж байсныг тэмдэглэсэн хэмээн үзэж байна. Мөн §96: зүйл “Сэнгүр горхиноос Хэрлэн мөрний эх Бүрги эрэгт нутаглан буув. Цотан эхийн бэлэг хэмээн хар булган дах авч ирсэн бөлгөө. ...” хэмээн чингис хаанд хар булган дах бэлэглэсэн талаар дурдаж буй бол уг дахаа Ван хаанд өргөхөд тэрээр баясан ийнхүү өгүүлсэн байдаг.

«Хар булган дахын [чинь] хариуд

Хагацсан улсыг чинь хамтатгаж өгсү

Булган дахын.[чинь] хариуд

Бутарсан улсыг чинь бүрэлдүүлж өгсүү ...

үүнээс харахад зүгээр булган дах өргөн барьж буй мэт боловч дах өргөн барихад улс цэргээ хөдөлгөхөө амлаж буй зэргээс харахад ихэд үнэтэй зүйл байсан нь ажиглагдах бөгөөд язгуурлаг нэгний хэрэгцээ байсныг илтгэх мэт. Гэхдээ Ван хаан ганцхан булган даханд аймаг цэргээ хөдөлгөж буй бус урьдын ачийг санаж ийнхүү туслахаа илтгэж буй гэлтэй. Гэхдээ уг булган дахыг үргэлж дурдаж сануулж буй нь нилээд үнэтэй эрхэм зүйл байсныг илтгэнэ. Мөн §97: Бурхан Халдунаас Урианхай иргэн Жарчудай өвгөн хөөргө үүрч, Зэлмэ нэрт хөвүүнээ дагуулж ирж Жарчиудай өгүүлрүүн: Ононы Дэлүүн болдогт бүхийд Тэмүүжинийг төрөхөд булган өлгий өгч билээ би... мөн Мэргэдийг дайлаар мордон бусниулж байхад... §114: “Удуйд мэргэдийн дүрвэсэн газар булган малгайт, марлын годон гуталт илгэн хөөмий, усны булган (халиу) хоёрыг зүйсэн дээлтэй таван настай Хүчү нэрт ...» хүүг олж Өүлэн эхэд өргүүлдэг бол Шихихутагыг олж авч буй хэсэгт §135: Татарын хороолсон Нарату шүтээнээ буусан нутгийг талахуйд нэгэн өчүүхэн хүүхэд гээснийг бидний цэргүүд нутгаас олжээ. Алтан ээмэг, дөрөвчит, булгаар доторлосон таж торгон элгэвчит, бяцхан хүүхдийг авчирч Чингис хаан, Өүлэн эхэд асруульа хэмээн өгөв. Өүлэн эх өгүүлрэн «сайн хүний хөвүүн ажгуу. Язгуур сайт хүний ураг буй за» таван хөвүүний зургадугаар хөвүүн болгон Шихихэн Хутугу хэмээн нэрийдэж асрав. [Цэрэнсодном, 2000] хэмээжээ Өүлэн эхийн өгүүлж буйгаар түүний хувцас эдлэлээс язгуурлаг нэгний хөвүүн болохыг түвэггүй мэдэж буй зэргээс харахад булга бол нилээд өндөр дээдийн бараа байсныг харж болно. Мөн Марко Поло-гийн тэмдэглэлд «Миний ярьж байгаа тэр нэгэн орд, хоёр танхимыг доорх маягаар барьжээ. Танхим тус бүр нь удган модыг сайхан засаж хийсэн гурван баганатай гадна талыг нь хар, цагаан, улаан судалтай халзтай туйлын гоё арслангийн арьсаар бүрсэн ба бороо салхинд

огт ажрахааргүй бат бөх аж. Бас хамгийн сайхан хамгийн үнэтэй булга, суусар үенгийн арьсаар доторложээ. Эрэгтэй хүний нэг дээлэнд орох сайн булганы арьс чухамдаа хоёр мянган бизант (зоос) хүрэх ба энгийн арьс бол мянган бизант болдог ажээ. Татарууд булганы арьсыг (хаан үс) гэх ба булга бол суусрын дайтай амьтан юм. ...Түүний дэргэдхэн байгаа их хааны нойрсох өргөө гадна талаасаа арслангийн арьсаар хучаастай, дотор талдаа мөн булга суусрын үстэй, бүгдийг цэмцийтэл зассан нь үнэхээр алдартай.» «Тэдний хувцас гэвэл: Баячууд нь алтан саатай магнаг торгоор хийж, өд ноолуур хийгээд булга, суусар, галт хар үнэг, үнэгний арьсаар доторлосон буюу эмжин хажсан дээл өмсөнө. Гоёл чимэглэл нь маш сайхан бөгөөд үнэ ихтэй».

Тэгвэл Зүүн хойд мужийн Ойн иргэд болон булга, суусрыг хэрхэн тэмдэглэдгийг хэлний баримтаас тодруулъя. Манж хэлэнд булга суусрыг «Seke» хэмээн дуудаг [傲拉-毕力格, 2016: 465-466]. Түнгүс хэлний баримт мөн л «Seke» хэмээдэг гэж толь бичиг зааж байна. Гэхдээ бид бүс нутгийн бүх толь бичгийг шүүрдэж үзэх шаардлагатай буюу Сибирь тойрсон якут, чуваш, монгол, манж-түнгүс тэргүүтэй алтай язгуурын бүх хэлний баримтуудыг харах шаардлагатай байна. Якут хэлэнд булга “säbra-säвра” хэмээх ажээ [Пекарский, 1916: 196]. Бидний таамагласан «sbr» хэмээх үгтэй бүтцийн хувьд бараг адил байна. Чуваш хэлэнд сасар, монгол хэл сасар, казак, киргиз хэлэнд сусар, алтай бүс нутагт сузар хэмээдэг бол дундад эртний монгол хэлэнд «subsar, suusar» хэмээж байна [Федотов, 1996: 33]. Эртний монгол хэлэнд субсар-булга гэсэн холбоо үгээр хэрэглэгдэж байсан бололтой байна. Чуваш хэлэнд Хура Сасар [Егоров, 1996: 184] хэмээн хар булгыг онцлон хэлж байгаа бололтой. Уг үгийг Алтай хэлний язгуурын толь бичгээс шүүн үзвэл «segu» жижиг үслэг ан, эртний түрэг хэлнээ «seger (ke)» эртний монгол хэлэнд «sowsar» манж хэлэнд «seke», зүрчин хэлэнд «ser-ke», дундад зууны солонгос хэлэнд «sepe» хэмээх хэлбэртэй байсан ажээ. Үүнээс харахад дундад зууны солонгос хэлэнд буй «сэпэ» нь бидний шивэй хэмээх үгийн уг үндсийг хадгалсан байх магадлал их өндөр байна. Мэдээж эртний түнгүс юм уу монгол хэлний олон зуун жилийн хэлний хөгжлийн явцад хуучрах ойр зэргэлдээ хэлний үгийг зээлэх зэрэг үзэгдэл элбэг байсан нь илэрхий учир хөрш зэргэлдээ хэлний үгсийн сангаас тохирох үгийг хайж буй билээ. Эвенк хэлний толь бичигт «seke» хэмээн манж үгтэй адилаар тэмдэглэгдсэн байна [杜鲁基尔-锡阿番等, 2010: 1110]. Гэвч толь бичгүүдэд тэр бүр оноосон нэрийг тэмдэглэдэггүй учир бид хятадын зүүн хойд мужийн эвенк, якут зэрэг анчин угсаатны домог үлгэрээс хайж үзье.

Тэдний үлгэр домогт өдөр тутмын аж ахуй, ан авын тухай зүйлд булгатай холбоотой нилээд сонин үлгэрүүд байна. Жишээ нь булга хэмээх үгийг Эвенки хэлэнд хэрхэн тэмдэглэдэг талаар угсаатны зүйн мэдээ байна.

Эвенкийн «Анчин ба бяцхан цагаан луу» (猎人和小白龙) хэмээх үлгэрт «...Мэргэн хэмээх анчин эр нэгэн өдөр авд явж байгаад нэгэн агуй руу цөмөрч ороод нэгэн цагаан хувцастай залуу хүлээтэй байхыг олдог. Түүнтэй танил-

цахад хар луу түүнийг олзлон агуйдаа авчирсан бөгөөд 2-3 хоногийн дараа түүнийг цаазлах гэж байжээ. Тиймээс уг цагаан хувцастай залуу амь аварсанд баярлан ах, дүү бололцоод нөгөөх цагаан хувцастай хүн цагаан луу болон хувирч анчныг суулган хөөрч, хар луутай тулалдахад мэргэн нум сумаараа хар лууны нэг нүдийг харваж энэ тулаанд ялалт байгуулсанд, цагаан луу хоёр дахь удаа амь аварлаа манайд очьё гээд тэнгэрийн оронд очдог. Очих үед цагаан луу манай аав чамайг маш ихээр шагнана Алт, мөнгөнөөс нь татгалзаад танай тэнд буй хар булгыг л авья гэж хэлээрэй хэмээн захьдаг. ... Тэгээд Луу хаан алт, эрдэнэс санал болгосон боловч тохирсон ёсоор хар булга л авч, түүнийгээ аваад харьдаг. Хар булга анчныг анд явсан хойгуур сайхан үзэсгэлэнтэй бүсгүй болон хувирч, хоол ундыг хийж өгдөг болов. Анчин эр хоёр дахь өдөр анд явж буй мэт болоод гадаа нуугдан харахад булга сайхан бүсгүй болон хувирч хоол хийж байх үед орж ирээд булганы арьсан хувцсыг нь шатаачихдаг. Үзэсгэлэнт бүсгүй чи арай яарлаа гурав хоног өнгөрсөн бол би үүрд чинийх болох байсан. Намайг удахгүй тэнгэрийн орон руу авахаар ирнэ...» [敖嫩, 2007: 75-111] Уг үлгэр бол еврази-д түгээмэл тарасан баатарлаг үлгэрийн нэгэн хувилбар юм. Уг үлгэрийн тэнгэрийн гүнжийн мотив нь хар булгаар илэрч буй бол европ зүгт энэхүү үлгэрийн гүнж мэлхийн арьсан хувцастай байдаг. Харин тал нутгийн нүүдэлчдийн хувилбарт буюу Хори Буриадын үүссэн домогт хун галуун хувцастайгаар дүрслэгддэг. Үүнээс харахад уг баатарлаг үлгэр нь тухайн бүс нутагт дэлгэрэхдээ голлох аж, ахуй эрхэм амьтдын дүрд мотив шилжиж буй зэрэг нь нилээд сонирхолтой юм. Уг үлгэр нь Дагуурын Тулар Эвенк тосгоны Аофүжин (敖福金) хэмээх 31 настай эр 1990-ээд онд ярьж өгсөн хувилбар юм. Судлаач Ао Нэн (敖嫩) тэмдэглэж авахдаа эвенкээр тэмдэглэн авсан бөгөөд уг тус бүрийг хятдаар хадсан байна. Гэхдээ уг үлгэрт гарч буй булга- sebeiwe-紫貂, булганы арьс-huring sebeiini nangda гэх үгсийг Өвөр Монголын Ардын хэвлэлийн хорооны Эвенк-Монгол толь бичигт булгыг манж хэлний «seke»-тэй адилаар тэмдэглэдэг хэмээн буусан нь эвенк хэлэнд дийлэнх нь булгыг манжаар хэлдэг учир толь бичигт ийнхүү орсон бололтой. Тус үг эртний энэ үлгэрт харин нилээд мартагдсан үг, хэлбэрээрээ буй нь ихэд олзуурхууштай. Магадгүй булга дотроо олон янз учир яг хар булгыг бас энэхүү «sebeiini» үгээр хэлж байж болох юм. «Шивэй» хэмээх нь булгачин гэсэн үг байж болоход нэг алхам дөхүүлсэн баримт бидэнд ийн олдлоо.

|   | Хэл    | Булга-суусар | Солонго  | Үен                  | Хэрэм  | Үнэг    |
|---|--------|--------------|----------|----------------------|--------|---------|
| 1 | Монгол | sowsar       | solongo  | Ц а г а а н<br>булга | herem  | hūnegen |
| 2 | Алтай  | segu         | solukV   |                      | guri   | p iune  |
| 3 | Якут   | sabra        | solongdo |                      |        |         |
| 4 | Эвенк  | sebeni       | soliyā/  |                      | gurnun | hineki  |

|    |                    |        |                   |                  |              |               |
|----|--------------------|--------|-------------------|------------------|--------------|---------------|
| 5  | Манж               | seke   | silixi / soloxi   | Sangiyan<br>seke | gurna        | pun           |
| 6  | Тунгус             | sege   | solonggo          |                  | gurma        | pun           |
| 7  | Ульч               | sēpe   |                   |                  |              | puntulce      |
| 8  | Чуваш              | sasar  |                   |                  |              |               |
| 9  | Хойд Со-<br>лонгос | sēpe   | solu              |                  | gorma-<br>go |               |
| 10 | Turkic             | sogur  | sialik            |                  |              | Enúk/<br>únek |
|    | Хятад              | 貂鼠     | 黄鼠狼               | 银鼠               | 青鼠           | 狐             |
|    | Орос               | Соболь | Колонок,<br>хорёк | горно-<br>стой   | белка        | пищуха        |
|    | Англи              | Sable  | weasel            | ermine           | squirril     |               |

Манжийн хааны арван сайн нохойн зургийг 1730-аад онд Италийн зураач Ж.Кастильоне зурсан байдаг. Бүх зурагт хаанахын хэнээс бэлгэнд ирсэн, дуудлага цол нь юу гэдгийг монгол, манж, хятад тэмдэглэсэн байдаг. Монгол дуудлагыг голдуу баримталсан бөгөөд хятад хэлээр тухайн нохойн зүс, цолын орчуулга нилээд өргөн утга агуулгатай бичигдсэн нь ажиглагдаж байна. Жишээ нь Монгол дуудлагад «Цэрвүү» хэмээсэн бол зарим бүтээлд (идэр, саарал луу) хэмээсэн байдаг. Арван сайн нохойн дунд «Булагтай-Сэбэртү»-г (цасан хумстай, том саварт хилэн хар) [Ганбат нар, 2019:45] гэж хятад утгыг баримталсан байна. Булагтай буюу Сэбэртү (雪爪卢) (бүх бие хар боловч дөрвөн сарвуу цасан цагаан) Зүүнгарын тайж Галданцэрэн (准噶尔台吉噶尔丹荣楞) өргөн барьжээ. Уг нохойн зүсэм нь булгатай адил гялалзсан хар үстэй нохой байна. Манж хэлэнд булгыг «Сэкэ» гэдэг гэтэл уг зүсмийн нохойг монголоор булагтай хэмээн бичээд манж хэлэнд Сэбэртү хэмээн буулгасан нь шууд орчуулга нь бол нь мэдээж юм. Манж хэлний толь бичгээс харахад Сибэри (Siberi) гэдгээр дөрвөн хөл цагаан хар морийг бас хэлж байна. Тэгэхээр булаг-сибэри нь монгол болон манжаар хар зүсмийн дөрвөн шийр алаг зүсмийг зааж буй үг бололтой байна. (зураг-1) Булаг түрэг хэлний bulgha, bulga- or bulya буюу алаг, холих гэсэн үг бол алаг-булаг хэмээх хар зүс голлосон алгийг илтгэж буй үг бололтой бөгөөд Сибэри-тэй холбон тайлбар хийхэд Хар булга дөрвөн хөл, хошуу цагаан байдагтай дөхөж булгыг зааж байж болохоор сонин тохиолдол хэлний баримтад байна. Эвенк хэлний булга хэмээх Сэбэйни нь манж хэлэнд хар алгийг заах үгээр орсон ч байж болох авиазүйн тохирол ажиглагдаж байна.

Булга ихтэй нутаг учир Булган хэмээх газрын нэрс үүссэн. Ховд аймгийн Булган голын булга Алтайн булга дотроо хар бараан зүстэй, сор сайтайд тооцогдож байжээ [Намнандорж: 1976. 119]. Булга илүү ихтэй газар учир бусдаас онцлон магадгүй эртний уламжилалт нэрээ илүү хадгалсан газар нь Шивэр, Сибэр гэх мэтээр (өтгөн, шигүү) гэх утгаар одоо ойлгогдож буй энэхүү үг

нь эртний Сувсар буюу Булганы арьс шигүү, өтгөн ноолууртайг илтгэсэн газар усны нэр гэлтэй. Сибэр, Сибэн хэмээн тэмдэглэж байсан нь өнөөгийн Шивир, Сибир хэмээх нэр үүссэн байх магадлал өндөр байна. Сибирийн бүс нутагт эртнээс сууж байсан ойн иргэд ангийн үсээр алба өргөдөг байсан бөгөөд түүн дундаа булганы арьс нилээд дээгүүрт орж байсан юм. Одоогоор булганы өлгий нутаг нь Сибир юм. Тиймээс газар усны нэрд үлдсэн байж болох баримтуудыг авч үзье. Сибирийг монгол хэлэнд Шивэр их ой гэсэн утгатай үг хэмээн хэлэлцдэг. Монгол улсын ойт хээрийн бүсэд буй болон умард нутгийн аль ч бүс нутагт Шивэрийн гол, Шивэрийн даваа, Шивэрийн нуруу, Шивэрийн адаг [Равдан: 2006. 699] гэсэн нэрс бүхий газар түгээмэл байна. Бидний таамаг зөв бол эдгээр газар бүгд суусар-булга байсан нутаг учир ийнхүү нэрийдэх болсон хэмээн үзэж байна. Монгол нутаг дахь Шивэр нэртэй газар усны нэрсийг аймаг нутгийн байршлаар нь авч үзвэл.

|    | Аймаг     | Сум          | Газрын нэр  | Байгал орчны нөхцөл  |
|----|-----------|--------------|---|--|
| 1  | Увс, Ховд | Шивэр бригад | Шивэр   |  |
| 2  | Булган    | Хантай       | Ар Шивэрт булаг   |  |
| 3  | Өмнөговь  | Баяндалай    | Шивэр булаг   |  |
| 4  | Хөвсгөл   | Тариалан     | Шивэрт булаг  |  |
| 5  | Архангай  | Баян-Уул     | Шивэртийн булаг   |  |
| 6  | Хэнтий    | Хэнтий       | Шивэрт булаг  |  |
| 7  | Булган    | Хантай       | Шивэртийн булаг   |  |
| 8  | Архангай  | Өндөр-Улаан  | Шивэртийн булаг   |  |
| 9  | Хөвсгөл   | Тариалан     | Ар Шивэрт гол   |  |
| 10 | Завхан    | Тосонцэнгэл  | Ар Шивэртийн гол  |  |
| 11 | Хэнтий    | Жаргалтхаан  | Шивэр гол   |  |
| 12 | Булган    | Орхон        | Шивэр гол   |  |
| 13 | Архангай  | Их тамир     | Шивэрт гол  |  |
| 14 | Булган    | Хутаг-Өндөр  | Шивэрт гол  |  |
| 15 | Архангай  | Чулуут       | Шивэрт гол  |  |
| 16 | Архангай  | Баян-Уул     | Шивэртийн гол   |  |
| 17 | Архангай  | Ихтамир      | Шивэртийн гол   |  |
| 18 | Архангай  | Тариат       | Шивэртийн гол   |  |
| 19 | Сэлэнгэ   | Дархан       | Шивэртийн гол   |  |
| 20 | Завхан    | Нөмрөг       | Шивэртийн гол<br>Ар Шивэрт, Өвөр<br>Шивэрт хэмээн<br>хоёр гол байдаг. | Ой мод ихтэй, ар, өвөр гэж хоёр байдаг холбоо нуурт зугаадаг. Өвөр нь уулаас буудаг. Нөмрөг Хөдөргийн нуруу. |
| 21 | Завхан    | Тэлмэн       | Шивэртийн гол   | Өвөр шивэрт нь Тэлмэн нуурт зугаадаг байна.  |
| 22 | Хөвсгөл   | Цэцэрлэг     | Шивэртийн даваа   |  |
| 23 | Хөвсгөл   | Шинэ-Идэр    | Шивэргэлийн даваа   |  |

|    |            |              |                           |   |
|----|------------|--------------|---------------------------|---|
| 24 | Ховд       | Үенч         | Шивэрийн даваа            |   |
| 25 | Төв        | Баянцогт     | Шивэрийн даваа            |   |
| 26 | Хөвсгөл    | Шинэ-Идэр    | Шивэрийн даваа            |   |
| 27 | Ховд       | Дуут         | Шивэртийн даваа           |   |
| 28 | Хэнтий     | Норивлон     | Шивэртийн даваа           |   |
| 29 | Сэлэнгэ    | Ерөө         | Шивэртийн даваа           |   |
| 30 | Сэлэнгэ    | Ерөө         | Шивэртийн нуруу           |   |
| 31 | Архангай   | Чулуут       | Их Шивэртийн нуруу        |   |
| 32 | Дорнод     | Чойбалсан    | Шивээтийн нуруу           |   |
| 33 | Төв        | Угтаалцайдам | Шивэрийн даваа            |   |
| 34 | Баян-Өлгий | Дэлүүн       | Шивэрийн уул<br>Сарай уул |   |
| 35 | Увсын      | Ховд         | Шивэр                     |   |
| 36 | Баян-Өлгий | Далайн хөл   | Шивэрийн уул              |   |
| 37 | Архангай   | Баян-Уул     | Шивэрт уул                |   |
| 38 | Архангай   | Төвшрүүлэх   | Шивэрт уул                |   |
| 39 | Хэнтий     | Норивлон     | Шивэр Мандал<br>хөндий    |   |
| 40 | Хөвсгөл    | Тариалан     | Шивэртийн хөндий          |   |
|    | Хөвсгөл    | Төмөрбулаг   | Шивэрт                    | Шивэртийн рашаантай хойшоо харсан ам, модтой                                  |
|    | Увс        | Сагил        | Шивэр                     | Улавчаа орхисон газар   |
| 41 | Баянхонгор | Баян-Өндөр   | Шивэртийн Эхэн худаг      | Э.Равдан. Монгол газар нутгийн нэрийн зүйчилсэн толь. Боть II, УБ., 2006. 699 |

Үүнээс гадна Шивээт хэмээх нэртэй газар усны нэр олон байна. Хэдийгээр Шивээ хэмээх үгийн гол утга нь ямар нэгэн харуул, хориг, шивээний шивээг илтгэдэг боловч газрын байц, олон жилийн дуудлагад хувирсан байх магадлалтай, тухайн газрын байцыг нь харахад хойш хангай, ой модтой ойр буй шивээ нь шивэртэй адил утга илтгэж байж болохоор байна. Мөн Шаварт хэмээх гол нуурын нэр олон байх бөгөөд шаваргүй гол ус гэж нэг ч үгүй бөгөөд энэ нь эхэндээ шивэр байж байгаад аажимаар суусар-булга үгүй болж суусрын шивэр хэмээх утга ч мартагдан бүдгэрсэнээр Шавар, Шаварт хэмээх газрын нэрсийн зарим нь угтаа Шивэр байсан байх газрын байц харагдаж байна. Мөн Хөвсгөл аймгийн Шивлэг Дөтийн гол [Равдан: 2006. 175] мөн л булга суусартай гэсэн утгатай гол байж болохоор дүр харагдаж байна. Дээрх Шивэр хэмээх үг бүхий газар усны нэрийн бүтцийг харахад тухайн зүйл бүхий амьтныг заасан утгатай жинхэн нэрээс тэмдэг нэр бүтээх «т» дагавар бүхий холбоо үгийн хэлбэр ажиглагдаж буйг анзаарах хэрэгтэй. Үүнтэй төстэй үслэг ангаар нэрлэгдсэн газар усны нэр олон билээ. Солонгот гол, Солонготын даваа, Булган гол, Булган уул, Үенчийн гол, Үнэгтийн даваа, Минжийн хангай, Минжийн гол, Тарвагатай нуруу гэх мэт болно. Булган хэмээх га-

зар усны нэр нь ямар нэгэн байдлаар булга бүхий нутаг байсан учир ийм нэрийдэлтэй болсон бөгөөд Булагийн гол гэсэн олон газар усны адил нэр байх бөгөөд угтаа Булгын гол, Булгат гол байж байгаад булга хэмээх амьтан нь устан үгүй болсноос хойш нэр нь гажиж Булагийн болон хувирсан байх магадлалтай юм. Бид ямартай ч дундад эрт үед монгол нутагт булгыг «шивэ, шивэр (shiwe, shiwer)» буюу сувсар хэмээх үгтэй дүйцэх үгээр нэрлэж байсныг хэлний баримтаас үзлээ.

Хөлөнбуйрийн бүс нутаг, түүн дундаа Эргүнэ баруун хошууны Жилалин (吉拉林) балгаснаас хойш 240 орчим ли газарт Баяндэлэг уулын (巴雅彦都鲁克山) баруунтаа Шивэр Булаг гол (锡伯尔布拉克河) хэмээх гол байна. Уг гол нь Эргүнэ голд өмнөд этгээдээс нийлж цутгадаг хэмээн тэмдэглэжээ. Энд Манжийн Найралт Төвийн (雍正) 5-р он буюу 1728 онд Шивэр Булагийн харуулыг (锡伯尔布拉克卡伦) нээж байсан байна. Гэвч толь бичигт Шивэр булаг гэж бичээд галиглахдаа Шавар булаг (siber bulak karun)[siber] хэмээн буулгасан нь нилээд төөрөгдөлд оруулсан байна. Тэдний тайлбарт шивэр хэмээх үг нь монгол хэлний шавар гэсэн үг, булаг нь цэвэр усны эх гэсэн үг гээд Шавар булаг (泥泉水) хэмээх утгатай хэмээн тайлбарлажээ. [朝克: 1993. 107] Бидний үзэж буйгаар энэхүү гол Шавар Булаг биш Манж эхээ дагалвал Шивэр булаг хэмээх гол бөгөөд Булгат булаг гол гэсэн санаатай нэр юм. Одоо энэ голын нэр өөрчлөгдсөн бололтой газрын зургаас олдохгүй байна. Эргүнэ голын урд талаас ирж нийлдэг гэхээр одоогийн Дэрбул гол бололтой. Тиймээс Монголын зүүн Хөлөнбуйртай хиллэж буй нутагт Манжийн үеийн харуулын нэрэнд мөн Шаварт булаг, Хэрэмт булаг хэмээх харуулын нэр байх бөгөөд энэхүү Шаварт булаг бол гажсан нэр Шивэрт булаг л гэсэн нэр болов уу. Учир нь Хэрэмт булаг, Шивэрт буюу (Булгат булаг) гол гэсэн нэр байсан хэмээн үзэх боломж байна. Шивэр хэмээн Суверыг одоогийн байдлаар VIII зууны үед адил дуудаж байсан байж болох баримт нь Уйгурын хаан Моюунчурын гэрэлт хөшөөний 3, 4-р мөрөнд «... *Найман Огуз, есөн Татар бүгд хоцролгүй ирцгээв. Сэлэнгийн баруун, Яьлун Колын өмнөөс, Шып-ийн эхэн хүртэл цэрэг суулгав би. Кэргүн, Шакьш, Шыпийн эхнээ ирцгээв. ...*» [Аззая: 2013. 101]. Энэхүү Сэлэнгийн баруун талд Яьлун гол, Шып-ийн эх хэмээн хоёр гол бололтой нэр гарах бөгөөд Шып нь бидний суусар хэмээн үзэж буй Шив-ийн язгуураар нэрлэгдсэн гол бололтой. Бидний бодлоор Ерөө гол нь энэхүү Шып гол байж магад эсвэл Орхонтой нийлээд Сэлэнгэд цутгаж буй хэсгийг хэлж байж болох юм. Учир нь Ерөөд Шивэртийн нуруу, Шивэртийн даваа хэмээх газар байна. Тиймээс уг гол Уйгурын үед Шив-ийн гол буюу «Сув» хэмээх «суверын гол» гэсэн нэртэй байсан байж болох юм. Монгол улсад Шивэр хэмээх газар усны нэрээс хамгийн том нь Ерөөгийн Шивэртийн нуруу гэсэн газар байгаа нь түүхэн баримжааг зааж байж болох юм.

Сув хэмээх үг хэрэв суусарчин булгачин хэмээх үгийн язгуур байж болохыг батлах нэгэн сонин баримт МНТ-д байна. §115-д «... Тоорил хан буцахдаа Бурхан Халдуны араар Өхөртү Жубур дайран, Гацуурт субчид,

Улиа[с]тай субчид дайран, [ан] гөрөө авласаар Туулын хар шугуйг зорин эргэв.» «... to'oril-qan icurun burqan-qaldun-nu gerü-ber hökörtü-jubur da'arin qaca'uratu-subcit huliyatu-subcit da'arin görü'en inu abala'at tu'ula-yin qara tün-ni jorin icuba» гэжээ. Энд Улиастайн субчид, гацууртын субчид хэмээх хоёр газрын мэргэжил нэгт хүмүүсийн талаар дурдагддаг. МНТ-ны эхэд Субчид хэмээх үгийн өмнөх үгийг хятад хэлнээ газрын нэр хэмээн орчуулаад уг үгд ямар нэгэн орчуулгын санал өгөлгүй хоосон орхисон байна. Бид үүнийг Гацууртын сувсарчид, Улиастайн сувсарчидтай нийлж ан ав хийгээд буцсан тухай тэмдэглэсэн зүйл бөгөөд Субчид буюу Сувсарчид хэмээх үг нь «Монголын нууц товчоо»-г хятад хадмалтай болох үед монгол хэлэнд бүрэн мартагдсан байж хэмээн үзэж байна.

Булга хэмээх үг чухам аль хэлний үг вэ? Зэргэлдээ хэлний үгсийн санд дийлэнхдээ «са, сэ, су» язгуураар эхлэх буюу сувсар хэмээж байхад булга хэмээх үг бараг цор ганц монгол хэлэнд байна. Дундад үеийн монгол хэлэнд сувсар булга хэмээн холбоо үгээр голдуу таарч байна. Булга нь «Bulqa» хэмээх «Bu+lu+q» гэсэн гурван үе байна. Мин улсын үеийн Хуа И Юй толь бичигт «Buluhan» хэмээн тэмдэглэж байна. Тэгвэл лавтай XII зууны үед булга хэмээх үг нилээд хэвшсэн маягтай хэрэглэж байсан бөгөөд хэдий үед монгол хэлэнд орж ирэв гэдэг нь нилээд сонирхолтой байна. Марко Поло-гийн тэмдэглэлээс харахад суусар булга хэмээн нэгэн үе хамт хэрэглэгдэж байсан нь ажиглагдаж байна. Тиймээс XII зууны үед лавтай булга хэмээх үг нилээд зүгширсэн байсан бөгөөд анх монгол хэлний алаг-булаг[Karataу and: 2003] буюу харлаг хэмээх зүс заасан үгнээс хар булга буюу булга хэмээх үг үүссэн байж болох юм. Марко Поло-гийн тэмдэглэлд «... Татаарууд булганы арьсыг (хаан үс) гэнэ. Тэд булгыг (рондэс?) гэх ба суусрын дайтай амьтан юм.» [Марко Поло: 2019. 96] хэмээн дийлэнх зохиолд ийм утгаар орчуулагдаж байна. Бидний үзэж буйгаар булга бол суусрын нэг төрөл гэсэн санаа илтгэж байсан болов уу гэсэн таамаг дэвшүүлж байна. Утгаа булга бол суусарын овгийн нэгэн төрөл бөгөөд бусдаас хар зүстэйгээрээ онцлог юм.

Сибирийн баруунаас Каспийн тэнгис рүү нүүсэн Авар иргэд дотор авгар, сабир, бургар... зэрэг арван гурван аймаг бүгд ойн иргэд бөгөөд тэдний дунд буй Бургар-ыг өнөөгийн Болгарууд болсон хэмээн судлаачид үздэг бөгөөд дээрх жишээ авсан алаг-булагийн булагтай холбож холилдсон үндэстэн хэмээн тайлбарласан[Karataу and: 2003] судалгааны бүтээл бий. Бидний үзэж буйгаар Бургар, Сабир нь булгачин, сувсарчин хэмээх үгийн эртний хувилбар юм биш биз? Хэрэв энэхүү гаргалгаа зөв байвал булга, сувсар хэмээх үг бүр эртнээс холбоо үгээр илэрхийлэгдэж олон зууныг дамжсан жишээ байж болох бөгөөд хэрвээ энэ үнэн бол Жужанчууд монгол хэлтэн байсны баталгааны нэг өчүүхэн хэсэг болж болох юм.

Тэгэхээр Шивэй хэмээх үг нь Шивэ, Шивэр хэмээх үгтэй гарлын холбоотой сувсар хэмээх үгнээс үүсэлтэй бөгөөд булгачин, сувсарчин, хэрэмчин гэх аж ахуйн онцлогоороо ижил овог аймгуудыг бүгдийг нь “Шивэй” хэмээн

хятад сурвалж бичигт тэмдэглэх болжээ. Тэдгээрийг газар зүйн байц, оршин буй байдал зэргээр нь умард Шивэй, магадгүй жинхэнэ хар булга агнаж, түүний арьсийг нийлүүлдэг байсан нь Да Шивэй, хар хэрэм агнаж байсан нь Сяо Шивэй буюу Жижиг Шивэй, хадны суусар нь шар толгойтой бараан зүсмийн байдгаас шалтгаалан Хуан той Шивэй буюу Шар толгойт Шивэй гэх мэт нэршлүүд үүссэн юм биш биз гэсэн сэжиг түүрүүлж байна. Одоо бид Шивэй аймгуудын түүхэн газар зүйг одоогоор илрээд буй Шивэр хэмээх газар усны нэрүүдтэй харгуулан үзье. Монгол болон БНХАУ-ын Зүүн хойд мужид буй газар усны нэрд Шивэр, Шивээ нэртэй газар маш их байх бөгөөд бүгд умард зүгт тайга, ой шугуй руу шахсан байдалтай жижиг салаа голууд, Сибирийн их ойг имжсэн шинжтэй байрлалд оршиж буй нь ажиглагдаж байна. Өргөргийн 80°-130°, уртрагийн 47°-50° хооронд дийлэнх нь байрлаж буй бөгөөд Соён-Алтай, Хангайн нуруу, Хэнтий нуруу, Их, Бага Хянганыг хамарсан томоохон газар нутагт бүгдэд нь ийм нэртэй газар байна. Одоо эдгээр газрын дийлэнхид нь булга, суусар байхгүй бөгөөд нутгийн иргэд ч Шивэр хэмээх үг бүхий газрын нэрийг ямар учиртайг нь хэлж мэдэхгүй байгаа юм. Энэ нь биологийн зүйл устаж үгүй болж буйтай холбоотой бөгөөд хамгийн ойрын жишээ буга хэмээх амьтнаар авч үзэхэд одоо Богд ууланд буга байхгүй, түүнээс өмнө орших Зоргол хайрхан уул мөн л одоо бугагүй эртдээ Зоргол хайрханд Богд уулын залуу бугууд шахагдан уг хайрханд зусдаг байсантай холбоотойгоор Зоргол хайрхан нэрийг авч байсан болов уу. Мөн БНХАУ-ын Өвөр Монголын Бугат хот мөн л үүний нэгэн жишээ юм.

БНХАУ-ын судлаач Бай Үй Дун-ны сүүлийн үеийн судалгаандаа Шивэй аймгуудын түүхэн газар зүйн байршил, чухам ямар аймгууд энэхүү нэрийг зүүж байсан талаар нилээд сонирхолтой судалгааны үр дүнд хэвлүүлсэн байна. Түүний үзэж буйгаар Шивэй аймгууд нь ганцхан Зүүн Монгол, БНХАУ-ын Зүүн хойд мужид, ОХУ-ын Алс Дорнодын нутгаар байгаагүй энэхүү бүлэг зөвхөн нэг хэсэг нь хэмээгээд бусад хэсэг нь Байгаль нуурын зүүн, баруун биеээр байсан аймгууд мөн энэхүү нэрийг зүүж байсан талаар нилээд ултай судалгаа хийсэн байдаг [白玉冬: 2017]. Тэрээр Шивэй аймгуудыг зөвхөн өнөөгийн БНХАУ-ын Зүүн хойд муж, Хөлөнбуйрын сав газраар хязгаарлагдахгүй Уйгурын хааны гэрэлт хөшөөнд дурдаж буйгаар Хөвсгөл нуурын зүүнтэй мөн хэсэг бүлэг Шивэй аймгууд байсан. Бидний үзэж буйгаар Хөвсгөл нуураас зүүн тийш Хянганы нурууны ар, Сибирийн их ойг имжсэн нутаг, Хөвсгөл нуураас баруун тийш Соёны нурууг дагасан нутагт оршин сууж байсан нийтлэг анчид Шивэй нэрийн дор байж хэмээн үзэх үндэс байна. Монголын нууц товчоонд Шивирээр нэрлэгдсэн аймгийн талаар нэг удаа дурдагдах бөгөөд Зүчи ойн иргэдийг дагуулж буй үйл явдалд §135: ирж Жөчитэй уулзав. Шибир, Кэшдийм, Байид, Тухас, Тэнлэг, Төгэлэс, Таш, Бажигидаас нааш ойн иргэнийг Жөчи [дагавар] оруулж, хиргисүүдийн түмтийн мянгатын ноёдыг, ойн иргэний ноёдыг авч ирж Чингис хаанд цагаан шонхрууд, цагаан морьд, хар булгадаар

[бэлэглэн] уулзуулав. §135: ...joci-da a'uljaba sibir kesdim bayit tuqas tenlek t'eles tas bajigid-aca inaqsi hoi-yin irgen-i joci oro'ulju kirgisud-un tümed-ün minqad-un noyad-i hoi-yin irgen-ü noyad-i abu'at irejü cinggis-qahan-tur saqa'a-nu'ut singqod-iyar saqa'a-nu'ut aqtas-iyar qara-nu'ut buluqad-iyar a'ulja'ulba oyirad-un. Энэхүү мэдээнд нэг аймаг эртний суусарчин буюу шибир хэмээх үгийн Шивирээр нэрлэгдсэн байх бөгөөд бусад булгаар алба барьж буй аймгууд бүгд өөр өөрсдийн нэртэй байгааг харж болно. Харин Дундад улсын эртний сурвалж бичигт тэмдэглэгдсэн Шивэйн олон аймаг нь тус тусдаа нэртэй аймаг бүлгүүд байсан бөгөөд эдгээр олон аймгуудыг бүгдийг нь аж ахуйгаар нь Шивэй буюу Сувсарчин хэмээх нэрийн дор тэмдэглэх болсон байна.

### Ном зүй:

<http://gerel.net/> <http://hkuri.cneas.tohoku.ac.jp/p05/manchu/listAction> хайлт (siber)

Karatay - Karatay, Osman (2003). *In Search of the Lost Tribe: The Origins and Making of the Croation Nation*. Ayse Demiral. ISBN 9789756467077.

Аззаяа - А.Аззаяа. Орхон бичгийн дурсгал V. Монгол Алтай судлаачдын холбоо XIV. УБ., 2013.101

Батсүрэн - Б.Батсүрэн. Ухуань (Авар) ба Сяньби (Сэрби). УБ., 2016

Билэгт - Л.Билэгт. Роль шивэйских племен в этногенезе монголов// Studia Ethnologica. Том. XVI, fasc. 8. УБ., 2004. 47-54

Ганбат нар- Н.Ганбат, Б.Батцоож, Г.Одмагнай. Түүх өгүүлэх нэгэн зураг. УБ., 2019. 45

Егоров - В.Г.Егоров. Этимологический словарь Чувашского языка. Чебоксары-1996. 184

Марко Поло- Марко Пологийн аялал. Орч: Г.Бат-Учрал, Элизабетта Рагагнин, Самүэла Симион. УБ., 2019.96

Намнандорж - О.Намнандорж. БНМАУ-ын Дархан газар, цаазтай амьтан. УБ., 1976.119

Пекарский - Э.К.Пекарский. Краткий Русско-Якутский словарь. Петроградъ. 1916.г. 196.л

Равдан - Э.Равдан. Монгол газар нутгийн нэрийн зүйчилсэн толь. Боть I, II. УБ., 2006

Сүхбаатар - Г.Сүхбаатар. Сяньби. УБ.,1971. 76-77

Федотов - М.Р.Федотов. Этимологический словарь Чувашского языка. В 2-х томах. Том II, Сав-Яштака. Чебоксары-1996. 33

Цэрэнсодном - Д.Цэрэнсодном. Монголын нууц товчооны орчуулга, тайлбар. УБ., 2000

敖嫩- 敖嫩.鄂温克民间故事集. 通辽市. 2007. 75-111

傲拉-毕力格- 蒙汉满词典. 作者: 傲拉-毕力格, 内蒙古科学技术出版社.2016. 465-466

尹铁超- 尹铁超. 鲜卑名考, 满-通古斯语言与文化研究, 编: 赵阿平, 民族出版社。北京2008. 351-367

朝克- D.O.朝克. 《黑龙江志稿》呼伦县和室韦县的地名考释. 民族研究.1993. 107

朱学渊- 朱学渊. 鲜卑民族及其语言, 载《满语研究》, 2000 (1), (2); 孙进已: 东北民族源流, 75页, 哈尔滨, 黑龙江人民出版社, 1989.

杜鲁基尔-锡阿番- 鄂蒙词典. 杜鲁基尔-锡阿番, 杜拉尔-道尔基。民族出版社, 2010. 1110

白玉冬- 白玉冬. 九姓达斡游牧王国史研究 (8-11世纪). 中国社会科学出版社. 北京2017年

### References:

<http://gerel.net/> [http://hkuri.cneas.tohoku.ac.jp/p05/manchu/listAction\\_hajlt\(siber\)](http://hkuri.cneas.tohoku.ac.jp/p05/manchu/listAction_hajlt(siber))

Karatay - Karatay, Osman (2003). In Search of the Lost Tribe: The Origins and Making of the Croation Nation. Ayse Demiral. ISBN 9789756467077.

Azzayaa - A.Azzayaa. Orhon bichgijn dursgal V. Mongol Altaj sudlaachdyn holboo XIV. UB., 2013.101

Batsyren - B.Batsyren. Uhuan' (Avar) ba Syan'bi (Serbi). UB., 2016

Bilegt - L.Bilegt. Rol' shivejskih plemen v etnogeneze mongolov// Studia Ethnologica. Tom. XVI, fasc. 8. UB., 2004. 47-54

Ganbat nar- N.Ganbat, B.Batcoozh, G.Odmagnaj. Түүх өгүүлэх negen zurag. UB., 2019. 45

Egorov - V.G.Egorov. Etimologicheskij slovar' CHuvashskogo yazyka. CHEboksary-1996. 184

Marko Polo- Marko Pologijn ayalal. Orch: G.Bat-Uchral, Elizabetta Ragagnin, Samyela Simion. UB., 2019.96

Namnandorzh - O.Namnandorzh. BNMAU-yn Darhan gazar, caaztaj am'tan. UB., 1976.119

Pekarskij - E.K.Pekarskij. Kratkij Russko-YAkutskij slovar'. Petrograd". 1916.g. 196.1

Ravdan - E.Ravdan. Mongol gazar nutgijn nerijn zyjchilsen tol'. Bot' I, II. UB., 2006

Syhbaatar - G.Syhbaatar. Syan'bi. UB.,1971. 76-77

Fedotov - M.R.Fedotov. Etimologicheskij slovar' CHuvashskogo yazyka. V 2-h tomax. Tom II, Sav-YAshtaka. CHEboksary-1996. 33

Cerensodnom - D.Cerensodnom. Mongolyn nuuc tovchoony orchuulga, tajlbar. UB., 2000

敖嫩- 敖嫩. 鄂温克民间故事集. 通辽市. 2007. 75-111

傲拉-毕力格- 蒙汉满词典. 作者: 傲拉-毕力格, 内蒙古科学技术出版社. 2016. 465-466

尹铁超- 尹铁超. 鲜卑名考, 满-通古斯语言与文化研究, 编: 赵阿平, 民族出版社. 北京2008. 351-367

朝克- D.O. 朝克. 《黑龙江志稿》 呼伦县和室韦县的地名考释. 民族研究. 1993. 107

朱学渊- 朱学渊. 鲜卑民族及其语言, 载《满语研究》, 2000 (1), (2); 孙进己: 东北民族源流, 75页, 哈尔滨, 黑龙江人民出版社, 1989.

杜鲁基尔-锡阿番- 鄂蒙词典. 杜鲁基尔-锡阿番, 杜拉尔-道尔基. 民族出版社, 2010. 1110

白玉冬- 白玉冬. 九姓达斡游牧王国史研究 (8-11世纪). 中国社会科学出版社. 北京2017年

**МРНТИ 03.41.91**

**УДК: 904**

### **Өлзийбаяр С.**

Монгол улсын ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, доктор (Ph.D) (Монгол улс ).

E-mail: ulziibayars@yahoo.com

## **ХАН ХЭНТИЙ УУЛЫН НЭРИЙН ҮҮСЛИЙН АСУУДАЛД**

Бурхан Халдун нэр (топоним)-ийн утга нь «бурхан» гэх буддын шашны бурхан тэнгэрийн нэр, Халдун нь эрт цагт өвгөд дээдсийн шарилыг хайлуулан чандар болгох газрын цээр нэр бололтой байна. Бурхан нэрийн «бур» язгуур гээгдэж, Хан хэлбэртэй болсон. Халдуны «qala» язгууртай ойролцоо утгатай халуун ханзны «qana» язгуураас *санда*, *сандайх*, *сэнтййх*, *сэнтйий* гэх мэт утга салбарлан үүнээс Хэнтий нэр үүссэн байна. Хан Хэнтий уул нь байрлал, үзэгдэх ихэмсэг төрх байдлаар үнэхээр хаан сэнтйй мэт харагдах тул Монголын алтан ургийн ихэс дээдэс Их Чингис хааны төр ёсыг билэгдэж, тахисаар ирсэн юм. Тиймээс Хан Хэнтий уулыг Бурхан Халдун болгож өөрчилсөн УИХ-ын шийдвэрийн зөв, бурууг эргэн нягтлах, улмаар Хан Хэнтий нэрийг буцааж албан ёсоор сэргээх нь төр ёсны түүхэн уламжлалд үлэмж нийцтэй болох болов уу.

**Түлхүүр үг:** Бурхан Халдун, Хан Хэнтий, хан сэнтйй, тахилга.

IRSTI 03.41.91

UDC: 904

**Өлзийбаяр С.**

Ph.D., Researcher, Institute of History and Ethnography,

Academy of Sciences of Mongolia, (Mongolia)

E-mail: ulziibayars@yahoo.com

**ETYMOLOGICAL ISSUES KHAN HANTIY**

Presumably, the toponym «Burkhan Khaldun» consists of the word «Burkhan (Buddha)» from Buddhism and «Khaldun» that means the forbidden place where cremations of our ancestors' dead bodies were made. The root «bur» of the word Burkhan was lost and «Khan» remained. The root «gala» of the word Khaldun is similar to the meaning of the hieroglyph «kane», the throne or seat in Mongolian language is named as *sentikh* or *seniti*. *Sentii* inclined and as the result the toponym «Khentii» appeared. The mountain Khan Khentii really has grandiose appearance as the khan's throne and therefore, aristocrats from the Mongolian Golden genesis have worshipped the mountain symbolizing Chinggis khan's state morality. Therefore, it will be correct to restore the former name Khan Khentii (changed as Burkhan Khaldun) officially.

**Keywords:** Bûrqân Qâldûn, Khan Khentii, khan seniti (king throne), tahlilga

МРНТИ 03.41.91

УДК: 904

**Олзийбаяр С.**

д.и.н., научный сотрудник, Институт истории и этнологии,

Академии наук Монголии (Монголия),

E-mail: ulziibayars@yahoo.com

**ЭТИМОЛОГИЧЕСКИЕ ВОПРОСЫ ХАН-ХЕНТИЙ**

Предположительно, топоним «Бурхан Халдун» состоит из слов «Бурхан (Будда)» и буддизмского «Халдун», что означает запретное место, где производились кремации трупов предков. Корень «бур» слова Бурхан был потерян, а «Хан» сохранился. Корень «гала» слова «халдун» подобен значению иероглифа «кане», трон или место на монгольском языке называют сентих или сенти. Сентий склонился и в результате появился топоним «Хентий».

Гора Хан-Хентий действительно имеет грандиозный облик как трон хана, и поэтому аристократы монгольского Золотого происхождения поклонялись горе, символизирующей государственную мораль Чингисхана. Поэтому будет правильным восстановить официальное имя бывшего хана Хентии (сменившего Бурхан Халдун).

**Ключевые слова:** Бурхан Халдун, Хан-Хентий, король торон, поминка

2017 оны 2-р сарын 9-ны өдрийн УИХ-ын № 20-р тогтоолоор Хэнтий хаан уулын нэрийг Бурхан Халдун уул болгон өөрчлөж, Хан Хэнтий уулын нэрийг газрын зургаас авах болсноор үнэн хэрэгтээ энэ хайрхан «алга болов». Энэхүү тахилгат их хайрханы нэрийг ЮНЕСКО-ийн Дэлхийн өвийн жагсаалтад оруулах зорилготой гаргасан шийдвэр бөгөөд тийм чухал эсэх асуудал нь уг уулын нэрийг өөрчлөхөөс бага санагдана.

МНТ –ны эхлэл Бөртэ чинийн нүүн ирж голомтоо бадраасан нутаг Бурхан Халдун уул хэмээн тэмдэглэгдсэн учраас зарим судлаачид ҮШ зууны дунд хэрд энэхүү нэр байсан гэж үзэж байна. МНТ –нд Бурхан Халдун уул Чингис хааны түүхтэй салшгүй холбогдон дурдагдаж байгаа нь тухайн цагт энэхүү нэр бий болж, өмнөх үеийн түүхэн үйл явдал өрнөсөн газрын нэрийг өөрчлөн нөхвөрлөн бичсэн байх магадлалтайг ч харуулж байж болох юм. Гэхдээ МНТ-оос өмнө Бурхан Халдун гэж оноосон нэр байсныг гэрчлэх баримт одоогоор олдоогүй ч Халдун нэр нэлээд эртний шинжтэй шиг байна. Хэл шинжээчдийн тайлбараар дундад үеийн монгол хэлний үед үгийн эхэнд байсан сул шүргэх *h*- орчин үеийн олонхи хэл, аялгуунуудад бүрмөсөн сугарсан [Төмөртоого, 1992: 118] ажээ. Орчин цагийн Алтай уулын нэр эрт цагтаа Г(Х)алтай байсан байх бүрэн боломжтой учир Халдун нэрийн нэгэн хувилбар байсан бололтой. Хэдийгээр МНТ-нд \**харбан* (арван) гэх зэргээр сул шүргэх *h* гийгүүлэгч сугараагүй жишээ цөөнгүй боловч орчин цагийн монгол хэлэнд хадгалагдсаар байгаа *h* авиа МНТ-нд сугарсан тохиолдолыг §94-т «...*cokole'ei aran ujeba-je cimayi*» [Igor de Rachewiltz..., 1972:19] «...*цөхлөө харан үзэв чамайг*» хэмээх үгнээс харж болох мэт. Эндээс үзэхэд гийгүүлэгч сугарах тохиолдол он удаан жил үргэлжлэх хувьсал болох нь харагдах учир эртний монгол хэлэнд *Галтай* уул гэгдэж байгаад МНТ-ны үед үгийн эхний гийгүүлэгч сугаран Алтай болоод байжээ. Ингэж үзвэл Халдун нэр эртний дуудлагаа хадгалсан хэлбэр гэж тайлбарлаж болох ба эртний монгол хэлтнүүд өнөөгийн Алтай мэт уулсын том ай (нуруу)-г Халдун гэж нэрийддэг байсан ч байж болох.

Бурхан Халдун уул МНТ болон Судрын чуулганд дурдагдсанаас үзэхэд нэгэн тодорхой уул эсвэл харьцангуй том талбай эзлэх уулс мэт дүрслэгдэнэ. Тухайлбал, Судрын чуулганд «Монголд Бурхан Халдун (*Bûrqân Qâldûn*) гэдэг нэртэй уул бий. Түүний нэг талын хормой нь олон голын эх болдог. Тэр голууд битүү бүрхсэн ой модтой. Тэр ойгоор тайчууд аймаг нутагладаг байв. Чингис хаан өөрөө оршуулах газраа тэнд гэж заасан ба миний болоод ургий-

нхныг маань тавих газар энд байх учиртай гэжээ. Чингис хааны өвөлжөө, зуслан тэрхүү хязгаарт байдаг ... Онон голын адгаас Бурхан Халдун хүрэхэд зургаан өдрийн газар» [Rashîd âl-Dîn Fazl..., 1383:541] гээд түүнээс эх аван урссан 8 голын нэрийг бичсэн байдаг. Эндээс үзэхэд их хааны өвөлжөө, зусланг багтаасан, хязгаар нутаг гэж тодотгосон, олон голын эх болсон зэргээс үзэхэд том талбайг хамарсан уулс болох нь илт мэдэгдэнэ.

Бурхан Халдун нэрийн талаар судлаачид бургас мод, онго шүтээн, эцэг өвгөд, эмгэд хөгшид, будда-ийн бурхан, бургих үйл үг гэх мэт олон салаа утгаар тайлбарласны дотор өвөг дээдсээ хөдөөлүүлэх ариун газар гэсэн утгаар үзсэн нь олон бий. Тухайлбал, С.Дулам “burqan”- нь «bu-ta, bu-r-ya-su» (бут, бургас)-ын эзэн бөгөөд бурх, бурхан гэдэг нь «өвгөн» гэсэн утгатай хэмээн үзсэн тул «Бурхан халдун» уулыг «өвгөдийн бургастай уул, халдун бургас бүхий өвгөдийн алтан өлгий» [Дулам, 1989: 56], М.Ууганбаяр «Бурхан халдун гэдэг нь «оршуулгын газар», «өвөг дээдэс, онгон» гэсэн утгатай гээд qala qalabaγai (эцэг, өвгөд), дагуур хэлний qa-la (овог аймаг, өвөг дээдэс) гэсэн үгтэй «qaldun» хэмээх үг гарлаараа нэг» [Ууганбаяр, 1994] гэжээ. Харин Ш. Гаадамба: Бурхан халдун-а гэсэн үгийн «Бурхан» гэсэн нь үнэхээр бурхан (тэнгэр бурхан) гэсэн утгаар хэрэглэгдсэн байж болно. Учир нь энэ үг энд «бурхан босхагсан» гэсэн хүний нэр биш, харин хүний үйл заасан үгтэй холбогдож байгаагаас энэ нь ил байна гэжээ [Гаадамба, 1990:223]. Одоо бидний Бурхан Халдун хэмээн үзэж буй хайрханы оройд Чингис хааны булш байх боломжтой [Батсайхан, Даваа, Бор, 2007: 77-86] гэх таамаг гарсан нь дээрх эрдэмтдийн саналыг тодорхой хэмжээнд лавшруулж буй хэрэг болно.

Бурхан Халдун нэрийн талаар бид дараах хэлбэрээр санал нэмэрлэх оролдлого хийлээ. Бурхан нэр нь Ш.Гаадамба гуайн тайлбараар үнэхээр бурхан шүтээний холбогдолтой байж болно. Тухайлбал, бурхан хэмээх үгийн гарлыг холбогдох үгээ улам хүч оруулсан «бүрмөсөн» гэсэн утгатай дүйлгэж болох «bürün» хэмээх МНТ-нд олонтаа тэмдэглэгдсэн үгийн «bür» язгууртай холбон үзэх саналтай байна. Тухайлбал, боржигин – «бүр»+ хан хүүд олгох цол болох «жигин» гэсэн хоёр үгийн нийлбэр «бүрэн цагаарсан» гэх утга илэрхийлэх *боржигин* нэр «bür» язгууртай болох талаар бид тайлбарласан билээ [Өлзийбаяр, 2015]. Бөртэ – «бүр» язгуур дээр тэмдэг нэр үүсгэх «т» дагавар залгаж, бүр хэтийдсэн, төгс хэмээх агуулгатай үг үүсгэжээ. МНТ-ны хажуугийн орчуулгад *börte cinö* –ийн бөртэг хөх чоно гэсэн утгаар орчуулсныг баримтлан чонотой холбон талбарласаар иржээ. Гэтэл их хатан Бөртэг мөн ижил *börte* хэмээн галиглажээ. Тиймээс эл оноосон нэрний чонотой холбогдох утга багасна хэмээн сэтгэж, бид дээрх санал дэвшүүлж буй болно.

Тэгвэл энэхүү «bür» язгуурын утгаар бурхан хэмээх үгийг тайлбарлахад бүр-хан буюу бүрүн хан хэмээх утгатай нийлмэл үг гэж ухах боломжтой болно. Энэ нь “өвгөн” гэсэн утгатай гэсэн судлаачдын тайлбартай зөрөхгүй. Товчилвол, «бүр» язгуур нь хан хэмээх эрхэм цолыг тодотгох, хүч оруулах хэлбэрээр хоршоноос *бурхан* буюу *бүр хан* хэмээх үг үүсчээ. Орчин цагийн

Бүрэн хаан нэрт уул нь эрт цагийн Бурхан уулын нэрийн улбаа мэт. Бурхан Халдун уулын Бурхан нэр нь Ш.Гаадамба нарын тайлбараар угаас бурхны агуулгатай байсан шиг байна.

Халдун нэрийн тухайд М.Ууганбаярын дагуур хэлний *qa-la* (овог ай-маг, өвөг дээдэс) гэсэн үгтэй “*qaldun*” хэмээх үг гарлаараа нэг гэж үзсэн нь дэмжүүштэй байна. *Qa-la* буюу овог, өвөг дээдэс хэмээх үг нь монгол хэлний *gal* буюу гал голомтоо тойрон нягтрах үйлээс гаралтай байж болох бөгөөд эдүгээ монгол хэлэнд «нэгэн гал болох» гэх мэт хэлц хадгалагдсаар байна. Энэ үгийн гал голомттой холбогдож болох бас нэгэн хувилбар нь монгол хэлээр *hanju* (*ханз*) гэгдэх байшин буюу гэрт хагас талыг эзлүүлэн, суух, хэвтэхэд зориулж хийсэн хөмрөг, халуун ханз, ханзтай байшин [Цэвэл, 1966: 658] - гэх утгатай үгийн гарал болно. Энэ үг хятад хэлэнд 炕 (*kàng*), харин манж хэлэнд “на” угтвар аваад *nahan* хэлбэртэй байна. Ер нь «Амар мөрний манж-тунгус ард түмэн эрт үеэс ханзны талаар нэгдсэн ойлголттой байсныг - нагань, накань, нахань, накан, наган (манж, негидаль), накан, нака, наха (нанай, ульчи, орочи) гэх мэт аялгаар» [Кызласов, 2009:95-129] кан буюу ханзыг нэрлэж байгаагаас мэдэж болох юм. Ханз нь манай эриний зааг үеэс Амар мөрний сав, Төв Азийн нутгаар тархах болсон сууцандаа гал түлж, дээгүүр нь чулуу хавтгайлан тусгайлан зассан сувгаар утааг гүйлгэж дулаацуулах байгууламж юм. Археологийн хэрэглэгдэхүүнээс үзэхэд монгол орны нутагт ханзыг олон үеийн туршид хэрэглэж байсан нь тодорхой болжээ [Давыдова, 1956:261-300; Бродянский, 1985:46-50; Деревянко, 1991:65 рис.33; Төрбат, Батсүх, Пуса, Рамзайер, 2008: 326-354; Өлзийбаяр, 2011:80-90; Батболд, 2013].

Ханзны *han, kàng* язгуур болон монгол хэлний *гал* (нэг гал болох, голомтоо тойроод нэгдэх утгаар) хэмээх үгтэй утга дүйлгэж болох дагуур хэлний *qa-la* язгуур хоёул “халах” үйлийг илэрхийлж байгаа нь сонирхолтой байна. *Хал* язгуураас халах, халуун зэрэг утгатай үг үүссэн бол *хан* язгуураас *х/с*-ээр сэлгэж, ханзны дээр суух үйлээс гаралтай *х/сандал* гэсэн үг үүсэн *сандайх, сэндийх, сэнтий* мэтээр хал, хан язгуурын утга салаалсан байж болох мэт. Ард түмний дунд Хан Хэнтий уулын нэрийг энэхүү хаан сэнтий хэмээх үгтэй холбон үзэх хандлага их бий.

Ш.Гаадамба «Халдун» гэдэг үгийг ... олонхи нь газар орны тусгай нэр гэж үзэж ирсэн боловч бидний бодоход халдун гэгч тахилга оршуулгатай газрын ерөнхий нэр бололтой. Учир нь МНТ-ны (§164) зүйлд «Би бэр өтүлбэй. Нама-йи өтүлжү өндүд-э (өндөр газарт) гарбасу, хагучидба би. Хагучитчу халдуд-та гарбасу» гэсэн үг гарч буйн доторх «халдуд-та» гэдэг үг бол «оршуулгын газар» гарвал гэсэн утгатай байна. Тийм газар нь өндөр газар байжээ [Гаадамба, 1990: 223]. Энэ санааг М.Базаррагчаа дэмжсэн байна [Бадамхатан, 1997: 36-48]. Ш.Гаадамба ийнхүү оршуулгын газар гэж тайлбарласан халдун нь халах язгуураас үүссэн нэр үг болно. *Халдун, халдуд* нь магадгүй шарил хайлуулах, чандар болгодог газрын тусгайлсан цээр нэр байсан бо-

лолтой. Шарилыг өндөр газарт их утаа май үүсгэж шатаах нь тэнгэрт сүнснийг дэгдээж буй санаа юм. А.Пунсаг МНТ-ны (§112)-зүйлд гардаг «Хаатай Дармалаг барин авчирч хавтсан бугуу өмсгөж, Халдун Бурханаа зориулав» хэмээсэн өгүүлбэрт буй «зориулав» хэмээх үгийг Бурхан Халдун ууланд өргөл, тахилга болгон нөгчөөснийг заасан цээр үг гэжээ. Мөн тэрээр МНТ-нд «үнсээр хийсгэн алдав (§87)», «үнсээр хийстэл үлитгэв (§112)», «үнсээр хийсгэх (§146), «үнсээр хийсгэн хядав (§148)» гэх мэтээр «алах, хядах» гэсэн утга илэрхийлэх цээр үгийг эртний монголчуудын оршуулгын «галийгчаа галаар дэгдээж, чандрыг нь хийсгэх» зан үйлээс улбаатай хэмээх санал дэвшүүлжээ [Пунсаг, 2008: 160-164, 65-66]. Эл санал нь халдун, халдудыг оршуулгын газар гэж үзсэнтэй утга зохицно. Ю.Болдбаатар Бурхан Халдун нэрийг тайлбарлахдаа тэнгэрт ойрхон бураа ихтэй бургиж байдаг уул хэмээн «бур» язгуураас гаралтай гэж үзсэн билээ [Болдбаатар, 2004: 49-58].

Тиймээс Бурхан Халдун нь бүрүн хан (бурхан болох) үгүй болсон өвөг дээдэс, чандрын газар гэсэн утга илэрхийлэх бололтой. Ингэж үзвэл халдуд нь олон тоог заасан утгатай байж болох бөгөөд нэг бус ийм халдун (халдахыг хорьсон *хориг*) байсан нь тодорхой юм. Буддын шашин дэлгэрэх цагт бурхан нэр өнөөгийн утгаар түгсэн бол *халдун*, *халдуд-та* нь шарил халаах, шатааж чандарлах ёс улирч, хуучин цагт дэлгэрч байсан булшлах, бунхлах оршуулгын зан үйл буцаж сэргэх болсонтой уялдан *халдута* нэр мартагджээ.

Бурхан Халдун чухам яагаад Хан Хэнтий болсон талаарх асуудал нэн сонирхол төрүүлнэ. Х.Пэрлээ Бурхан халдуны нэрийг хэзээ, хэдийд Хэнтий гэх болсон, Бурхан Халдун яагаад хуучин өчиг сацал-сударт XIII зууны үеийн бусад түүхэн газрын хамт нэр оролцох болж, Хэнтий хан, Бурхан халдун хоёр өөр тахилгын уул мэт дурсагдах болсон нь бас л тодорхойгүй. Эдгээр асуудлыг нэгэн тийш болгох нь Их хоригийг хэзээ үгүй болж, ор улбаагүй мартагдсаныг илрүүлэн олоход нягт холбоотой бөгөөд нилээд цаг хугацаа, мэдлэг чадвар, эд хөрөнгө орох буурьтай, шаргуу шинжилгээний ажил шаардагдана [Пэрлээ, 10-21] гэжээ.

Судар бичгээс сөхөхөд Хэнтий Хан нэр хамгийн түрүүнд 1604-1628 оны хооронд зохиогдсон “Хураангуй Алтан товч” зохиолд Их хааны шарилыг нутаглуулсан газрын талаар дурдсан (§68, 72) «Үнэн хүүрийг заримууд Бурхан Халдунаа онголов гэх, заримууд Алтай ханы ард, Хэнтий ханы өвөрт, Их Өтөг нэрт газраа онголов гэх» [Хаадын үндсэн хураангуй...2004] мэдээ 1634 онд зохиогдсон гэж үздэг Лу. Алтан товч зохиолд давтагддаг [Лувсанданзан, 2006:220]. Эндээс үзэхэд ХҮП зууны эх гэхэд Хэнтий Хан нэр гарсны зэрэгцээ Бурхан Халдун нэр ч хадгалагдаж байсан бөгөөд С.Бадамхатан дээрх мэдээг нягтлаад “Бурхан Халдун, Хэнтий Хан гэсэн энэ хоёр нэр зэрэгцэн оршиж байсан нь харагдаж байна. Хожим Бурхан Халдун нь Хэнтий Ханаар солигдон нэршсэн ажээ” [Бадамхатан, 1997] гэж дүгнэжээ.

Алтай ханыг Авлах цагт Аргал угалзыг Гүйцэн алахад Арван түмэн Авны улс үл магтав. Хөхүй ханыг Хөвчлөн авлаж Хөх чоныг Хөөж авлахад Хөв-

чийн улс Нэг ч үл магтав. Хэнтий ханыг Хэрэн авлаж Хэдэн түмэн Гөрөөсийг алахад Хэлхүй улс Нэгч эс магтав [Хоёр загалын тууж, 1956] гэж *Хэнтий Хан* нэр дурдагдсан «Чингисийн эр хоёр загал»-туужийн зохиогдсон он цагийн асуудал сонирхолтой. Ц.Дамдинсүрэн дээрх зохиолыг кирилл үсгээр хэвлүүлэхдээ Монголд ХҮГ зууны үеэс эхлэн бурхны шажин их дэлгэрсэн тул тэр үеэс хойш зохиогдсон зохиолд эрхбиш шажны нөлөө орсон байдаг бол энд огт байхгүйг онцолжээ. Хөх тэнгэрт сүсэглэх, тэнгэрт мал сэтэрлэх зэрэг бөөгийн заншил үлэмж байгаа, “отын хүн урьд яв, тахилзуурын хүн тасралтгүй яв» эсвэл XIII зууны эхэн үеийн «Чингисийн чулууны бичиг»-т буй «зэв онтодохуй» хэмээх үг энд дурдагдаж буй зэрэг хуучны буюу XIII-XIV зууны үеийн монгол хэлээр бичигдсэн зэрэгт үндэслэн «XIV зууны үеийн зохиол» бололтой хэмээн таамаг дэвшүүлжээ. Ц.Дамдинсүрэнгийн саналыг үндэс болговол түүх бичлэгт түвд уламжлал нэвтрэхээс өмнө Хэнтий нэр бий болоод байсан нь илт байна. Тиймээс Хэнтий нэрийн гарлыг түвд хэлний үүднээс тайлбарлах боломж багасах юм. Харин эртний түрэг-монгол хэлний үүднээс *ken-tag//taw//tay* өргөн уудам уул, таг хэмээсэн утгатай, *ken+tag // ken+taw // ken+tay > ken+tei* Хэн+тий байх учиртай өргөн уудам баян уул, уулын тэгш тагтай уул хэмээсэн утгатай бөгөөд *kön-dei > хөндий* гэсэнтэй загвар лугаа гэж тайлбарлаж болох ажээ<sup>1</sup>. Мөн олон ардын дунд сэнтий хэмээх үгтэй холбон үзэх нь их бий.

Эдүгээ бидний Бурхан Халдун уул хэмээн үзсэн уулыг Их Чингис хаан онцгойлон үзэж, тахиж байх тухай урагтаа захисан талаар МНТ (§103)-нд дурдсан буй. Бурхан Халдуныг хойч үе хэрхэн тахиж байсан тухай мэдээ ховор бөгөөд Х.Пэрлээ Хан Хэнтий уулын өврөөс гурван хөлт тогоо, барилгын үлдэц илрүүлэн XIII-XIV зуунд холбогдуулан, Төмөр хааны хүү Кемала Бурхан Халдунд байгуулсан сүмийн үлдэц гэж тайлбарласан [Пэрлээ]. Харин Хан Хэнтий уулын тахилгын талаарх мэдээ Өндөр гэгээний үед холбогдоно. Тухайлбал, 1818 онд Манж чин улсаас Хүрээнд томилон суулгасан төлөөний сайдуудаас, Манж улсын хаан эзэнд айлтгасан манж үсгийн айлтгал бичигт «Гагцхүү Халхын Түшээт хан, Сэцэн хан хоёр аймгийн нутгийн хооронд буй Хэнтий хан уул болбоос угаас өвгөн Жэбзүндамба хутагт тайх бөгөөд мөн ч Халхын ван, гүн нар чин үнэн санаагаар тус тусдаа тахимуй» [Манжаас халхын] хэмээн өгүүлжээ. Эндээс үзэхэд Хан Хэнтий уулыг ХҮГ зуун гэхэд тахиж байсан нь тодорхой бөгөөд мөн бичигт «Хан Хэнтий уул хэмээгч Богд эзний нэртэй уул бөгөөд Хүрээнээс зүүн тийш хоёр өдрийн алсалсан газарт буй» гэж өгүүлжээ. Тэгэхээр Хан Хэнтий уулын тахилга нь Их Чингис хаантай холбоотой байсан нь тодорхой бөгөөд Манжийн үед уламжлалт тахилгын мөн чанараа хадгалсаар 1920-иод онтой золгожээ. Тухайлбал, 1929 онд Монгол Ардын нам сэтгүүлд С.В.Кондратьев «Улс төр ба эрдэм боловсролын тухай» өгүүлэл нийтлүүлэхдээ «Хан Хэнтий нь онгон сүлдтэй уул бөгөөд Чингисийн нэртэй холбогдон эдүгээ хүртэл тахигдаж байна. Энэхүү уулын

<sup>1</sup> БНКазУ-ын эрдэмтэн Б.Напил энэхүү боломжит тайлбарыг амаар хэлж өгсөн болно.

бэлд Чингисийн хэмээн алдаршсан тогоо буй уулын хормойд ба оргил дээр хоёр сайхан чимэгтэй овоо бас бий» [Монгол ардын нам] гэжээ.

Өндөр гэгээн болон гарал угсаа өндөр ван гүнгүүд Хан Хэнтий уулыг Чингис хааны нэртэй холбогдуулан тахиж байсан нь Их хориг бүхий Бурхан Халдун уул нь Хан Хэнтий нэрээр солигдсон байх боломжтойг харуулж байна. Бурхан Халдун хэмээх оноосон нэр нь МНТ зохиогдох үеийн нэршил эсвэл уг зохиолд гарч буй Бөртэ чино, түүний дараа Шинчи баян ирэх үед уг нэртэй байсан эсэхийг бид батлан өгүүлэх боломжгүй ч Их хааныг Тэнгэрт дэвшсэний дараа түүний үнэн биеийг онхолсон өндөр уулыг Бурхан Халдун гэж нэрлэсэн байх тал ч бий.

Их хааны биеийг оршуулсан газар болох Бурхан Халдуныг Судрын чуулганд олон голын эх газарт байрладаг болохыг онцлон дурдсан нь ихэд учиртай. Газрыг шинжих монгол сударт уулын хааны шинжийг «Уулын хааны үзүүр нь огторгуйд тулсан мэт, бат үзэсгэлэн байдал нь тэгш, хязгаар муруй үгүй, гол сайн, асга цас ой бүрдсэн. Хавцгай хийгээд усан өмнөөр нь хүрээлсэн. ... Ардаа [эгц] түргэн болоод өвөртөө хэвтэх, хормой уртлаг, газрын хязгаар давхарлаг, эрт нарны гэрэл тусаад үдэш удаан хураах» [Дэсрид Санжаажамц, 2017: 51] гэх тодорхойлон бичсэн нь гурван мөрний эх Хан Хэнтий уулын хэлбэртэй яв цав нийцнэ. Хан Хэнтий уул буюу Их хааны онгоныг хадгалсан байж болох хайрхан маань өндөрлөг буюу их мөрнүүдийн эх дээр тэнгэрлэг байрлалтай байна. Төрх байдал нь Хубилай хааны үед зохиогдсон тухайн цагийн төр, хууль цаазын чухал эх сурвалж болох «Цагаан түүх» зохиолд «хан хүн харьт гурван их үйлс, дөрвөн их төр, зургаан их үлгэр, долоон их бин, есөн их билгэ»-тэй хэмээгээд есөн их билгийн дотор «өндөр далбат асари хүнд суудлын билгэ» [Цагаан түүх, 2006:31] болох хаан сэнтийтэй туйлын төслөг болно. Хоёр талдаа уужим хоёр түшлэг, өргөн суудалтай, өндөр далбатай мэт үзэгдэх, их мөрнүүдийн эх дээр байрлах ийм уулыг өөр хаанаас ч эрээд олдохгүй бизээ. Тиймээс Хаан Сэнтий болсон уулын дээр цагаан яст «Жэбзүндамба хутагт тайх бөгөөд мөн ч Халхын ван, гүн нар чин үнэн санаагаар» тахихаар дээр нь гарахаас бус дорд харцас Хан Хэнтий уулын өмнө талд нь байрлах Босгын даваанаас үл хэтэрдэг байсан бизээ.

Тиймээс Хэнтий нэрийн гарал нь ka-na, qa-la хэмээх «халах, халуун» гэсэн утгатай язгуур буюу өмнө үеийн Халдун хэмээх чандар хийх оршуулгын газрын нэрийн язгууртай нэг байна. Магадгүй XIII, XIV зуунаас хойш Их Хааны онгоныг хадгалсан төрийн их билгийн нэг уужим сэнтийтэй төслөг байдлаар нэрлэх хандлага давамгайлан Хан Сэнтий буюу Хан Хэнтий уулын нэр төлөвших болжээ. Ноёлог өндөр ууланд Хан цол хайрлаж, дуудах болсон цагаас Бурхан нэрийн «būr» язгуур гээгдсэн бол өвгөд (магадгүй Чингис хаан)-ийн үнэн биеийг халааж чандарлан, их утаа май тавих замаар сүнсийг тэнгэрт дэвшүүлэх өндөрлөг ууланд байрлах халдун нь оршуулгын энэхүү зан үйл улирахад мартагдаж, улмаар утга шилжихийж *сэндийх*, *сэндий* хэмээх утгатай болж хадгалагдсан бололтой байна. Энэ үг халдуны нэг адил ха-

лах, гал хэмээх утга илэрхийлэх дээр нь хэвтэх, суух зориулалт бүхий *кан* (халуун ханз) – аас гаралтай бөгөөд монгол хэлэнд дээр нь суух утга илэрхийлэх *санда* хэмээх үг ийнхүү үүсчээ. Эндээс *сэндийх*, *сэндий*, *сэнтий* гэх үгнүүд салаалсан бөгөөд өнөөгийн бидний Бурхан Халдун гэж итгэж байгаа уул маань үзэгдэх байдал, тэнгэрлэг төрхөөрөө үнэхээр ялгардаг учир хаан төрийн билгэ өргөн далбат исэр, сэнтий хэмээх утгатай болжээ. Монгол хэлний S гийгүүлэгч нь Буриад хэлний Ага, Алар, Барга, Эхирид-булагад, Хори аялгуунд сул шүргэх h-ээр, Сартуул, Цонгоол, Хорчин, Жалайд, Дөрвөд аялгуунд хамжих d, t-гээр, Монгол хэлэнд хамжин шүргэх dz-гээр хэлэгдэж байна. Сахал –haxal, шөнө- hǒñě (Alar), hǔñi (Aga, Barg), сүх – hǔxe (Bur), hǔke (Tǔnk), ус – uhañ (Aga, Alar, Ekh-Bul, Khori) г.м [Төмөртоогоо, 1992:128] -ээр чөлөөтэй сэлгэдэг учир Хаан сэнтий нь Хан Хэнтий гэж дуудагдах болсон бололтой. Хан Хэнтий уул нь үнэн төрхийн хувьд хаан төрийн их билгэ исэр суудал болох хаан сэнтийг өөрийн эрхгүй санагдуулам байна.

Одоо бидэнд мэдэгдэж буйгаар Чингис хаан, хаан төрийн их сэнтийтэй салшгүй холбогдон Өндөр гэгээний үеэс «Хан Хэнтий уулын тахилга» хэмээн онцгойлон нэрлэгдсээр ирсэн нь тодорхой болоод байгаа учир уг тахилгын уламжлалыг бид эрх биш язгуурын нэрээр хадгалах нь зүйтэй санагдана. Учир иймийн тулд хаан төрийн их билгэ болсон нөгөө талаар Их Хааны онгоны нэртэй салшгүй холбоотой Хан Хэнтий уулын нэрийг буцааж сэргээх нь зүйтэй болох бизээ.

Бурхан Халдун нэр (топоним)-ийн утга нь «бурхан» гэх буддын шашны бурхан тэнгэрийн нэр, Халдун нь эрт цагт өвгөд дээдсийн шарилыг хайлуулан чандар болгох газрын цээр нэр бололтой байна. Бурхан нэрийн «бур» язгуур гээгдэж, Хан хэлбэртэй болсон. Халдуны «qala» язгууртай ойролцоо утгатай халуун ханзны «qana» язгуураас *санда*, *сандайх*, *сэнтййх*, *сэнтий* гэх мэт утга салбарлан үүнээс Хэнтий нэр үүссэн байна. Хан Хэнтий уул нь байрлал, үзэгдэх ихэмсэг төрх байдлаар үнэхээр хаан сэнтий мэт харагдах тул Монголын алтан ургийн ихэс дээдэс Их Чингис хааны төр ёсыг билэгдэж, тахисаар ирсэн юм. Тиймээс Хан Хэнтий уулыг Бурхан Халдун болгож өөрчилсөн УИХ-ын шийдвэрийн зөв, бурууг эргэн нягтлах, улмаар Хан Хэнтий нэрийг буцааж албан ёсоор сэргээх нь төр ёсны түүхэн уламжлалд үлэмж нийцтэй болох болов уу.

### Ном зүй:

Бадамхатан С. Чингис хаан: Энд би нойрсоно. УБ., 1997.

Базаррагчаа М. “Бурхан халдун” хэмээх үгийн гарал, бүтцийн онцлог // МУБИС, Монгол судлалын сургууль, Монгол судлалын чуулган. ЭШБ, Боть №11 (46), УБ., 2011.

Батболд Г. Хятан ханзан халаалтын тухайд (Чинтолгой балгаснаас илэрсэн ханзан халаалтын жишээн дээр) // Нүүдэлчдийн өв судлал. Т.ХҮ, Fasc.7. УБ., 2013

Батсайхан З., Даваа Н., Бор Ж. Их овоо Чингис хааны булш мөн үү // Mongolian Journal of Anthropology, Archaeology and Ethnology, Vol.3, № 1 (287): (2007)

Болдбаатар Ю. Боржигин нэрийн тухай // Mongolica. Vol.14 (35) УБ., 2004.

Бродянский Д.Л. Кроуновско-хуннские параллели // Древнее Забайкалье и его культурные связи. Новосибирск, 1985.

Гаадамба Ш. Монголын нууц товчоо. УБ., 1990.

Дэсрид Санжаажамц. Газрын шинжийн монгол судар II. УБ., 2017. (орчуулсан Б.Няммягмар)

Давыдова. А.В. Иволгинское городище (К вопросу о гуннских поселениях в Забайкалье) // Советская археология. Т. XXV.1956.

Деревянко Е.И. Древние жилища Приамурья. Новосибирск, 1991.

Дулам С. Домог зүйн дүр. УБ., 1989.

Кызласов И.Л. Новые поиски в алтаистике. II. Археологические разработки // Древности Сибири и Центральной Азии // Горно-Алтайск, ГАГУ, 2009. № 1-2 (13-14)

Лувсанданзан. Эртний хаадын үндэслэсэн төр ёсны зохиолыг товчлон хураасан Алтан товч хэмээх оршвой. Монгол бичгээс хөрвүүлж, оршил бичиж, харгуулан тайлбар хийсэн Ш.Чоймаа // Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал. УБ., 2006.

Манжаас халхын Хэнтий хан уулыг тахиx болсны тухай // ШУА-ийн ТАХ-ийн БМТ.х 3,д 1, хн-923 а

Монгол ардын нам хэмээх сэтгүүл. 12-р дугаар дэвтэр. Монгол улсын 18-р он 3-н сард. Улаанбаатар хот дахь монгол үсгийн хэвлэлийн хороо (монгол бичгээр).

Өлзийбаяр. Монголын нууц товчоон дахь “Ихэсийн газар”-ын талаар цөөн хэдэн үг // Studia Historica. Tom. XL. fasc. 5. УБ., 2011.

Өлзийбаяр С. Ч(Т)угин хийгээд Чингис нэрийн учир // Studia Historica. Tom XLIII.Fasc.4. УБ., 2015.

Пунсаг А. Монголын нууц товчооны судалгаа. УБ., 2008.

Пэрлээ Х. “Их хориг” хаана байна // SM.Tom.IV, Fasc 10-21

Төмөртогоо Д. Монгол хэлний түүхэн хэлзүй. 1. УБ., 1992.

Төрбат Ц., Батсүх Д., Пуса Н., Рамзайер Д. Хүннүгийн үеийн Бороогийн сууринд хийсэн судалгаа // Талын их эзэнт гүрэн-Хүннү. Монгол-Солонгосын хамтарсан судалгааны 10 жилийн ойн симпозиум. National Museum of Korea. Seoul, 2008

Ууганбаяр М. “Бурхан нь мөн оршуулгын газар гэсэн утгатай байх ёстой хэмээн санана” // Улаанбаатар сонин, 1994, №139 (598)

Хоёр загалын тууж. Ц.Дамдинсүрэн хэвлэлд бэлтгэв. Б.Содном редакторлов. ШУХ-ийн хэвлэл, УБ., 1956.

Хаадын үндсэн хураангуй Алтан товч. Монгол бичгээс хөрвүүлж, оршил бичиж, харгуулан тайлбар хийсэн Ш.Чоймаа // Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал. УБ., 2006.

Цагаан түүх. // Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал. УБ., 2006.

Цэвэл Я. Монгол хэлний товч тайлбар толь. УБ., 1966.

Igor de Rachewiltz. Index to the Secret History of the Mongols // Indiana university publications Uralic and Altaic series. Vol.121. 1972

Rashîd âl-Dîn Fazl Âllâh Hamadânî. *Jâmi' âl-tâwârîx*. Tashîh Muhammed Rûshan, Mustafî Mûsavî. J. I, Tehran, 1383. (Д.Анхбаярын орчуулснаар)

### References:

Badamhatan S. CHingis haan: End bi nojrsono. UB., 1997.

Bazarragchaa M. “Burhan haldun” hemeekh үгийн гарал, бүтэйн онцлог // MUBIS, Mongol sudlalyn surguul’, Mongol sudlalyn chuulgan. ESHB, Bot’ №11 (46), UB., 2011.

Batbold G. Hyatan hanzan halaaltyn tuhajd (CHintolgoj balgasnaas ilersen hanzan halaaltyn zhisheen deer) // Nyudeldchdijn ов sudlal. T.XY, Fasc.7. UB., 2013

Batsajhan Z., Davaa N., Bor ZH. Ih ovoo CHingis haany bulsh men үг // Mongolian Journal of Anthropology, Archaeology and Ethnology, Vol.3, № 1 (287): (2007)

Boldbaatar YU. Borzhigin nerijn tuhaj // Mongolica. Vol.14 (35) UB., 2004.

Brodyanskij D.L. Krounovsko-hunnskie paralleli // Drevnee Zabajkal’e i ego kul’turnye svyazi. Novosibirsk, 1985.

Gaadamba SH. Mongolyn nuuc товчоо. UB., 1990.

Desrid Sanzhaazhamc. Gazryn shinzhijn mongol sudar II. UB., 2017. (orchuulsan B.Nyammyagmar)

Davydova. A.V. Ivolginskoe gorodishche (K voprosu o gunnskih poseleniyah v Zabajkal’e) // Sovetskaya arheologiya. T. XXV.1956.

Derevyanko E.I. Drevnie zhilishcha Priamur’ya. Novosibirsk, 1991.

Dulam S. Domog зүйн дүр. UB., 1989.

Kyzlasov I.L. Novye poiski v altaistike. II. Arheologicheskie razrabotki // Drevnosti Sibiri i Central’noj Azii // Gorno-Altajsk, GAGU, 2009. № 1-2 (13-14)

Luvсанданзан. Ertний хаадын үндэслэн төр Yosny zohiolgyg товчлон хураан Алтан товч hemeekh оршвож. Mongol бичгээс хөрвүүлж, оршил бичиж, харгуулан тайлбар хийсэн Ш.Чоймаа // Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал. UB., 2006.

Manzhaas halhyn Hentij han uulyg tahih bolsny tuhaj // SHUA-ijn TAH-ijn BMT.h 3,d 1, hn-923 a

Mongol ардын нам hemeekh setgyyl. 12-r dugaar devter. Mongol улсын 18-r on 3-n sard. Ulaanbaatar hot dah’ mongol үсгийн hevlelijн horoo (mongol бичгээр).

Өлзийбаяр. Mongolyn nuuc товчоон даг’ “Ihesijn gazar”-yn талаар cөөн хеден үг // *Studia Historica*. Tom. XL. fasc. 5. UB., 2011.

Өлзийбаяр S. CH(T)igin hijgeed CHingis nerijn uchir // *Studia Historica*. Tom XLIII.Fasc.4. UB., 2015.

Punsag A. Mongolyn nuuc товчооны судалгаа. UB., 2008.

Perlee H. “Ih horig” haana bajna // SM.Tom.IV, Fasc 10-21

Tөмөртөгөө D. Mongol helnij түүхэн helzyj. 1. UB., 1992.

Tөрбат C., Batsyh D., Pusa N., Ramzajer D. Hынныгijn yeijn Boroogijn suurind hijsen судалгаа // Tалын ih ezent гырен-Hынны. Mongol-Solongosyn hamtarsan судалгааны 10 zhilijn ojn simpozium. National Museum of Korea. Seoul, 2008

Ууганбаяр M. “Burhan n’ mөн orshuulgyn gazar gesen utgataj bajh yostoj hemeen sanana” // *Ulaanbaatar sonin*, 1994, №139 (598)

Hoyor zagalyn tuuzh. C.Damdinsyren hevleld beltgev. B.Sodnom redaktorlov. SHUH-ijn hevlel, UB., 1956.

Haadyn yndsen huraanguj Altan товч. Mongol bichgees hөrvyylyzh, orshil bichizh, harguulan tajlbar hijsen SH.CHOjmaa // Mongolyn түүхэн survalzh bichgijn cuvral. UB., 2006.

Cagaan түүх. // Mongolyn түүхэн survalzh bichgijn cuvral. UB., 2006.

Cevel YA. Mongol helnij товч tajlbar tol’. UB., 1966.

Igor de Rachewiltz. Index to the Secret History of the Mongols // Indiana university publications Uralic and Altaic series. Vol.121. 1972

Rashîd âl-Dîn Fazl Âllâh Hamadânî. Jâmi’ âl-tâwârîx. Tashîh Muhammed Rûshan, Mustafî Mûsavî. J. I, Tehran, 1383. (D.Anhbayaryn orchuulsnaar)

**ЭТНОГРАФИЯ  
ETHNOGRAPHY****МРНТИ 68.01  
УДК 636****Рэгдэл Д.,<sup>1</sup> Энхтуяа Б.<sup>2</sup>**

Монгол улсын ШУА-ийн ерөнхийлөгч, академич<sup>1</sup>  
Монгол улсын ШУТИС-ийн профессор, химийн шинжлэх ухааны доктор,  
профессор<sup>2</sup>

**БЭЛЧЭЭРИЙН МОНГОЛ МАЛЫН МАХ<sup>1</sup>**

Бэлчээрийн монгол малын махны хүнс тэжээлийн болон биологийн үнэт чанарын судалгааны дүнг эмхэтгэн, бусад улсад үржүүлдэг малын махны үзүүлэлттэй харьцуулан үнэлэлт дүгнэлт өгөх хэлбэрээр туурвисан энэхүү монографийг хүнс, хөдөө аж ахуй болон нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр сургалт, судалгаа-шинжилгээний ажил эрхэлдэг багш, судлаач, эрдэм шинжилгээний ажилтан, мал аж ахуйн салбарын мэргэжилтэн, салбарын бодлого боловсруулах, шийдвэр гаргах түвшнийхэнд зориулав.

**Түлхүүр үгс:** Монгол малын мах, тэжээллэг, биологийн үнэ цэнэ

**IRSTI 68.01  
UDK 636****Regdel D.<sup>1</sup>, Enkhtuya B.<sup>2</sup>**

Doctor of Chemistry, Academician, President of the Academy  
of Sciences of Mongolia,<sup>1</sup>  
Doctor of Chemistry, Professor, Mongolian National University of Sciences,<sup>2</sup>

**MONGOLIAN PASTURE MEAT**

(Дүгэрийн РЭГДЭЛ, Батсүхийн ЭНХТУЯА БЭЛЧЭЭРИЙН МОНГОЛ  
МАЛЫН МАХ. - Улаанбаатар, «СОЁМБО ПРИНТИНГ» ХХК,  
2012 он.- 296 хуудас, 91 хүснэгт, 54 зураг, 41 хавсралт хүснэгт)

This monograph, compiled by research on nutritional and biological value of Mongolian livestock meat and evaluated in comparison with meat of breeding

<sup>1</sup> Дүгэрийн РЭГДЭЛ, Батсүхийн ЭНХТУЯА БЭЛЧЭЭРИЙН МОНГОЛ МАЛЫН МАХ. - Улаанбаатар, «СОЁМБО ПРИНТИНГ» ХХК, 2012 он.- 296 хуудас, 91 хүснэгт, 54 зураг, 41 хавсралт хүснэгт

animals in other countries, is a monograph by teachers, researchers and researchers in the field of food, agriculture and field health. analysts, livestock professionals, and policy makers.

**Keywords:** Mongolian livestock meat, nutritional and biological value

**МРНТИ 68.01**

**УДК 636**

**Рэгдэл Д.,<sup>1</sup>Энхтуяа Б.<sup>2</sup>**

д.х.н., академик, Президент Академии наук Монголии,<sup>1</sup>  
д.х.н., профессор, Монгольский национальный университет<sup>2</sup>

### **МЯСО ПАСТБИЩНОГО СКОТА МОНГОЛИИ**

(Дүгэрийн РЭГДЭЛ, Батсүхийн ЭНХТУЯА БЭЛЧЭЭРИЙН МОНГОЛ  
МАЛЫН МАХ.- Улаанбаатар, «СОЁМБО ПРИНТИНГ» ХХК,  
2012 он. - 296 хуудас, 91 хүснэгт, 54 зураг, 41 хавсралт хүснэгт)

Эта монография, составленная на основе исследования питательной и биологической ценности мяса крупного рогатого скота в Монголии с мясом племенных животных в других странах, дана оценка и проведен сравнительный анализ. Представляет собой монографию, исследователей в области пищевых продуктов, сельского хозяйства и здравоохранения.

**Ключевые слова:** мясо крупного рогатого скота Монголии, пищевая и биологическая ценность.

Бид манай орны мал аж ахуй (МАА), махны үйлдвэрлэлийн тулгамдсан болон онцлог зарим асуудал, тэдгээрийг шийдвэрлэхдээ уг салбарын даяаршлын орчин дахь хөгжлийн нийтлэг болоод шинэлэг чиг хандлагатай уялдуулан авч үзэх боломжийн талаар өөрсдийн үзэл санаа, байр сууриа товчхон илэрхийлэх нь зүйтэй гэж үзсэн юм.

Өнөөгийн монгол нутагт зэрлэг амьтан гаршуулан, амьдрал ахуйдаа ашиглаж эхэлснээс хойш 5000 орчим жил өнгөрч байгаа талаар зарим судлаач эрдэмтэд тэмдэглэсэн байдаг. Гэхдээ морьтон дайчдаараа алдаршсан хүннүчүүд Дотоод Ази хэмээн нэрлэгдэж байсан Евразийн их тал нутгийн зүүн хагаст буюу одоогийн Монголын нутагт 24 аймгийн холбооноос тогтсон хүчирхэг гүрнийг манай эриний өмнөх IV зуунд байгуулж байсан тухай түүхэн баримт байдаг болохоор монгол нутагт мал маллаж эхэлсэн цаг түүх 5 мянган жилээр хязгаарлагдахгүй нь тодорхой юм [Гумилев, 1997]. Тэгэхлээр одоогоос хамгийн наад тал нь 6000-аас цааш жилийн тэртээ гэрийн тэжээмэл амьтан бий болж, өвөг монгол угсаатан, овгуудын дотор «мал» хэмээх ойлголт хэдийнээ бүрэлдэн тогтчихсон байсан байж таарна.

Өнгөрсөн зууны 30-аад он буюу монгол мал, мал аж ахуйг ЗХУ (хуучин нэрээр)-ын эрдэмтдийн өргөн оролцоотойгоор орчин үеийн шинжлэх ухааны арга, аргачлалаар судалж эхэлсэн цагаас хойш «мал» хэмээх нэрийн өмнө «гэрийн тэжээмэл» гэх илүүц тодотгол оруулах болсон нь европ сэтгэлгээний гадаад нэр томъёог хэт махчлан орчуулж хэрэглэснээс улбаалан бий болсон алдааны нэг юм. Монгол хүний хувьд гэрийн эсвэл хээрийн мал гэх ухагдахуун огт байхгүй агаад тухайн ойлголт нь мал бол аль нэгэн субъект (ноёны, жасын, коммуны, нэгдлийн, ардын, иргэний)-ын өмч, малчны хараа хяналт, ивээл додомд ашиг шимээ өгч байдаг амьтан гэдгийг аяндаа илэрхийлж байдаг билээ.

Харин «бэлчээрийн», «бэлчээрийн монгол» зэрэг тодотгол бол монгол малын мөн чанар, онцлог, түүнээс гарах бүтээгдэхүүний брэнд байдлыг илтгэх учраас тэдгээрийг элдэв нарийн тайлбаргүйгээр дэлхий даяар ойлгогдох болтол нь хүн төрөлхтний тархи толгойд, яг Coco-Cola шиг болтол нь суулгаж өгч чадвал манай МАА хөгжлийн ирээдүй, монголчууд бидний эрх ашигт бүрнээ нийцсэн үйл хэрэг болох нь дамжиггүй. Энэ бол нийгмийн цар хүрээгээрээ маш чухал асуудал бөгөөд түүнийг хэрэгжүүлэхийн тулд бидэнд хийх ажил асар их байгаа нь дэлхий дахины МАА, махны үйлдвэрлэлийн чиг хандлага болоод манай улсад энэ талаар баримталж буй төрийн бодлого, мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний судалгааны өнөөгийн байдал, малын гаралтай түүхий эдийн боловсруулалтын түвшин, энэ салбарын доторх бизнесийн төдийгүй, гадаад, дотоодын эерэг, сөрөг сонирхол сэлтээс илэрхий харагдана.

Иймд манай уламжлалт МАА болон түүнтэй шууд холбоотой үйлдвэрлэлийн бусад салбарын хөгжил бол зөвхөн бидний дотоод асуудал биш юм. Өнөөдөр дэлхий дээр бодитой оршин байгаа соёл иргэншлийн 2 үндсэн хэлбэрийн нэг бол нүүдлийн соёл иргэншил бөгөөд түүнийг унаган төрхөөр нь өдийг хүртэл авч яваа цөөхөн орны нэг нь манай улс байдаг. Нэг талаас, тэрхүү соёл иргэншлийг тээгч үндсэн элементүүд нь манай орны хувьд нүүдлийн МАА-д орших тул уламжлалт МАА-гаа хадгалан үлдэх, зах зээлийн шаардлагад нийцүүлэн хөгжүүлэх явдал бол бидний зүгээс нийт хүн төрөлхтний өмнө хүлээж байгаа үүрэг гэж үзэж болно. Өөрөөр хэлбэл, бидний тухайд даяаршлын орчилд өөрийн онцлогоо хадгалан ондоошиж орших нэг гол эх сурвалж бол манай уламжлалт нүүдлийн мал аж ахуй, түүний тогтвортой хөгжил байж болох магадлалтай.

Нөгөө талаас, улам бүр эрчимжиж байгаа даяаршлын давалгаанаас тийрэгдэн хаягдчихгүйн тулд дэлхийн хөгжлийн нийтлэг чиг хандлагыг баримжаалан, улс орныхоо өрсөлдөх чадварыг байнга дээшлүүлж байх шаардлага жилээс жилд улам нэмэгдэх нь тодорхой. Эдгээр учир шалтгааны улмаас хөгжлийн энэхүү 2 шаардлагын уулзвар дээр уламжлалт мал аж ахуйн түүх-соёлын болоод нийгэм-эдийн засгийн ач холбогдлыг Монгол орны экосистемүүдийн тэнцвэрийг хадгалж үлдэх асуудалтай уялдуулан зохицолдуулсан шинэ бодлого боловсруулан хэрэгжүүлэх замаар манай

МАНСА салбарын урт хугацааны тогтвортой хөгжлийн суурь үндсийг шинээр бий болгох бодит нөхцөл бүрдээд байгаа төлөв байдал харагдаж байна.

Одоогийн түвшинд бид мал аж ахуйн салбарынхаа бүхий л талын ач холбогдлыг олон үзүүлэлтээр гаргаж болох боловч, Монголын бэлчээрийн МАНСА тухайд нь нэн тэргүүний ээлжинд анхаарал хандуулваас зохилтой хэд хэдэн онцлог асуудал байна гэдэг нь энэ монографийг бичих явцад улам тодорхой болж байна. Үүнд:

**Нэгдүгээрт**, энэ салбар бол улсын хэмжээнд хамгийн том ажил олгогч. Манайд эрдэс баялаг, уул уурхайн салбар асар хурдан тэлж, эрчим хүчний хэрэглээ эрс нэмэгдэж байгаа хэдий боловч, ажиллах хүчний тоогоороо МАНСА салбар ойрын ирээдүйд тэргүүлэх байр сууриа хадгалсаар байх нь тодорхой байна. Өнөөдөр манай улсын 170 мянга гаруй малчин айл хамгийн багаар бодоход 400 шахам мянган хүнийг ажилтай байлгаж, 800 гаруй мянган хүний нийгмийн асуудлыг зохицуулж байгаа гэсэн ерөнхий тооцоо гаргахад нэг их хол зөрөхгүй байх. Энэ утгаар нь авч үзвэл МАНСА салбарын нийгмийн ач холбогдлыг бүрэн үнэлэхэд бэрх. Үүний зэрэгцээ эдийн засаг, нийгмийн бусад салбартай харьцуулахад энэ салбар нь жендерийн асуудлаа өөрөө хөдөлмөрийн харьцаагаараа зохицуулаад явчихдаг болохоор төрийн зүгээс нэмэлт зохицуулалт, зардал бараг шаардагдаад байдаггүй онцлогтой.

Харин түүний ДНБ-д эзлэх хувь хэмжээ, бүтээмжийн тухайд бол тусдаа асуудал. Эдийн засгийн утгаараа МАНСА салбарын ирээдүйн хөгжлийн асуудлын нэг зангилаа нь энд ч байж мэднэ.

**Хоёрдугаарт**, хамгийн олон ажлын байрыг хадгалан авч явдаг хэрнээ бодит эдийн засгийн бусад салбартай харьцуулахад шинээр ажлын байр бий болгох шууд зардал маш бага. Гэхдээ өнөөг хүртэл ажлын байр нэмэгдэх, хорогдох нь төрийн оролцоо багатай, үндсэндээ байгаль, цаг уурын ааш, аягаар зохицуулагдаж ирсэн, тухайн бүс нутагтаа тохиолдлын шинжтэй, хязгаарлагдмал байсаар байна. Ер нь нүүдэлчдийн улс, гүрнүүдийн мандан бадрал, уруудал доройтол нь хамгийн өргөн утгаараа уур амьсгалын өөрчлөлтөөс бүрэн хамааралтай явж ирснийг өнгөрсөн түүх гэрчилдаг.

Сүүлийн 2000 жилийн хугацаанд Евразийн тал нутгийг нэлэнхийд нь хамарсан их ган 3 удаа буюу III, X, XIV зуунд тохиосон байх бөгөөд тухай бүрд нь ихээхэн газар нутаг хоосорч, хүн ам нь үхэж үрэгдэн, тархаж сарнисны улмаас Евразийн улс төрийн газрын зурагт томоохон өөрчлөлтүүд орж байсан гэдэг [Гумилев, 1967]. Хүннүгийн хоёрдох уналт, түүнээс хойших Евразийн улс төрийн ландшафтын томоохон өөрчлөлтүүд эдгээр их гантай хугацааны хувьд үндсэндээ давхацдаг байна. Эндээс, хуурай сэрүүн бүс нутагт нүүдлийн МАНСА дагнан болон зонхилон эрхэлж ирсэн улс гүрнүүдийн хүчирхэгжил, хөгжлийн явцыг хязгаарлагч хамгийн гол хүчин зүйл бол уур амьсгал, цаг уурын нөхцөл нь байсан ба энэ ерөнхий зүй тогтол одоо ч гэсэн үйлчилсээр байна гэдгийг ойлгоход тийм ч хэцүү биш юм.

Харин XXI зууны Монгол улсын МАНСА нь эдийн засагт зонхилох салбар байхаа больж, эзлэх хувь хэмжээ нь жилээс жилд багасах нь улам бүр тодорхой

болж байгаа болохоор дээрх зүй тогтол манайд одоо шууд үйлчлэхгүй байх магадлал нэмэгдэж байна. Гэхдээ энэ нь манай улсын хөгжил уур амьсгалын өөрчлөлтөөс хамааралгүй болчихно гэсэн үг бас биш юм. Цаана нь түүнээс хамааралтай хөрсний элэгдэл доройтол, гадаргын болон гүний усны хомсдол, усалгаатай болон усалгаагүй газар тариалангийн хөгжил, хүн амын нүүдэл суудал, байршил гээд мөнхийн гэмээр амаргүй асуудлууд байсаар л байх болно.

Мөнтүүнчлэн нүүдлийн МАА нь бүтээмжийн хувьд угаасаа хязгаарлагдмал болохоор Монгол хүний хүнсний бүтцийн онцлог болоод аюулгүй байдлыг баталгаатай хадгалах, хангах, МАА-гаа орчин үеийн нөхцөлд нийцүүлэн авч явахын тулд хөгжлийн шинэ бодлого зайлшгүй шаардлага болон тавигдах нь мэдээж хэрэг. **Ийм бодлогын үндэс нь төр(улс)-ийн байнгын татаас(дотаци)-тай, мэргэжлийн малчнаар зонхилон хангагдсан бэлчээрийн (нүүдлийн) МАА бий болгох замаар түүний тогтвортой хөгжил, уламжлалыг хадгалан авч явахад оршиж болох талтай.** Энэ тохиолдолд ажлын байр бий болгох зардал нилээд нэмэгдэх хэдий ч улс орны нийтлэг эрх ашгийн үүднээс нэг мөр шийдэл гаргах ёстой асуудал юм.

**Гуравдугаарт,** монгол малын махан ашиг шим бий болох шууд болон шууд бус зардлыг байж болох доод хэмжээнд нь хүргэж барих нь салбарын тогтвортой хөгжлийн тулгуур асуудлын нэг юм. Манай орны нийт бэлчээрийн эдэлбэр газар нь хонин толгойд шилжүүлснээр 60-70 сая малыг өвс тэжээлээр хангах боломжтой гэж үздэг авч, бэлчээр нутгийн жил жилийн даацыг өөрчилж байдаг хүчин зүйлсийн нөлөөллийг тооцох боломж, чадавхи тэр бүр байдаггүй болохоор салбарын хөгжлийг нарийвчлан төлөвлөхөд амаргүй. Нөгөө талаар, нүүдлийн МАА-д нэгж бүтээгдэхүүнийг хямдхан зардлаар бий болгодог гэсэн ташаа ойлголт амь бөхтэй оршоор байгаа нь салбарын цаашдын хөгжилд сөрөг нөлөө үзүүлж мэдэх магадлал бүхий хүчин зүйлсийн нэг.

Манай ХАА салбарын эрдэмтэн судлаачдын олон жилийн судалгааны материалаас [Малын тэжээл..., 2012] ургуулан тооцоолоход, монгол (халх) хонины махан ашиг шим бүрдэх өртгийн талаар дараахи дүгнэлт хийж болохоор байгаа юм. Үүнд, нас гүйцсэн монгол эм хонь хоногт ойролцоогоор 3,45 кг ногоо (7 дугаар сарын ботууль-алаг өвст бэлчээрийн ногоонд шилжүүлснээр) идэх бөгөөд 4,5 насандаа эрчимтэй өсөлт нь саарч нядалгаанд ордог гэж үзвэл нэг хонь энэ бүх хугацааны туршид (нийтдээ 54 сар) 5680 гаруй кг өвс ногоо хэрэглэхээр байна. Энэ хугацаанд ясгүй тураг мах (гадар өөх орно)-ны хэмжээ нь 1,3 кг (нялх хурга)-аас 17,7 кг болж махны цэвэр нэмэгдэл 16,4 кг болно [Хонь судлал..., 2011]. Өөрөөр хэлбэл, насан туршийн хэрэглээгээр нь тооцвол 4,5 настай монгол эм хонь дунджаар 346 кг бэлчээрийн өвс ногоо идэж байж 1 кг цэвэр тураг мах бий болгож байна. 20 кг-ын боодол өвсний өөрийн өртгийг 1750 төгрөг гэж үзвэл 1 кг мах бүрэлдэхэд 30000 орчим төгрөгний өвс ногоо шаардагдана гэсэн үг. Дээр нь гэр бүлийн 2 хүний хөдөлмөр, нэг хонины хоногийн дунджилсан

хэрэглээний 3,2 л [Малын тэжээл..., 2012], нийт 4,5 жилийн хэрэглээний 5250 л цэвэр усны үнэ цэнэ (үйлдвэрлэлийн хэрэглээгээр тооцвол 5250007) болоод нүүдлийн МАА-гаас экосистемд учруулж буй дарамтыг нэмж тооцвол 1 кг махны бодит өртөг аль хэр өндөр болох нь харагдана.

Ийм болохоор манай эрдэмтэд МАА салбарын нэгж бүтээгдэхүүнд ногдох зардлыг бууруулах талаар шинжлэх ухааны үндэслэл, баталгаатай олон чухал дүгнэлт, зөвлөмж, технологи боловсруулсны зарим нь хязгаарлагдмал хүрээнд ашиглагдаж байгаа боловч ихэнх нь нийгмийн шилжилтийн он жилүүдэд мартагдах тийшээ явж байгаа юм, харамсалтай нь. Энэ чиглэлээр манай эрдэмтдийн хийсэн өргөн хүрээтэй судалгааны ажлын нэгээхэн хэсэг нь манайд үржүүлдэг бэлчээрийн болоод хагас суурин маллагаатай бүх төрөл, үүлдэр, үүлдрийн хэсгийн малын махан ашиг шим бүрдэх динамикийг тухайн малын наснаас хамааруулан, Монгол орны байгаль-цаг уурын бүс бүрээр нарийвчлан тогтоож өгсөн явдал юм.

Эдгээр судалгаанаас үйлдвэрлэлийн зардлыг бууруулах нэг гол арга бол мал нядлах насыг оновчтой тогтоох явдал гэдэг нь тодорхой харагддаг. Ганц жишээ татахад, монгол хонины махан ашиг шим төрснөөс хойших эхний 18 сард хамгийн эрчимтэй нэмэгдэх бөгөөд ийм шүдлэн болон нас гүйцсэн эм хониноос авах цэвэр тураг махны хэмжээ ердөө 5 орчим хувийн зөрөөтэй байдаг [Хонь судлал...,2011]. Эндээс, хэрвээ монгол хонийг 18 сартай шүдлэн насанд нь нядалгаанд оруулдаг болчихвол махан ашиг шимийн хувьд 5 хувийн алдагдал хүлээх боловч махны шууд өртөг дор хаяж 3 дахин буурах тооцоо гарч байна. Малыг өсвөр насанд нь нядалж хэрэглээнд оруулахын алсдаа унацтай бас нэг онцгой чухал ач холбогдол нь үйлдвэрлэлийн эргэлт хурдасч, экологид учруулах ачаалал эрс багасахад оршино.

**Дөрөвдүгээрт,** нүүдлийн МАА-н тэлэлт ба хөгжлийн бодлогыг хуурай, сэрүүн бүс нутгийн экосистемүүдийн тэнцвэрт байдлыг хангах, агаар дахь хорт болоод хүлэмжийн хийг багасгах асуудалтай уялдуулах явдал бол энэ салбарын хэтийн хөгжлийн амин чухал пиаардлага гэдэг нь улам бүр тодорхой болсоор байна. НҮБ-ын мэдээнээс [BasedonFAO...,2002], адилхан хугацаанд 1 кг мах бий болгоход шаардагдах талбай дээр 200 кг улаан лооль, эсвэл 160 кг төмс ургуулж болох бөгөөд ийм хэмжээний мах үйлдвэрлэлд 2000-3000 литр, харин 1 кг үр тарианд 100 литр ус ашигладаг нь харагдах бөгөөд, сүүний сайн

үүлдрийн нэг үнээ жилд дунджаар 4700 кг энгийн, 1600 кг хүчит тэжээл иддэг гээд бодохоор МАА салбар дахь экологийн нөөцийн ашиглалт асар өндөр, үйлдвэрлэлийн ашигт ажиллагааны бодит түвшин нам байдаг нь тодорхой юм. Үүнийг бас суурин болоод нүүдлийн МАА-гаас экосистемд учруулж буй дарамтын зөвхөн нэг хэсэг гэж үзэж болно. Дээр нь уг салбараас байгаль орчны бохирдолд оруулдаг «хувь нэмэр»-ийг заавал харгалзан үзэхээс өөр аргагүй хэмжээнд хүрээд байгааг нүүдлийн МАА\*тайГмонголчууд бид ч гэсэн бодолцох, тооцох үүрэг хүлээх нь дамжиггүй.

Японы МАА, бэлчээрийн шинжлэх ухааны үндэсний хүрээлэнгийн судалгаагаар 1 кг үхрийн мах бүрэлдэн бий болоход үүсэх нүүрсхүчлийн хий нь хэмжээгээрээ суудлын машин 250 км явах, эсвэл 100 ватт(лаа)-ын чийдэнг 20 хоног тасралтгүй асаах эрчим хүч үйлдвэрлэхэд ялгарах уг хийтэй тэнцүү болохыг тогтоосон байдаг. Дэлхий даяар хүний хүчин зүйлийн нөлөөгөөр бий болдог нийт хүлэмжийн хийний 18 хувь (нүүрсхүчлийн хийд шилжүүлэн тооцсон) МАА-ын салбараас гардаг бөгөөд энэ үзүүлэлтээрээ тээврийн салбараас даваад байгаа юм. Харин МАА салбар дэлхийн дотоодын нийт бүтээгдэхүүний ердөө л 2 хувийг үйлдвэрлэж байна.

МАА үйлдвэрлэлээс нийт метаны 37 хувь, азотын оксидуудын 65 хувь тус тус гарч байгаа нь тун ноцтой асуудал. Эдгээр хий нь агаарын бохирдолд томоохон байр эзэлдэг агаад дэлхийн дулааралд нүүрсхүчлийн хийнээс 20 дахин хүчтэй нөлөө үзүүлэгч метан нь хивэгч малын тэжээлээ шингээх физиологийн үйл ажиллагааны явцад аяндаа бий болдог, азотын оксидууд нь малын бааснаас зонхилон ялгардаг зэрэг онцлогтой. Эдгээр онцлог нь манай МАА үйлдвэрлэлтэй шууд хамааралтай тул хөгжлийн шинэ бодлогодоо заавал харгалзан үзэх нь зүй ёсны хэрэг юм.

Өөрөөр хэлбэл, мал амьд байх бүхий л хугацааны туршид эдгээр агаар бохирдуулагч, эмисси үүсгэгч хийнүүд нь биологийн зүй тогтлоороо аяндаа байнга ялгарсаар байх болно. Өнгөцхөн харахад МАА дахь метан, азотын оксидууд нь хүний үйл ажиллагаанаас хамааралгүй ялгарч байгаа мэт боловч, тэдгээр хийний ялгарлыг удирдан зохицуулах хязгаарлагдмал боломж хүн төрөлхтөнд бас бий.

Малын тоо, толгой өсөхийн хэрээр МАА-гаас дэлхийн дулааралд үзүүлэх нөлөө улам ихсэх, агаарын бохирдол, хөрсний доройтлыг нэмэгдүүлэх, урт хугацааны бэлчээрийн хэт ашиглалт бий болох зэрэг сөрөг үзэгдлүүд даамжирсаар алс хэтдээ экологийн тэнцвэрт байдалд эргэлт буцалтгүй өөрчлөлт оруулах магадлал байсаар байгаа. Тэр босгыг нэгэнт давчихсан хойно хөгжлийн тухай биш, харин энэ нутагт хүн оршин үлдэх, эс үлдэх тухай асуудалтай тулгарч таарна. Ийм учраас бид одооноос л ямарч үнээр хамаагүй махны экспорт нэмэгдүүлэх тухай биш, харин нүүдлийн аргаар үржүүлэх малын тооны зохимжит хязгаар тогтоох, сүргийн зөв бүтэц бий болгох, мал сүргээ бүрэн эрүүлжүүлэх талын асуудлуудаа ярьж, шийдвэрлэж, шат дараатай хэрэгжүүлж эхлээд явмаар байгаа юм.

Ер нь хуурай, сэрүүн бүсийн манайх шиг улс махыг түүхий эд хэлбэрээр экспортлогч орон болох гээд байх онцын шаардлагагүй бөгөөд харин өндөр технологийн боловсруулах үйлдвэртэй болж, тусгай зориулалтын, өндөр үнэтэй, багаахан хэмжээний бэлчээрийн малын махыг гадаадад гаргадаг болох стратегид түлхүү ач холбогдол өгвөл дэлхийн тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд нийцэмжтэй байх учиртай. Өөр зам байхгүй гэдэг нь дэлхийн олон улс орны хөгжлийн түүх, олон мянган эрдэмтэн судлаачдын өргөн цар хүрээтэй, гүн гүнзгий судалгааны ажлуудын үр дүнгээр батлагдаад байна шүү дээ.

Манай эрдэмтэд сүүлийн жилүүдэд ашиг шимээр арвин, бүтээмж ихтэй үүлдрийн малын биологийн чадавхийг бүрэн ашиглах зорилгоор мах, сүү, ноосны чиглэлээр төрөлжсөн, эрчимжсэн аж ахуйнуудыг байгуулах асуудлыг нилээд судалж байгаа бөгөөд хэмжээ, далайц багатай, технологийн түвшний хувьд анхан шатны суурин мал аж ахуйн эхлэл тавигдаж байна [Минжигдорж, 2012]. Ийм хэлбэрийн аж ахуйнуудыг торниулан бойжуулж томруулах, бүрэн утгаараа үйлдвэржсэн хэлбэрт шилжүүлэх замаар харин томоохон хот, суурин газрын хүн амын хэрэглээ, экспортын түүхий эдийн өсөлтийн зонхилох хэсгийг хангах нь зөв шийдлүүдийн нэг байж болох талтай. Аль ч тохиолдолд мал сүргээ эрүүлжүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангах асуудал тэргүүн ээлжинд тавигдах нь дамжиггүй бөгөөд УИХ-аас батлан хэрэгжүүлж байгаа мал аж ахуй болон малчдын талаар төрөөс баримтлах бодлогын баримт бичгүүд, « Монгол мал» хөтөлбөрийн хүрээнд энэ ажлын нилээд хэсгийг нугалах боломжтой гэдэгт судлаач бид итгэлтэй байна.

**Тавдугаарт,** малын тоо толгойг хэт нэмэгдүүлэхгүйгээр энэ салбарын бүтээмж, ашигт ажиллагааны түвшин, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх нэг зам бол өндөр технологийн, бага, дунд оврын үйлдвэрүүд байгуулах явдал юм.

Энэ асуудлын хүрээнд монгол малын мах, сүү, малын гаралтай бусад дайвар, дагавар түүхий эд, бүтээгдэхүүний хувьд нарийвчлан судлах, манай орны нөхцөлд тохирсон гүн боловсруулалтын технологиудыг бий болгох, биологийн үнэ цэнийг нь орчин үеийн шинжлэх ухааны түвшинд бүрэн дүүрэн гаргаж тавих, тэдгээр нь экологийн цэвэр түүхий эд болохыг бүх талаар нь баталгаажуулах зэрэг чиглэлээр хийх, шийдвэрлэх их ажил хүлээгдэж байгаа нь бидний судалгааны үр дүнгээс харагдаж байна.

Дашрамд тэмдэглэхэд, дайвар, дагавар түүхий эд гэж бидний яриад, бичээд сурчихсан маань бас л харь хэлнээс шууд орчуулан авсан ойлголт бөгөөд монгол малчин хүний хувьд тэдгээр түүхий эдийг хоёрдугаар зэргийн юм гэж ялгаварлан гадуурхахгүйгээр дийлэнхийг нь дотор мах гэж нэрлэн, өөр өөрт нь тохирсон аргаар боловсруулан хэрэглэж ирсэн баялаг уламжлалтай билээ. Малын гадар, дотор махыг бэлтгэх, боловсруулах, хэрэглэх тэрхүү уламжлалаа хадгалах, орчин үеийн нийгмийн болоод технологийн хөгжилд нийцүүлэн шинэчлэх, гадаад, дотоодын хэрэглэгчийн онцлогт тааруулан өөрчлөх чадавхиа байнга дээшлүүлж баймааж л бид өөрийн онцлогт тохирсон орчин үеийн үйлдвэрлэлийн технологийг зүгширүүлж, хаана ч хүлээн зөвшөөрөгдөхүйц брэнд бий болгож байх багтай суурьтай болж авна.

Үүнд ерөнхийдөө уламжлалт технологи, арга ажиллагаагаа судлах, хамгийн гол нь тэрхүү брэндүүдийн суурь материал болдог түүхий эдээ нарийвчлан судалж, шинэ мэдлэг, мэдээллийг тасралтгүй үйлдвэрлэж байх асуудал багтана. Энэ чиглэлээр давын өмнө шийдвэрлэж болох, хийх шаардлагатай ажил үйл, гүнзгийрүүлэн судлуштай асуудал цөөнгүй байгаагийн заримаас тоймлон авч үзье.

Өнөөгийн Монгол орны мал сүргийн зонхилох хэсгийг бүрдүүлж байгаа нутгийн үүлдрийн таван хошуу мал нь олон мянган жилийн байгалийн

шалгарал, малчин ардын ухамсартай селекцийн зохистой хослолын үр дүнд бий болсон хагас зэрлэг амьтад юм. Бэлчээрийн мал жилийн дөрвөн улиралд идэвхтэй хөдөлгөөнд орших тул холестерин зэрэг хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө бүхий нэгдлүүд, мөн хүнд элементүүдийг маш бага хэмжээгээр агуулдаг болохоор өөхтэй тарган мах нь ч суурин маллагаатай амьтныхтай харьцуулахын аргагүй давуу талтай байх магадлал өндөр.

Эдгээр амьтад нь манай уудам дэлгэр нутагт өөрийн тааваараа идээшлэн, өвсний сорлог, усны тунгалгийг сонгон хүртэн өсч үржиж ирсэн учраас ургамлын гаралтай биологийн идэвхит нэгдлийн баялаг эх булаг, тэдгээрийн амьд уурхай болж байдаг. Ганцхан жишээ дурьдахад, манай малчид үнсэндээ витаминь нэмэлт эх үүсвэр авдаггүй атлаа жилийн аль ч улиралд аливаа витаминь дутагдалд тэр бүр ороод байдаггүй нь бэлчээрийн малын махаа тогтмол хэрэглэдэгтэй холбоотой гэж үзэж болно. Орчин үеийн шинжлэхуаанд одоо мэдэгдэж буй бүх витаминь хоногийн хэрэгцээ болоод хүнсний голлох нэрийн түүхий эд, бүтээгдэхүүнд агуулагдах дундаж хэмжээг нэг бүрчлэн тооцож гаргасан байдаг [Raport, 1983]. Дурдаж байгаа мах, махан бүтээгдэхүүнд агуулагдах витаминь үзүүлэлт нь бүгд жинхэнэ утгаараа «тэжээвэр», буюу суурин маллагаатай малын гаралтай түүхий эдтэй холбоотой нь тодорхой юм.

Витаминь хоногийн хэрэгцээ, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд агуулагдах дундаж хэмжээний талаарх энэ хоёр бүлэг үзүүлэлтийг харьцуулаад тооцохоор, монгол хүн, ялангуяа хөдөөгийн малчид В-ийн бүлгийн зарим витаминь бусад бүх төрлийн витаминь ужиг дутагдалтай байх өндөр магадлалтай авч амьдрал дээр огт тийм биш байдгийг нэг талаас, тэдний хүнсний хэрэглэний зонхилох хэсгийг бүрдүүлэгч манай малын гаралтай хүнсний түүхий эдүүдийн макро болон микробүрдэлтэй холбож тайлбарлахаас өөр гарц одоохондоо харагдахгүй байна.

Бэлчээрийн монгол малын махны болон хүнсний үндсэн нэрийн түүхий эд, бүтээгдэхүүний цөөн зарим витаминь хэмжээг манай судлаачид тогтоосон байх бөгөөд [Raport, 1983; «Бэлчээрийн монгол..», 1996] тэдгээрт ч мөн анализ хийж үзэхэд хүний организмн витаминь орчин үеийн шинжлэх ухаанаар тогтоож өгсөн хэрэгцээг хангахад хүрэлцэхээргүй байдаг.

Гэтэл монгол хүн витаминь дутагдалд төдийлөн ороод байдаггүйн учир юунд оршино вэ? Монгол хүний витаминь хэрэгцээ бусад үндэстнийхээс бага байдаг гэж үзэх үндэслэл туйлын бага. Үүнийг харин онолын хувьд монгол малын махны бичил бүрдэлтэй холбон авч үзэх боломжтой гэсэн санааг бид дэвшүүлж байгаа юм.

Манай зарим судлаач бэлчээрийн монгол хонь зуны улиралд 570 орчим зүйлийн зэрлэг ургамал идэж тарга хүчээ авдаг гэж үздэг [Хонь судлал, 2011]. Тэдгээр ургамалд үндсэн шим тэжээлийн бодисоос гадна хоёрдогч метаболит хэмээн нэрлэгддэг олон арав (зуу)-н бодис агуулагдаж байх бөгөөд нилээд хэсэг нь биологийн идэвхит нэгдлийн бүлэгт багтдаг. Эдгээр биологийн идэвхит нэгдлийн зарим хэсэг химийн хувиралд орох боловч, зарим нь

хувиралд орохгүйгээр малын бие махбодид хуримтлагдан оршино гэж үзэх үндэслэл бий. Уг нэгдлүүд малын сүү, махаар дамжин хүний биед орохдоо 2 үндсэн үүрэг гүйцэтгэнэ. Нэгдүгээрт, эсийн дотор явагдах биохимийн урвалуудын субстрат болон зохицуулагч, хоёрдугаарт, хүний физиологи-биохимийн процессын хувьд Ипинэ мэдээлэл болох юм.

Энэхүү хоёр талт нөлөөллийн дүнд олон зуун үеэрээ ийм бэлчээрийн малын мах хэрэглэж байгаа хүмүүсийн биед дасан зохицох (зохицуулах) шинэ механизм бүрдэн бий болж, витаминь хэрэгцээг өөр түвшинд зохицуулдаг байж мэдэх юм. Хэдийгээр магадлал багатай ч, байгалийн гаралтай биологийн идэвхт олон арван нэгдлийн дотор зарим витаминь үүргийг гүйцэтгэх чадвартай шинэ бодисууд байхыг ч үгүйсгэх аргагүй.

Ийм болохоор энэхүү сонин үзэгдлийг тайлж тайлбарлахын тулд манай малын махны бичил бүрдэл дэх витамин, витамин төст бодис, витаминь үүрэг гүйцэтгэх чадвартай шинэ нэгдлүүдийг эрж илрүүлэх нь инноватив агуулгатай судалгаа байх болно. Өнөөгийн түвшинд аргагүй талаасаа ч, судалгааны зардал чирэгдэл талаасаа ч амаргүй асуудал боловч энэ чиглэлийн зорилтот судалгааны ажлыг монголчууд бид л хийх ёстой бөгөөд энэ нь монгол малын махны брэнд шинжийг илтгэх нэг үндсэн үзүүлэлт болж өгөх юм.

Монгол малын махны өвөрмөц шинж чанарыг илэрхийлдэг өөр нэг чухал үзүүлэлт бол түүнд агуулагдах биологийн идэвхт болоод өвөрмөц тосны хүчлүүд, тэдгээрийн хоорондын харьцаа юм. Суурин маллагаатай хивэгч малын махны тосны хүчлийн бүрдлийг тэжээлээр нь дамжуулан өөрчлөх замаар хүний бие махбодын дотоод хэрэгцээг зохистой түвшинд хангах чиглэлээр гадаад орнуудад асар ихээхэн хэмжээний судалгаа хийгдээд байна. Эдгээр ажил эхний шатандаа үндсэндээ малын махан дахь полиен тосны хүчлийн хэмжээг өсгөх чиглэлийг гол болгож байсан бол шинжлэх ухааны ололт, нээлт нэмэгдэхийн хэрээр эерэг тосны хүчлүүд, ооб, ю3 полиен хүчлүүдийн бүлэгт багтдаг зэрэгцээ хоёрчийн холбоот линолын хүчлийн хувь хэмжээг дээшлүүлэх, ханасан, ханаагүй хүчлүүдийн болоод зарим полиен хүчлүүдийн зөв харьцааг бий болгох талруугаа эрчимжиж байгаа юм.

Эндээс, тэжээлд нь янз бүрийн химийн бодис, бусад нэмэлт хэрэглэх аргаар суурин маллагаатай малын маханд зарим нэг нааштай өөрчлөлт оруулах боломж харагдаж байгаа хэдий ч хэт эрчимтэй шахаж бордох, тэжээлд элдэв нэмэлт хэрэглэх болсны улмаас махны байгалийн шинж чанар алдагдах, бэлчээрийн малын маханд байдаг биологийн өндөр идэвхтэй, өвөрмөц бүтэц бүхий тосны хүчлүүд алга болох, тосны хүчлүүдийн зохистой харьцаа алдагдах, орчны хүчин зүйлсийн нөлөөнд хялбар өртөмтгий болох зэрэг ноцтой үзэгдлүүд гарсаар байгааг судлаачид олон удаа тэмдэглэн бичсэн байдаг.

Сүүлийн жилүүдэд судалгааны ихээхэн сонирхолтой объект болж буй биологийн өндөр идэвхит, зэрэгцээ хоёрчийн холбоот линолын хүчил нь монгол малын булчин ба өөхлөг эдийн тосны хүчилд харьцангуй их

ZHanajdarov O. K. Religiya i mifologiya drevnih tyurkov. – Kokshetau: Izd – vo Kokshetauskogo universiteta, 2004 g. – S. 42.

Sabitov A. R., Bahmutov YU. I., Butkeeva E. V., Turganbaeva L. R. Mnimye arhitekturnye prostranstva. – Almaty: Kompleks, 2000. – S. 17.

Muhambetova A. S. Tengrianskij kalendar' kak osnova kochevoj civilizacii // V kn.: Kazhskaya tradicionnaya muzyka i XX vek. – Almaty: Dajk-Press, 2002. – S. 41.

John Collins. Klimt: Modernism in The Making. – London: Harry N. Abrams, 2001. – P. 91.

Bajpakov K. Velikij SHelkovyj put' (na territorii Kazahstana). – Almaty: Ad-amar, 2007. – S. 403.

ZHanajdarov O. K. Religiya i mifologiya drevnih tyurkov. – Kokshetau: Izd – vo Kokshetauskogo universiteta, 2004. – S. 3.


Bazaz'yanc S. B. Hudozhnik, prostranstvo, sreda. – M.: Sovetskij hudozhnik, 1983. – S. 157.

SHklyeva S. A. Istoriya iskusstv Kazahstana. – Almaty: Oner, 2011. – S.125.

Ergalieva R. A. Etnicheskoe i epicheskoe v iskusstve Kazahstana. – Almaty: ZHibek zholy, 2011. – S. 120.

Ergalieva R. A. Etnokul'turnye tradicii v sovremennom iskusstve Kazahstana. – Almaty: Gylym, 2002. – S. 172.





**Key-words:** Mongolian language, triple components in linguistics, tooth, shin and belly.

МРНТИ 16.41.25


УДК 811.512.3

### Бадамдорж Д.

д. ф. н., профессор Монгольского государственного университета  
(Монголия)

Email: badamdorj50@yahoo.com

В данной статье автором установлено, что **тройные компоненты** есть в монгольской языковой системе в работах монгольского лингвиста. Автор отмечает, что в уровнях лингвистики есть три компонента: монгольская фонетика, фонология, графемы, стилистика, лексикология, синтаксис, морфология, семантика и диалектология. Например, гласный монгольского языка состоит из трех черточек: зуба, голени и живота.



**Ключевые слова:** монгольский язык, тройные компоненты в лингвистике, зуб, голень, живот

*“Монгол бичгийн хэл нь дорно, өрнийн утга зохиолыг холбосон их хэлний нэг юм.” Ш. Лувсанвандан 1982 он.*

Монгол туургатан дорно дахин хийгээд өрнө дахины гачил дээр нүүдлийн соёл иргэншлийн орчилд бусад үндэстэнд үл давтагдах, даяаршилд эс уусах дангааршлын соёлыг бүтээсэн юм.

Монгол хүмүүн соёл иргэншиж ирсэн үйл явцад Алтай язгуурын хэлнээс салбарлан дангааршиж, монгол оюуны соёлын үнэт ололт болсон **монгол утга зохиолын хэл** үүсэн, хувьсаж, хөгжиж боловсорсон агаад мөнхүү до тоод бүтцийн байгуулалт ч улмаар цэгцэрсэн ажээ. Монгол хэлний энэхүү цэгцэрсэн **гурвал** бүтэц, тогтолцооны өөрмөц бүрэлдүүлбэрийн хэвшил тогтоц, мэдлэгийн тогтолцооны талаар монголч эрдэмтэд ажиглаж, хэлбич-


гийн ухааны бүтээлдээ тэмдэглэж иржээ. Бид сүүлийн 700 орчим жил буюу цуваа цагийн дотор монгол хэл шинжлэлийн бүтээлийг гүймэгхэн мөшгөж үзвэл, монгол хэлний үүсэл, хувьсал, хөгжил, хэвшлийн бүтэц, тогтолцооны аяндаа цэгцрэн бүрэлдсэн **гурвал бүрэлдүүлбэр** хэмээх өвөрмөц шинж буй нь илхэн байна. Монгол хэлний дотоод бүтэц, тогтолцооны бүрэлдүүлбэр гурвал /гурамсан/ байгаа явдал бидний сэтгэлгээ, танин мэдэхүй, хэл гурвын шүтэлцээний нарийн унаган тогтоц юм.

Энэхүү нарийн тогтцыг хэл шинжлэлийн олон судлаачдын бүтээлээс танилцаж болно. Хэл шинжлэлтэн, эрдэмтэн Данзандагва, Агваандандар, Ш. Лувсанвандан, Ц. Дамдинсүрэн, Б. Ринчен, Т. Пагва, Чой. Лувсанжав, С. Галсан, Д. Төмөртоогоо, М. Базаррагчаа, Ж. Надмид, Ц. Өнөрбаян, Б. Пүрэв-Очир, Ж. Санжаа, Ц. Норжин, Я. Шмидт, А. Бобровников, Б. Я. Владимирцов, В. Л. Котвич, А. Д. Руднев, Г. Д. Санжеев, Т. А. Бертагаев, Б. Х. Тодаева, З. К. Касьяненко нарын зэрэг монголч олон эрдэмтний бүтээлд эл гурвал бүрэлдүүлбэрийг тэмдэглэсэн нь бий. Монгол хэл шинжлэлийн түвшин, салбар бүрт буй **гурвал бүрэлдүүлбэрийг** авч үзье.

#### **Нэг. Авиазүй, авиалбарзүйн түвшин.**

Монгол судлалд монгол хэл шинжлэлийн судлаачид, тэдний бүтээл томхон байр суурьтай юм. Монгол хэлний авиазүй, авиалбарзүйн **гурвал бүрэлдүүлбэрийн** тухай хэл шинжлэлтэн нэлээд хэдэн тохиолдлыг тэмдэглэсэн байна. Тухайлбал:

- “...Монгол улсын үсгийг хэдрэгний дүрсээр нь **эр, эм, эрс** гурван-аар **чанга хийгээд хөндий, саармаг** гурван-аар зохиосон болай.” [Т. Паг. 1957:41]



- “**Эр, эм, эрс** хэмээн нэр өгсөн учир ану: Эр эм хоёр үсгийг нэгэн үгэнд хавсарч үл бичих бөгөөд эрс лүгээ хавсарч болохыг мэдэхийн тул буй.” [Аг. 1828:01]


- “Долоон эгшиг: Хоолойн/хэлний хойгуур/: а, о, у, хэлний дундуур: э, ө, ү, хэлний үзүүрээр: и **гурван** эгнээ байна.” (Я. Шми. 1832:06) гэжээ. “Эгшиг нь хэлний хойгуур: а, о, у, дундуур: э, ө, ү, саармаг: и **гурав**...” [Г. Д. Сан. 1953:18]

- “Өргөлт: Эхний үе: эндэ, хоёрдугаар үе: дэгүү, гуравдугаар үе: укъял” (Я. Шми. 1832:15) байна гэжээ.

- Эгшиг, гийгүүлэгчийг хэлний **урдуур, дундуур, хойгуур** гэж тус бүр **гурав** ангилав. [Б. Я. Вла. 1929:57-63]

- “**Богино** эгшиг авиалбар. Орчин цагийн монгол хэлэнд а, о, у, ө, ү, э, и гэсэн долоон богино эгшиг бий. ...**Урт** эгшиг авиалбар. Сунжруулж удаан хэлэх эгшгийг урт эгшиг гэнэ. Орчин цагийн монгол хэлэнд аа, оо, уу, ээ,

өө, үү, ий гэсэн долоон урт эгшиг авиалбар бий. ...**Хос** эгшиг авиалбар. Нэг үе болж дуудагдах хоёр өөр эгшигийг хос эгшиг гэнэ. Орчин цагийн монгол хэлний ай, уй, ой, үй, эй уруудах хос эгшиг болно.” [Орч. 1966:22-23] Эгшиг авиа богино, урт, хос гэсэн **гурвал** бүрэлдүүлбэртэй ажээ.



- Монгол хэлний урт ба хос эгшиг нь **эгшиг+гийгүүлэгч+ эгшиг (v+c+v)** уугал бүрэлдүүлбэрээс үүссэн болохыг олон монголч нар бүтээлдээ монгол бичгийн хэлийг үндэслэн тэмдэглэсэн байна. Энд (v+g+g+v, v+w+v, v+n+v, v+y+i) гэх эртний монгол хэлний **гурвал** авиа, үсгийн цогцоос өдгөөгийн урт, хос эгшиг үүссэн учраас монгол хэлний **гурвал** тогтолцоо эртний ойлголт юм. [Д. Төм.1992:84-94], [Г. И. Рам.1908:54], [Ж. Над. 1967:27-28]

- Т. Пагва монгол хэлний гийгүүлэгч авиаг **богино, урт, хос** гэж ангилжээ. “Монголч эрдэмтэн академич Б. Я. Владимировичын шинжилснээр Х, Т, Ч, Ц, Д, Х, З, Л, С, Ш зэрэг гийгүүлэгч ...уртаар дуудагддаг./34 дэх тал/ Хос гийгүүлэгч нь монгол хэлэнд Ц, Ч, ДЖ, ДЗ, КХ эдгээр юм./30 дахь тал/” [Т. Паг. 1976:30, 34] гэж үлдсэн б, в, р, м, г, к, н гийгүүлэгчийг богино гэж үзсэн шиг байна. “Монгол хэлэнд Ц, Ч, З, Ж энэ дөрвөн хэлний урдуурх **хос** гийгүүлэгчээс гадна хэлний арын КХ –ийн хос гийгүүлэгч бий.” [Т. Паг. 1959:39] Иймд монгол хэлний гийгүүлэгч авиа нь эгшгийн нэгэн адил **богино, урт, хос** гэж байгаа гэжээ. “**Урт** гийгүүлэгчид нь үгийн тэргүүн үе дэх задгай үеийн богино эгшигийг сунжруулан уртаар дуудахыг хязгаарлах, үеийн уламжлалт бүтэц, балархай эгшгийн үе бүтээх үүрэг, байрыг хэвээр хадгалахад чухал үүрэгтэй ажээ.” [Ж. Сан. 2008: 146]


- “Орчин цагийн монгол хэлний эгшиг нь эгшиг зохицох хуулиар **эр**: а, аа, ай, о, оо, ой, у, уу, уй, /ы/, **эм**: э, ээ, эй, ө, өө, ү, үү, үй, **саармаг**: и, ий гэсэн авиалбарзүйн **гурван** эгнээ бий.” [С. Гал. 1975:31] Монгол хэлний урт эгшиг нь “**1.** Аа, оо, уу, өө, үү, ээ, **2.** Яа, еэ, ёо, юу, юү, **3.** Ий, ы.” [З. К. Кась. 1968:06]

- “Хэлний гийгүүлэгч. Хэлний **үзүүрийн** гийгүүлэгч: т, д, ц, ч, з, ж, н, с, ш, л, р, хэлний **дундуурх** гийгүүлэгч: j, хэлний **угийн** гийгүүлэгч: г, х, нг, к, га.” [Орч. 1966:26] гэсэн гурвал бүрэлдүүлбэртэй.

- В. Л. Котвич “Хоолойн(хэлний арын) х, г, к **гурван** гийгүүлэгч байдаг.”[В. Л. Кот. 1902:23] гэжээ.

- Ж. Санжаа “Монгол хэлний гийгүүлэгч авиаг бүтэх аргаар нь **хамжих, шүргэх, хамжин шүргэх** гэж **гурав** ангилна. **Хамжих**: b,b', p,p', m,m', n,n', d,d', t,t', g,g', n, **шүргэх**: w,w', s,s', l,l', r,r', j, x,x', **хамжин шүргэх**: dz, dz', ts,ts'.” [Ж. Сан. 2008:144]

## ХАМЖИХ



• “Халхын аялгууны үеийн бүтэц нь: ...V+C, C+V, C+V+C зөвхөн ийм байна.” [Б. Я. Вла. 1929:417]

“Орчин цагийн монгол хэлэнд богино, урт, хос эгшиг цөм үе болдгоос гадна **эгшиг+гийгүүлэгч, гийгүүлэгч+эгшиг, гийгүүлэгч+эгшиг+гийгүүлэгч** гэсэн үеүд байдаг.” [Орч. 1966:46]

• “Дан ганц эгшгээр бүтсэн үе бол гагцхүү үгийн эхэнд тохиолдохоос үгийн дунд, адагт байдаггүй....а, аа, ай ... **Гурван зүйл** үе цөм ганц эгшгээр бүтсэн үе.” [Б. Рин. 1966:398]

• Үсгийн дүрмийн ёсоор **гурвал** бүтэц буй болсон байна. Тухайлбал, “**Ж, Ч, Ш** –ийн дараах эгшиг: 1. Эр үгийн эхний **ж, ч, ш гурвын** дараа богино и эгшиг бичихгүй, **а, о, у гурвын** нэгийг бичнэ. Жишээлбэл: Шар, чагтага, жаргалан, шороо, чоно, чухал, шугам гэх мэт. 2. Эм үгийн эхний **ж, ч, ш** –ийн дараа богино э эгшиг бичихгүй, **и, ө, ү гурвын** нэгийг бичнэ. Жишээлбэл: Жил, чимээ, ширээ, чөлөө, шөнө, жүжиг, шүдлэн гэх мэт. 3. Эр эм ямар ч үгийн дунд орсон **ж, ч, ш гурвын** дараа балархай эгшиг бичих шаардлага гарвал дандаа и эгшиг бичнэ. Жишээлбэл: Ажил, ашиг, ишиг, хөгжил, учир, дэвших гэх мэт.” [Ц. Дам. 1983:413] “Үсгийн дүрмийг тогтооход авианы зүй, үгийн зүй, уламжлал буюу түүхийн гэж ийм **гурван** үндсэн зарчмыг баримталдаг.” [Ш. Лув. 2019:36]

• “Хэлний өргөгдөх байдлаар эгшгийг **дээд, дунд, доод** гэж ангилж болно. Дээд: и, у, ү, дунд: э, о, ө, доод: а.” [Б. Х. Тод. 1964:05]

• “Хоёр төрөл бус хэл **их зөрөөтэй**, хоёр төрөл хэл **дунд зэрэг зөрөөтэй**, нэг хэлний хоёр аялгуу **бага зөрөөтэй** байдаг гэсэн зарчмыг баримталж байна.” (Ж. Сан. 2011:183) “Бид орчин цагийн монгол төрөл хэл аялгуунд **их авиалбар/гиперфонем/, авиалбар/фонем/, авиа** гэсэн **гурвалсан** тогтолцоо байна хэмээн үзэж байна.” [Ж. Санжаа. 2011:245]

• Халхын аялгууны **с, ч, ц** гурван гийгүүлэгч буриад аялгуунд **h, ш, с** гурван гийгүүлэгчээр сэлгэдэг хуультай. [Г. Д. Сан. 1953:45]

Хэл шинжлэлтэн эрдэмтдийн бүтээлд дурдсан, монгол хэлний авиазүй, авиалбарзүйн түвшний эдгээр **гурвал** олон бүрэлдүүлбэрийг тоймлон нэгтгэвэл, эгшиг авиа, авиалбарын гурвал бүрэлдүүрбэр, гийгүүлэгч авиа, авиалбарын гурвал бүрэлдүүлбэр, ер эгшиг, гийгүүлэгч авиа, авиалбарын зүй тогтлын зүйл зүйл гурвал бүрэлдүүлбэр байна. Ялангуяа, монгол хэлний үгийн үе, өргөлт, авианы сэлгэлт, зөв бичих зүй зэргийн **гурвал** бүрэлдүүлбэр нь өвөрмөц тогтолцоо юм. Энэ нь монгол хэл шинжлэлийн судалгаа, хэлний сургалтад суурь ойлголт болно. 1832 оны Я. Шмидтийн “Монгол хэлний

зүй” —ээс өдгөө хүртэл бичсэн монгол хэлний хэлзүйн бичгүүдэд хэлбэрсудлалын олон гурвал бүрэлдүүлбэр байгааг онцлон тэмдэглүүштэй байна.


### Хоёр. Үсэгзүйн түвшин.

Монголчууд үсэг бичиг авч, боловсруулсан мянга гаруй жилийн түүхэнд үсэг, үсэглэврийн бүтэц, тогтолцоо ихэд нарийн хэвшин бүрэлджээ. Саяхнаас үндэсний бичиг хэмээн нэрлэж буй монгол бичгийн үсэглэврийн зурмыг мэргэн ухаан зарж, нарийн журамтай болгожээ. Монгол бичгийн үсэглэврийн тогтолцоог цаашид судлууштай. Жишээлбэл, нэгэн үсэглэвэр үгийн **эхэн, дунд, эцэст** гэх гурван зурамтай байгааг авиалбарыг тод, дунд, балархай хэлдэгтэй холбон үзэж ч болох талтай юм. Хэл судлаачид монгол хэлний үсэгзүйн гурвал бүрэлдүүлбэрийг бичсэн байна. Үүнд:

Монгол бичгийн үсэглэврийн зурмыг нэлээд нарийвчлан судалсан академич Б. Ринчен бээр “Монгол үсгийн цагаан толгойд ᠠ ᠡ ᠢ ᠣ ᠥ а, э, и, о, ө таван тэмдгээр долоон эгшиг авиаг тэмдэглэжээ. Чухам нарийвчилбал, таван тэмдэг нь угтаа ᠠ ᠡ ᠢ ᠣ а, и, о ... **гуравхан** тэмдгээр таван тэмдэг болгосон нь ... монгол үсэг зохиогчид туйлын цөөн тэмдгээр хэрэгцээт авиаг тэмдэглэх аргыг сүрхий нарийн олжээ. ...**Гурван** тэмдэгтээр таван үсэг зохиох аргыг ямар ч бодох машин ондоогоор гаргахгүй тийм сүрхий нарийн бодож олсон аргыг нь үнэхээр сонин гэж хэн ч гайхан бодмоор ажам.” [Б. Рин. 1966:46] гэжээ.

- “Долоон эгшиг тэмдэглэх долоон үсэг нь **гурван** тэмдэгтээс бүтжээ.” [Ц. Дам. 1957:146]

- “13 дугаар зууны монгол хэлэнд ...эгшиг авианд оногдох тэмдэг зөвхөн **ацаг, шилбэ, гэдэс гуравхан** байсан,...Үгийн эхэнд орвол **гурвууланд** нь цөм нэгэн ацаг нэмэгдэнэ.” [Ц. Нор. 1987:136]



- М. Базаррагчаа “Монгол үсэг нь авианы адилаар утгатай юм. Шүд, шилбэ, гэдэс **гурав** нь монгол хэлний анхдагч эгшигийн үүсэлтэй холбоотой байж болох юм. Шүд, шилбэ нь тус бүр хоёр болж, гэдэс нь дөрөв болж, нийтдээ найман эгшиг яваандаа бий болжээ.” [М. Баз. 1995:5936]

- Академич Ц. Дамдинсүрэн “Чойжи-Одсэр монгол **үсгийг** анх **чанга, хөндий, саармаг** анги болгож хуваажээ. Ингэж **гурван** анги хуваасан нь монгол хэлний өвөрмөц байдалд тохирсон бөгөөд монгол хэлийг сайн судалж байж энэ хуваарийг хийсэн байх ёстой.” [Ц. Дам. 1957:140] Ер монгол бичгийн ямар ч үсэг **гурваас** илүү зурам үгүй юм. “Үсэг нь үгийн **эхэнд, дунд, эцэст** гэх **гурван** хэлбэртэй.” [Я. Шми. 1832:01] “Монгол бичгийн үсэг: **Эхэн, дунд, эцэст** гэсэн зурамтай.” (Б. Я. Вла. 1929:71),

• Кирилл шинэ бичигт “к, ф, щ **гурван** үсэг нь зөвхөн ормол үгэнд тохиолдоно. **Капитал, Франц, Щедрин** гэх мэт.” [З. К. Кась. 1968:09]

• Тод үсэг 1648 он. “Монгол уйгур үсгийг бага зэрэг засварлан **ө ү, о у, д т** зэрэг урьд нь хэлбэрээр ялгардаггүй байсан үсгийг дүрсээр нь ялгаж зохиосон үсэг. ...” [Б. Сумь. 1972:35] Ийнхүү **гурван** хос үсэг бүр адил зурамтай.

• Мөн монгол бичгийн нэг үсгээс хоёр үсэг уламжилсан болохыг “**а-аас о,у** хоёр, **э-ээс ө, ү** хоёр, **на-аас но, ну** хоёр, **нэ-ээс нө, нү** хоёр ...56 үсгийг зохиов.” [П. Б. Бал. 1962:42]

• Ц. Шагдарсүрэн “Монгол туургатны хэрэглэж ирсэн олон зүйл бичиг үсгийн дурсгалыг үзвэл, бичих журмын хувьд хэрэглээний зорилго, тухайн цаг хугацааны шалтгаацлаас үүдэж, хэдэн зүйл ялгаатай байжээ. Үүнд:**Хичээнгүй бичиг**

#### Таталган бичиг

**Эвхмэл бичиг** хэмээн хувааж болох юм” [Ц. Шаг. 2001:201] гэжээ.

• А. Д. Руднев монгол бичгийн хэлнээ **гурвал** бүрэлдүүлбэр бүхий цэг байдгийг бичсэн: “1. **Цэг**, 2. **Давхар цэг**, 3. **Дөрвөлжин цэг**” [А. Д. Руд. 1905:28] гэжээ.

Монгол бичгийн хэлний үндэсний бичгийн үсэг, үсэглэврийн **гурвал** бүрдүүлбэрийг дээрх байдлаар ажиглаж ирсэн нь түүний зүй тогтол, бүтэц, тогтолцоог танин тэдэж, судалсны үр дүн юм.


#### Гурав. Хэлбэрсудлалын түвшин.

Монгол хэлний хэлзүйн байгуулал буюу хэлбэр судлалын **гурвал** зүй тогтол, бүтэц, тогтолцооны талаар монголч нар шинжилж бичсэн санал дүгнэлт цөөнгүй байна. Үүнд:

• Академич Ш. Лувсанвандан: “Монгол хэлний үгсийн аймгийг жагсаан сийрүүлбээс: 1. **Нэрс**, ...2. **Үйл үг**, 3. **Сул үг** ийм болно.” [Ш. Лув. 1939:47],

#### ҮЙЛ ҮГ

НЭРС



СУЛ ҮГ

• Академич Б. Ринчен: “Монгол хэлний эл **гурван** том ай: нэр, үйл, сул үг...” [Б. Рин. 1966:75] Р. Жагварал: “Миний бие монгол хэлний үгсийг аймаглах явдалд Ш. Лувсанвандан, Б. Ринчен нартай санал нэг бөгөөд өөрөөр хэлбэл, монгол хэлнээ **нэр үг, үйл үг, сул үг гуравхан** зүйл байна гэж үзэж байна.” [Р. Жаг. 1976:26] гэв. “Монгол хэлэнд 1. **Үйл үг**, 2. **Нэр үг**, 3. **Сул үг**.” [А. Д. Руд. 1905:29] “Монгол-халимаг хэлний үгсийг нөгцлөөр ялгагдах **нэр үг**, нөхцөлөөр хувилгах **үйл үг**, нөхцөлөөр үл хувилгах **сул үг** гэж **гурав** ангилж болно.” [А. Боб. 1849:52] гэжээ.


• Чой. Лувсанжав бээр “The positional order of Mongolian morphemes are: **R+D+I** (R-root morphemes, D-derivational morphemes, I- inflectional

morphemes) [Чой. Лу. 2005:199] хэмээн монгол хэлний бүтээврийн байрлалын дэс дарааг тэмдэглэжээ. Ц. Өнөрбаян “Олон тоотой **язгуур** нь цөөн дагаврын өмнө тохиолдож, цөөн тоотой **нөхцөл** нь олон үндсийн дараа орж, **дагавар** нь тоо ба хамрах язгуур, үндсээрээ яг дундын шинжтэй байна. Энэ нь хэлний үзэгдэлд байдаг тэгш хэмт шинж мөн.” [Ц. Өнө. 1998:102]

• “Жинхэнэ нэрийн ай: **Тоо, тийн ялгал, хамаатуулах...**” гурван айтай. [Орч. 1966:88-89] “Харьяалах, өгөх орших, гарах **гурав...** шууд бус тийн ялгал.” (Ш. Лув. 2019:51-53), “Нэр үгийн эгшиг, -н, гийгүүлэгчээр төгссөн **гурван ялгал** бий.(Я. Шми. 1832:25), “Нэр үгийг онцлогоор нь **жинхэнэ нэр, тэмдэг нэр, тооны нэр** гэж ангилна.” [А. Поп. 1847:28] “Тэмдэг нэрийн **ерийн зэрэг**: Хангайн сайхан нуруу. Идэрийн сайхан гол. **Харьцуусан зэрэг**: Цаснаас цагаан, яснаас хатуу. **Давуу зэрэг**: Хамгийн дотно, адгийн муу.” [Орч. 1966:106-108] “Тэмдэг үгийн харьцуулсан зэргийг дотор нь **ерийн зэрэг, харьцуулсан зэрэг, давуу зэрэг** гэж **гурав** ангилж болно.” (Орч. 1985:255)

### ЕРИЙН ЗЭРЭГ

ХАРЬЦУУЛСАН ЗЭРЭГ



ДАВУУ ЗЭРЭГ

• “Бие гэгч **гурав** бий. Өөрийн **биеийг 1-р бие**, хэлэлцэгчийг **2-р бие**, 1-р, 2-р-аас бусад хөндлөнгийн этгээдийг **3-р бие** гэнэ.” [Ш. Лув. 2019:65] Монгол бичгийн хэлнээ зөвхөн эгшгээр бүтсэн нөхцөл **гурав** буйг Г. Д. Санжеев “**i** заахын тийн ялгал, **u** харьяалахын тийн ялгал, **a** орны тийн ялгал...” (Г. Д. Сан. 1953:163) гэж тэмдэглэжээ. “4. **Гурван биеийн** хүсэх төлөв үндсэн үйл үгнээ –аасай, –ээсэй, –сай, –сэй нөхцөл залгаваас **гурван биеийн** алинд ч өөрцгүй гүйцэтгэхүйд бэрхшээл бүхүй эрмэлзлэлийг гүйцэтгэхийг гүнээ эрмэлзсэн төлөв илэрнэ.” [Ш. Лув. 1939:130] “Нэрийн **гурван биед** хамаатуулах –минь, –чинь, –нь нөхцөлийг зохих нэрд нь залгаж, нэгдүгээр, хоёрдугаар, гуравдугаар биеийг нь ялгаж заадаг бол үйлийн **гурван биед** хамаатуулах яв-аарай гэх мэтийн олон нөхцөлийг зохих үйл үгэнд нь залгаж, уул үйлийн эзний хэддүгээр биед хамаатахыг заадаг.” (Ш. Лув. 2019:72) “Биеийн төлөөний үгийг **1-р биеийг** заан төлөөлөх, **2-р биеийг** заан төлөөлөх, **3-р биеийг** заан төлөөлөх гэж ялган үзэж болно.” (Орч. 1966:200) “Монгол хэл **гурван** биетэй. Би, чи, энэ/тэр/, минь, чинь, нь...” (Я. Шми. 1832:43) “Үүсмэл үйл үгийн 1. **Страдательные**, 2. **Переносные**, 3. **Взаимные** хэв бий.” [Я. Шми. 1832:79-84]

• З. К. Касьяненко “Монгол хэлний үйл үг бол **чухам үйл үг, үйлт нэр, нөхцөл үйл үг гэсэн гурван** үндсэн хэлбэртэй.” [З. К. Кась. 1968:13] гэжээ.

• “Үйлийн зэрэгцүүлэн холбох нөхцөлүүд: 1. Зэрэгцүүлэн холбох –**ж/-ч/** нөхцөл, 2. Зэрэгцүүлэн холбох –**аад/-ээд, -оод, -өөд/** нөхцөл, 3. Зэрэгцүүлэн холбох –**н** нөхцөл гэх **гурван** зүйл нөхцөл буй.” [Орч. 1987:112]

• “Цаг: Цагт нэрийн **өнгөрсөн, одоо, ирээдүй гурван** цаг, үйл үгийн **өнгөрсөн, одоо, ирээдүй гурван** цаг байна.” [А. Боб. 1835:59-73] “Жинхэнэ үйл үгийн өнгөрсөн цагийн нөхцөл нь: **-в**: Өнгөрөн төгссөн цаг: гарав, ирэв, бичив, **-жээ, -чээ**: Өнгөрөн үргэлжилсэн цаг: явжээ, гарчээ, босчээ, **-лаа/-лээ, -лоо, -лөө**/: Саяхан дууссан цаг: гарлаа, ирлээ, бичжээ гэх мэт.” (З. К. Кась. 1968:19-20) гэсэн тогтолцоотой гэжээ.

• Б. Х. Тодаева монгол хэлний үйл үгийн байдал/вид/ нь **гурван хувирал/** модификаторы/-тай гэжээ. а/. Үйл **эхлэх** байдал/начинательный вид/: **эхлэх**, б/. Үйл **үргэлжлэх** байдал/длительный вид/: **суух, явах, хэвтэх...** в/. Үйл **төгсөх** байдал/завершенный вид/: **авах, дуусах** гэх мэт.” (Б. Х. Тод.1951:116) гэжээ. Мөн “Орчин цагийн монгол хэлэнд **эхлэх байдал/начинательный вид/, үргэлжлэх байдал/длительный вид/, төгсөх байдал/законченный вид/** бий.” (З. К. Кась. 1968:48) гэсэн.

• З. К. Касьяненко “Орчин цагийн монгол хэлэнд 1. **Үйлдүүлэх хэв/** побудительный залог/, 2. **Үйлдэгдэх хэв/** страдательный залог/, 3. **Харилцан үйлдэлцэх хэв/** совместно-взаимный залог/ байна.” гэж бичжээ.

• М. Базаррагчаа бээр монгол хэлний **гурвал Н** буйг бичжээ. Үүнд:**Тогтвортой н**: дажин, дайн, **Завсрын н**: мананцар, цагаандай, **тогтворгүй н**: урин, урь (М. Баз. 2002:77) гэв.

Монгол хэлний хэл зүйн өвөрмөц зүй тогтол, бүтэц, тогтолцооны талаар хэл зүйчид судалж, **гурвал** бүрэлдүүлбэрүүд байгааг дээрх жишээ ба эш татсан ёсоор бүтээлдээ дурджээ. Монгол хэлний нэр ба үйл үгийн тогтолцоонд төрөл бүрийн айн гурвал бүрэлдүүлбэр байгаа нь манай сэтгэхүй, хэлний шүтэлцээний уугал тогтолцоо бөгөөд монгол аман хэлэхүйн хэвшил нь бичгийн хэлнээ улмаар дархлаа болж, олон мянган жил урт хугацаа, уудам орон зайд үеийн үед уламжлан, ихэвчилэн гурав гурваараа аяндаа цэгцэрсээр өдгөө болжээ.

#### **Дөрөв. Өгүүлбэрзүйн түвшин.**

Монгол хэлний өгүүлбэрзүйн түвшинд гурвал бүрдүүлбэр цөөнгүй бий. Энэ нь монгол хэлний бүтэц, тогтолцооны өвөрмөц нэгэн тал юм. Үүнд:

• “Энгийн өгүүлбэрт **өгүүлэгдэхүүн, өгүүлэхүүн, холбоц/связи**” [Я. Шми. 1832:128] гэсэн **гурван** бүрдүүлбэр бий.


• Өгүүлбэрийн дэд гишүүд “1. Тодотгол, 2. Тусагдахуун, 3. Байц.” (Орч. 1966:278-293) гэх **гурвал** бүрэлдүүлбэртэй.

• Монгол хэлний өгүүлбэрзүйн үг, нэгжийг холбох үндсэн **гурван** хэв маяг байгааг Т. А. Бертагаев бээр “...1. **Зэрэгцүүлэх** холбоо, 2. **Угсруулах/** захируулах/ холбоо, 3. **Харилцан захируулах** холбоо...” [Т. А. Бер. 1964:03] гэв. Б. Пүрэв-Очир “1. Угсруулах холбоо, 2. Зэрэгцүүлэх холбоо, 3. Харилцан зэрэгцүүлэх холбоо...” [Б. Пүр. 2001:101] гэжээ. “Зөвхөн нэрийн холбоо үг төдийгүй монгол хэлний угсруулах аргаар холбогдсон аливаа дэлгэрэнгүй хам бүтэц нэг бол үг+холбоо үг, холбоо үг+үг, эсвэл холбоо үг+холбоо үг гэсэн **гурван** үлгэртэй байна.” (Б. Раг. 1975:152) “Чөлөөт холбоо үгийн бүр-

элдүлбэр нь **а**. Энгийн үг, **в**. Үгийн санжсан холбоо үг, **с**. Хэлзүйжсэн холбоо үг байна.” [Лх. Дам. 1978:17]

- Монгол хэлний өгүүлбэрийг утгаар нь “Өгүүлбэр дотроо **асуух** өгүүлбэр, **дуудах** өгүүлбэр, **хүүрнэх** үгүүлбэр хэмээн **гурван** анги хуваагдана.” [Ш. Лув. 1939:44-51]

- Б. Пүрэв-Очир “Өгүүлбэрийн гишүүдийн зааж байгаа **юм**, **шинж**, **үйл** гэсэн үндсэн **гурван** гол утгыг учир шалтгааны болон хэл зүйн утгын холбоонд оруулан өгүүлбэрийн таван гишүүний хоорондын утгын холбоо, хамаарлыг гаргаж болно. Үүний тулд **юм**, **шинж**, **үйл гурвын** харьцааг **гурвалжингаар** төсөөлөн хийсвэрлэж, энэ гурвалжингаа **А** гээд, гурвалжингийнхаа нэг оройг **юм**, нөгөө оройг **шинж**, бас нэг оройг нь **үйл** гэж тэмдэглээд, ... утгын гурвалжингаа хэлбэр хоорондын холбоог үзүүлэх гурвалжин болгон өөрчилж, **В** гэж тэмдэглээд, гурвалжингийнхаа **юм** гэж тэмдэглэсэн оройг **юмын нэр/нэр үг/**, **шинж** гэсэн оройг харьцааны нэр /тэмдэг нэр, тооны нэр, дайвар үг, төлөөний үг гэх мэт/, **үйл** гэсэн оройг **үйлийн нэр/үйл үг/** гэж тэмдэглээд, ... эхний хоёр гурвалжинд /**АВ**/ түшиглэж, гурав дахь ... гурвалжнаа **С** гэж нэрлэн, гурвалжныхаа юм-юмын нэр гэсэн оройг өгүүлэгдэхүүн-тусагдахуун, шинж-харьцааны нэр гэсэн оройг байц-тодотгол, үйл-үйлийн нэр гэсэн оройг өгүүлэхүүн гэж тэмдэглээд, ... утгын холбоог үзүүлж байгаа юм. **АВС** гурвал гурвалжин нь проф. Б. Пүрэв – Очир монгол хэлний холбоо үгийн өнгөн бүтэц, гүн бүтцийн шүтэлцээгээр өгүүлбэрийн бүтэц хэсэг болсон холбоо үгийн утга зүйн онол буюу оюун дүгнэлт бичсэн байна.



... Өгүүлбэрийн гишүүд хоорондын холбоо гэдэг нь мөн л давхарласан тогтолцоотой үзэгдэл бөгөөд тэр нь **утга-хэлбэр-үүрэг/семантика-форма-функция/** гэсэн **гурвалсан /триада/ шинжтэй** байна.” [Б. Пүр. 1988:71-73] хэмээн өгүүлбэрийн доторх утга хэлбэрийн **гурвал** бүрэлдүүлбэрийг судалжээ. Монгол хэлний өгүүлбэрзүйн **гурвал** олон бүрэлдүүлбэр бол манай хэлний байгууламжийн язгуур тогтолцоо бөгөөд ер монголчуудын гурваар хэмжээлэн сэтгэж ирсний илрэл бололтой. Ялангуяа, проф. Б. Пүрэв-Очирын өгүүлбэрийн утгазүйн гурвал онолын тайлбар нь оновчтой байна.

#### **Тав. Үгийн сансудлалын түвшин.**


Монгол хэлний үгийн сан нь “Түрэг, монгол, манж-хамниган хэлний нийт дундын үг ч монгол хэлний үгийн санд багтах ёстой. ...Олон монгол хэлний

дундын үгс ч байх,... монгол хэлэнд харь гаралтай үг ам ба бичгийн аль алинаар нь нэвтрэн орсоор ирсэн билээ.” [Ж. Төм. 2001:52-56] гэсэнчилэн, алтай язгуурын хэлний үг, нийт монгол хэлний үгс, харь хэлний үгс гэсэн **гурвал** бүрэлдүүдбэртэй байна.

• Монгол хэлний үгийн сан-хэлбэр судлалын хосмолжин түвшинд үгийн **гурван зүйл** дохио байдаг. Академич Ш. Лувсанвандан бээр “Үг нь бодит ертөнцийн юм, үзэгдэл, чанар, хөдөлгөөнийг **нэрлэсэн, заасан, асуусан** дохио байна. Жишээлбэл, нар, сар, хүн, морь, уул, ус, дуу, цахилгаан, жаргал, зовлон, сайн, муу, өндөр, нам, дээр, доор, хойно, өмнө, олон, цөөн, явдал, үзэл, нэмэлт, хасалт, яв-, үз-, нэм-, хас-, сурагч, жолоодогч, бичдэг, сурсан, хоёр, гурав гэх мэтийн үгс нь тухайн юм, үзэгдэл, чанар, хөдөлгөөнийг **нэрлэсэн** дохио болж, би, чи, энэ, тэр, ийм, тийм, өдий, төдий, энд, тэнд, ингэ-, тэг-, гэ- гэсэн үгс нь тухайн юм, үзэгдэл, чанар, хөдөлгөөнийг нэрлэлгүй **заасан** дохио болно. Үүнээс гадна хэн, юу, ямар, хэд, хаана, яа-, хайч- гэх мэтийн үгс нь тухайн юм, үзэгдэл, чанар, хөдөлгөөнийг **асуусан** дохио болно. Энэ мэтээр бодит ертөнцийн нэг юм, үзэгдэл, хөдөлгөөнд зориулсан нэрлэх дохио, заах дохио, асуух дохио гэж **гурван** зүйлийн дохио байдаг. Жишээлбэл, морь гэсэн уул юмын нэрлэсэн дохио, морь гэж нэрлэлгүй заагаад энэ гэвэл заасан дохио, мөн морийг заагаад энэ юу вэ? гэвэл асуусан дохио болох мэт.” [Ш. Лув. 1968:14-15]

### НЭРЛЭСЭН ДОХИО

ЗААСАН ДОХИО



АСУУСАН ДОХИО

• Ж. Төмөрцэрэн монгол хэлний хэлцийг гурав ангилсан байна. “1. Өвөрмөц хэлц: хөх инээд, 2. Зүйрлэсэн хэлц: Хүний гараар могой барих, 3. Хэвшмэл хэлц: Өргүй бол баян, Өвчингүй бол жаргал.” (Ж. Төм.2001:139-141) гэх мэт.

• “Ялангуйяа, үгийн сангийн синоним найруулгын **гурван зэргээр** нарийн ялгарч байгааг доорх жишээнээс харж болно. Үүнд:

Тэргүүн – толгой – бөндгөр,

Хүртээх – өгөх – чулуудах,

Зоог – хоол- бантан, угаадас,

Зооглох – идэх – гудрах,

Нойрсох – унтах – ширгэх,

Морилох – явах – сажлах,

Өргөө – гэр – овоохой....” (Д. Отго.1997:49) гэж бичжээ.




Монгол хэлний үгийн сан-найруулга зүйн судлалд ийм гурвал бүрэлдүүлбэр бий.

**Зургаа. Найруулгазүйн түвшин.**

Монгол хүний тархинаа томьёолбор/код/ хэлбэрээр дардас мэт хэвшин тогтсон хэл, монгол хүний хэлийг үйл хөдлөл, ахуйн хэрэглээ, хүний харилцаанд оруулж буй хэлэх, түүний зууч болсон хүний сэтгэхүй, танин мэдэхүй тэргүүтний шүтэлцээ нь хэлний найруулгыг бүтээдэг гэж болно. Монгол хэлний найруулгазүйд гурвал бүрэлдүүлбэр бий.

- “Дээд найруулга/ном судрын найруулга/, доод найруулга/ярианы ба хар ярианы найруулга/, дундаж найруулга.” (М. Баз. 2003:24) байдаг. Дэлхий дахины олон хэлний гурван найруулгын онолд таацах монгол найруулгын гурван зэрэглэл байгааг манай эрдэмтэд бичсэн ч байна. Эрдэмтэн Д. Отгонсүрэн “...Ном бичгийн хэл буюу эрхэмсэг найруулга/высокий стиль, книжный стиль/, ердийн найруулга/нейтральный стиль, средний стиль/, доод найруулга буюу хар ярианы найруулга/сниженный стиль, разговорный стиль/ ...” (Д. Отго. 1979:07) гэжээ.

Ер монгол хэлний найруулгазүйн найруулгын гурвал эрэмбэ тогтолцоог гурвалжингаар дүрслэн зураглаж болох юм.



Мөн Р. Жагварал “Монгол хэлний хүндэтгэлийн үг бол дээд найруулгын хүрээнд багтдаг.” (Р. Жаг. 1976:40) гэв. Монгол хэлээр найруулан бичихэд гурвал хэмжээстэй ч байна.

**Долоо. Түүхэн хэлзүй.**

Монгол хэлний үүсэл, хувьсал, хөгжил гурвал ойлголт, бүрэлдүүлбэртэй байна.

- Б. Я. Владимирцов “...1. Нийт монгол хэл аялуу, 2. Дунд үеийн монгол хэл аялгуу, 3. Шинэ үеийн монгол хэл аялгуу...” (Б. Я. Вла. 1929:47)



• Проф. Н. Поппе монгол хэлний түүхэн хөгжлийг **гурав** ангилжээ. “1. Нийт монгол хэл, 2. Дундад үеийн монгол хэл, 3. Орчин цагийн монгол хэл.” (Н. Поп. 1955:15-16)

• Ш. Лувсанвандан “Монгол судлалд монгол хэлийг **гурав** хувааж заншжээ. Энэ нь эртний монгол хэл, дундад эртний монгол хэл, орчин цагийн монгол хэл **гурав** болно. ...Хуучин монгол бичигт эртний монгол хэлийг голлон тусган авч, дундад эртний монгол хэлний зарим онцлогийг авч, орчин цагийн монгол хэлний зарим онцлогийг угтан авсан байна.” (Ш. Лув. 2019:182) гэхчилэн гурвал бүрэлдүүлбэр байна. Монгол хэл бол түүхийн явцад хөгжлийн гурвал бүрэлдүүлбэртэй болсоор байжээ.


#### **Найм. Утгасудлалын түвшин.**

Монгол хэлний гүн бүтцийг сайтар ажиглавал, гурвал бүрэлдүүлбэр бүхий тогтолцоо бий.

1      2      3

• Ж. Төмөрцэрэн “Үгийн юм ба ухагдахуунд харьцсан холбоог түүний утга гэж нэрлэдэг.” (Ж. Төм. 2001:22)

• “1. Юмс ухагдахуун хоёр шууд шалтгаант холбоотой. 2. Ухагдахуун тэмдэг хоёр сэтгэхүйгээр зууч хийсэн шууд шалтгаант холбоотой. 3. Юмс тэмдэг хоёр шалтгаант холбоогүй, ухагдахуунаар дам холбоотой болно. Ерөөс үгийн утга гэдэг бол хүний сэтгэхүй оролцсон асар их хийсвэрлэсэн гурвал харьцаа гэж болно.” (Д. Бад. 1997: 57) Утгын гурвалжинг баримтлав.



• Хэлний хамгийн бага утгат хэсэг - бүтээврийн утгыг “...Язгуур бүтээвэр-үгийн сангийн утга, дагавар бүтээвэр-үг бүтээх утга, нөхцөл бүтээвэр-үг хувилгах утга” (Орч. 1997:278) хэмээх бүтээврийн гурван зүйл утга бий.

• Монгол хэлний холбоосыг Б. Х. Тодаева “Холбоос. 1. Холбох холбоос: ба, болон, бөгөөд. 2. Зааглах холбоос: буюу, уу/или/. 3. Болзол заах

холбоос: хэрэв/если/.” (Б. Х. Тод. 1951:162) гэж холбоосыг утгаар нь анги-ласан байна.

- Өгүүлбэрийн нөхцөлийн утга **гурвал** юм. “...**Асуух нөхцөл**: бэ?, вэ?, уу?, үү?, юу?, юү?, **онцлох нөхцөл**: шуу, шүү, даа, дээ, доо, дөө, л, ч, **барагцаалах нөхцөл**: биз, шив, ...” (Ш. Лув.1968:84-91)

- Н. Б. Дугаров Буриад хэл аялгууны ойролцоо утгат үгийг судлаад, утгазүйн бүрэлдүүлбэрийг гүнзгий танин мэдээд, “1. **Үнэмлэхүй** ойролцоо утгат үг/абсолютные синонимы/, 2. Санаа **дүрслэх** ойролцоо утгат үг/идеографические синонимы/, 3. **Найруулгазүйн** ойролцоо утгат үг/стилистические синонимы/.” (Н. Б. Дуг. 1978:40-48) гэжээ.

- Ю. Мөнх-Амгалан “Гуравдугаар биеэр төгсгөх **гурван** нөхцөл нь **гурвуулаа хүсэх цөм утгаараа** хоорондоо холбогдож, -г нь **зөвшин** хүсэх, -тугай, -түгэй нь **ерөөн** хүсэх, -аасай –ээсэй, -оосой, -өөсэй нь **мөрөөдөн** хүсэх нарийн өнгө аястай юм.” (Ю. Мөн. 1998:289) гэжээ. Монгол хэл шинжлэлийн утгасудлалын түвшний судалгаа нэлээд хожуу өрнөж эхэлсэн хэдий ч утгасудлалын хамааралтай гурвал бүрэлдүүлбэр байгааг хэл шинжээчид ийнхүү бичсэн байна.

### Ес. Аялгуусудлал.

Монгол утга зохиолын хэл тулгуурласан хийгээд тулгуурлаадүй олон аман аялгуу нь гурвал бүрэлдүүлбэртэй ч байдаг ажээ.

- Б. Я. Владимирцов халх монголчуудын хэлэлцэх аялгууг “1. **Дундад** халх буюу Улаанбаатарын халх нарын аялгуу, 2. **Зүүн** аймгийн халх нарын хэлэлцэх аялгуу, 3. **Баруун** аймгийн халх нарын хэлэлцэх аялгуу.” (Б. Я. Вла. 1929:09-10) гэж Халхын аялгууны хөгжлийн өвөрмөц онцлогийг харгалзан ангилсан учраас халх аялгуу нь хувьсал, хөгжлийн **гурвал** бүрэлдүүлбэртэй байгаа гэж ойлгож болох юм.

- Ж. Цолоо “Захчин аман аялгуунд нэр үгийн арван тийн ялгал байдаг. ...Орчин цагийн бичгийн хэлэнд байхгүй болсон зүг чиг заадаг, холбох, хэмжээ заадаг **гурван** тийн ялгал байгаа юм.” (Ж. Цол. 1965:70) гэж захчин аман аялгуунд онцгой гурвал бүрэлдүүлбэр байгааг тэмдэглэсэн байх жишээтэй байна. Ийм учраас аман аялгуунаа өвөр гурвал бүрэлдүүлбэр байдаг ажээ.

**Дүгнэн хэлбэл**, орчин үеийн монгол хэл шинжлэлийн түвшин, салбарт хэл шинжлэлтэн монгол хэлний авиазүй, авиалбарзүй, үсэгзүй, хэлбэрсудлал, өгүүлбэрзүй, үгийн сансудлал, найруулгазүй, түүхэн хэлзүй, утгасудлал, аялгуусудлал гэх зэрэг судалгаанд монгол хэлний гурвал бүрэлдүүлбэр байгааг бичсэн буй нь манай хэлний тогтолцооны өвөрмөц тал бөгөөд энэхүү гурвал бүрэлдүүлбэрийг өдгөөгийн хэлний судалгаа, сургалтад ихэд анхаарч, цаашид хэл шинжлэлийн онол, аргазүй болговол зохих юм. Монгол хүний сэтгэхүй, сэтгэлгээ, танин мэдэхүй, хэлний тогтолцооны гүн хамаарал ч харагдаж байгаа юм.

**Ном зүй:**

- (Аг. 1828) Агваандандар. Монгол үсгийн ёсыг сайтар номлосон хэлний чимэг хэмээгдэх оршив. Модон бар. 01,
- (Д. Бад. 1997) Д. Бадамдорж. Орчин цагийн монгол хэлний утгасудлалын үндэс. Улаанбаатар. 57,
- (М. Баз. 1995) М. Базаррагчаа. Монгол үгийн гарлыг мөшгөх нь. V. Улаанбаатар. 593б,
- (М. Баз. 2003) М. Базаррагчаа. Монгол хэлний сүегэр ба найруулбарын тухай. Улаанбаатар. 24,
- (М. Баз. 2002) М. Базаррагчаа. Утгын чуулган. Улаанбаатар. 77,
- (П. Б. Бал. 1962) П. Б. Балданжапов. Jiruken-u tolta-yin tayilburi. Монгольское грамматическое сочинение XVIII века. Улан-Удэ. 42
- (Т. А. Бер. 1964) Т. А. Бертагаев. Синтаксис современного монгольского языка в сравнительном освещении. Простое предложение. Москва. Стр. 03
- (А. Боб. 1835) А. Бобровников. Грамматика монгольского языка. Санктпетербургь. 59, 73,
- (А. Боб. 1849) А. Бобровников. Грамматика монгольско-калмыцкаго языка. Казань. 52
- (Б. Я. Вла. 1929) Б. Я. Владимирцов. Сравнительная грамматика монгольского письменного языка и халхаского наречия. Ленинград. 09-10, 57-63, 71, 417,
- (С. Гал. 1975) С. Галсан. Сопоставительная грамматика русского и монгольского языков. /фонетика и морфология/ часть 1. Улан-батор. 31
- (Ц. Дам. 1957) Ц. Дамдинсүрэн. Монгол хэл бичгийн тухай. Улаанбаатар. 140, 146,
- (Ц. Дам. 1983) Ц. Дамдинсүрэн, Б. Осор. “Монгол үсгийн дүрмийн толь. Улаанбаатар. 413,
- (Лх. Дам. 1978) Лх. Дамдинжав. Орчин цагийн монгол хэлний холбоо үг. Улаанбаатар. 17,
- (Н. Б. Дуг. 1978) Н. Б. Дугаров. Лексические синонимы в современном бурятском литературном языке. Москва. 40-48,
- (Р. Жаг. 1976) Р. Жагварал. Монгол хэлний хүндэтгэлийн үг. Улаанбаатар. 26, 40,
- (З. К. Кась. 1968) З. К. Касьяненко. Современный монгольский язык. Ленинград. 09, 13, 19-20,
- (В. Л. Кот. 1902) В. Л. Котвич. Лекции по грамматике монгольскаго языка... С. Петербургь. 23.
- (Ш. Лув. 1939) Ш. Лувсанвандан “Үгүүлбэр хэмээгч юу вэ? Шинэ толь сэтгүүл. № 1-2. Улаанбаатар. 44-51,
- (Ш. Лув. 1939) Ш. Лувсанвандан. Монгол хэлний зүй. Улаанбаатар. 47, 130,
- (Ш. Лув. 1968) Орчин цагийн монгол хэлний бүтэц, Монгол хэлний үг, нөхцөл хоёр нь. Улаанбаатар. 14-15, 84-91,

(Ш. Лув. 2019) Шадавын Лувсанвандан. Эрдэм шинжилгээний бүтээлийн чуулган. II боть. Орчин цагийн монгол хэлний сурах бичиг. Улаанбаатар. 36, 65,

(Ш. Лув. 2019) Шадавын Лувсанвандан. Эрдэм шинжилгээний бүтээлийн чуулган. V боть. Монгол хэлний бүтээвэр, өгүүлбэр, үгийн сан судлал. Улаанбаатар. 51-53, 72,

(Ш. Лув. 2019) Шадавын Лувсанвандан. Эрдэм шинжилгээний бүтээлийн чуулган. VI боть. Ерөнхий хэл шинжлэлийн зарим асуудал ба орчуулга. 182, 183,

(Чой. Лув. 2005) Choi. Lubcangjab. A contrastive analysis of the morphological structure of words in Mongolian and English. Pp. 199

(Ю. Мөн. 1998) Ю. Мөнх-Амгалан. Орчин цагийн монгол хэлний байжийн ай. Улаанбаатар. 289,

(Ж. Над. 1967) Ж. Надмид. Монгол хэл, түүний бичгийн түүхэн хөгжлийн товч тойм. Улаанбаатар. 27-28,

(Ц. Нор. 1987) Ц. Норжин. Монгол хэлний гол ёс. Өвөрмонголын сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо. Хөх хот. 136,

(Орч. 1966) Орчин цагийн монгол хэлний зүй. Улаанбаатар. 22-23, 26, 46, 88-89, 106-108,

(Орч. 1985) Орчин цагийн монгол хэл. Өвөрмонголын сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо. Хамтын бүтээл. Хөх хот. 255,

(Орч. 1987) Орчин цагийн монгол хэлний үг зүйн байгуулалт. Улаанбаатар. 112,

(Орч. 1997) Орчин цагийн монгол хэл. Их дээд сургуулиудын багш оюутан нарт зориулав. Улаанбаатар. 278,

(Д. Отго. 1979) Д. Отгонсүрэн. Ярианы найруулга, соёл. Улаанбаатар. 07,

(Д. Отго. 1997) Д. Отгонсүрэн. Монгол хэлний үгийн сангийн найруулга зүй. Улаанбаатар. 49,

(Ц. Өнө. 1998) Ц. Өнөрбаян. Орчин цагийн монгол хэлний үг зүй. Улаанбаатар. 102,

(Т. Паг. 1957) Т. Пагва. “Зүрхний тольтын тайлбар”-ыг судалсан тухай тэмдэглэл. Улаанбаатар. 41,

(Т. Паг. 1959) Т. Пагва. Хэлний шинжлэлийн удиртгал. Улаанбаатар. 39,

(Т. Паг. 1976) Т. Пагва. Хэл шинжлэлийн удиртгал. Улаанбаатар. 30, 34,

(А. Поп. 1847) А. Попов. Грамматика калмыцкого языка. Сочинение. Казань. 28,

(Н. Поп. 1955) N. Poppe. Introduction to Mongolian comparative studies. Helsinki. Pp. 15-16,

(Б. Пүр. 1988) Б. Пүрэв-Очир. Орчин цагийн монгол хэлний өгүүлбэрзүйн холбох тогтолцоо. Улаанбаатар. 71-73,

(Б. Пүр. 2001) Б. Пүрэв-Очир. Орчин цагийн монгол хэлний өгүүлбэрзүй. Улаанбаатар. 101,

- (Г. И. Рам. 1908) Г. И. Рамстедт. Сравнительная фонетика монгольского письменного языка и халхаско-ургинского говора. Санктпетербургъ. 54
- (Б. Раг. 1975) Б. Рагчаа. Орчин цагийн монгол хэлний бодит нэрийн холбоо үг. Улаанбаатар. 152,
- (Б. Рин. 1966) Б. Ринчен. Монгол бичгийн хэлний зүй. Дэд дэвтэр. Авиан зүй. Улаанбаатар. 46. 398,
- (Б. Рин. 1966) Б. Ринчен. Монгол бичгийн хэлний зүй. Гутгаар дэвтэр. Хэлбэрсудлал. Улаанбаатар. 75,
- (А. Д. Руд. 1905) А. Д. Руднев. Лекции по грамматике монгольского письменного языка. С. Петербургъ. 28, 29
- (Ж. Сан. 2008) Ж. Санжаа, Ж. Надмид. Монгол хэлний авиазүй ба авиалбарзүй. Улаанбаатар. 144, 146,
- (Ж. Сан. 2011) Ж. Санжаа. Монгол хэлний их авиалбар, авианы тогтолцоо. Улаанбаатар. 183, 245,
- (Г. Д. Сан. 1953) Г. Д. Санжеев. Сравнительная грамматика монгольских языков. Москва. 18, 45,
- (Б. Сумь. 1972) Б. Сумьябаатар. Монгол хэл, утга зохиол, аман зохиолын ном зүй. Улаанбаатар. 35,
- (Б. Х. Тод. 1964) Б. Х. Тодаева. Баоанский язык. Москва. 05,
- (Б. Х. Тод. 1951) Б. Х. Тодаева. Грамматика Современного монгольского языка, Фонетика и морфология. Ленинград. 112, 116, 162,
- (Д. Төм. 1992) Д. Төмөртоогоо. Монгол хэлний түүхэн хэлзүй. 1. Улаанбаатар. 82-94,
- (Ж. Төм. 2001) Ж. Төмөрцэрэн. Монгол хэлний үгийн сангийн судлал. Улаанбаатар. 22, 52—56, 139-141,
- (Ж. Цол. 1965) Ж. Цолоо. Захчины аман аялгуу. Улаанбаатар. 70,
- (Ц. Шаг. 2001) Ц. Шагдарсүрэн. Монголчуудын үсэг бичгийн товчоон. Улаанбаатар. 201,
- (Я. Шми. 1832) Я. Шмидт. Грамматика монгольского языка. Санктпетербургъ. 01, 06, 15, 25, 43, 43-44, 79-84

### References:

- (Ag. 1828) Agvaandandar. Mongol үсгийн yosyg sajtar nomloson helnij chimeg hemeegdekh orshiv. Modon bar. 01,
- (D. Bad. 1997) D. Badamdorzh. Orchin cagijn mongol helnij utgasudlalyn yndes. Ulaanbaatar. 57,
- (M. Baz. 1995) M. Bazarragchaa. Mongol үгийн garlyg mөshgөh n'. V. Ulaanbaatar. 593b,
- (M. Baz. 2003) M. Bazarragchaa. Mongol helnij syeger ba najruulbaryn tuhaj. Ulaanbaatar. 24,
- (M. Baz. 2002) M. Bazarragchaa. Utgyn chuulgan. Ulaanbaatar. 77,
- (P. B. Bal. 1962) P. B. Baldanzhapov. Jiruken-u tolta-yin tayilburi. Mongol'skoe grammaticheskoe sochinenie XVIII veka. Ulan-Ude. 42

- (Т. А. Бер. 1964) Т. А. Bertagaev. Sintaksis sovremennogo mongol'skogo yazyka v sravnitel'nom osveshchenii. Prostoe predlozhenie. Moskva. Str. 03
- (А. Bob. 1835) А. Bobrovnikov. Grammatika mongol'skogo yazyka. Sanktpeterburg». 59, 73,
- (А. Bob. 1849) А. Bobrovnikov. Grammatika mongol'sko-kalmyckago yazyka. Kazan'. 52
- (B. YA. Vla. 1929) B. YA. Vladimircov. Sravnitel'naya grammatika mongol'skogo pis'mennogo yazyka i halhaskogo narechiya. Leningrad. 09-10, 57-63, 71, 417,
- (S. Gal. 1975) S. Galsan. Sopostavitel'naya grammatika russkogo i mongol'skogo yazykov. /fonetika i morfologiya/ chast' 1. Ulan-bator. 31
- (C. Dam. 1957) C. Damdinsyren. Mongol hel bichgijn tuhaj. Ulaanbaatar. 140, 146,
- (C. Dam. 1983) C. Damdinsyren, B. Osor. "Mongol ysgijn dyrmijn tol". Ulaanbaatar. 413,
- (Lh. Dam. 1978) Lh. Damdinzhav. Orchin cagijn mongol helnij holboo yg. Ulaanbaatar. 17,
- (N. B. Dug. 1978) N. B. Dugarov. Leksicheskie sinonimy v sovremennom buryadskom literaturnom yazyke. Moskva. 40-48,
- (R. ZHag. 1976) R. ZHagvaral. Mongol helnij hyndetgelijn yg. Ulaanbaatar. 26, 40,
- (Z. K. Kas'. 1968) Z. K. Kas'yanenko. Sovremennyj mongol'skij yazyk. Leningrad. 09, 13, 19-20,
- (V. L. Kot. 1902) V. L. Kotvich. Lekcii po grammatike mongol'skago yazyka... S. Peterburg». 23.
- (SH. Luv. 1939) SH. Luvsanvandan "Ygyylber hemeegch yuu ve? SHine tol' setgyyl. № 1-2. Ulaanbaatar. 44-51,
- (SH. Luv. 1939) SH. Luvsanvandan. Mongol helnij zyj. Ulaanbaatar. 47, 130,
- (SH. Luv. 1968) Orchin cagijn mongol helnij bytec, Mongol helnij yg, nөhcөл hoyor n'. Ulaanbaatar. 14-15, 84-91,
- (SH. Luv. 2019) SHadavyn Luvsanvandan. Erdem shinzhilgeenij byteelijn chuulgan. II bot'. Orchin cagijn mongol helnij surah bichig. Ulaanbaatar. 36, 65,
- (SH. Luv. 2019) SHadavyn Luvsanvandan. Erdem shinzhilgeenij byteelijn chuulgan. V bot'. Mongol helnij byteever, өггүлбер, үгijn сан судлал. Ulaanbaatar. 51-53, 72,
- (SH. Luv. 2019) SHadavyn Luvsanvandan. Erdem shinzhilgeenij byteelijn chuulgan. VI bot'. Erenhij hel shinzhlelij zarim asuudal ba orchuulga. 182, 183,
- (CHoj. Luv. 2005) Choi. Lubcangjab. A contrastive analysis of the morphological structure of words in Mongolian and English. Pp. 199
- (YU. Mөн. 1998) YU. Mөнh-Amgalan. Orchin cagijn mongol helnij bajzhijn aj. Ulaanbaatar. 289,

- (ZH. Nad. 1967) ZH. Nadmid. Mongol hel, tyynij bichgijn tyyhen hөгzhlijн товч тоjm. Ulaanbaatar. 27-28,
- (C. Nor. 1987) C. Norzhin. Mongol helnij gol yos. Өвөрмонголн сурган hymyyzhlijн hevlelijн horoo. Hөh hot. 136,
- (Orch. 1966) Orchin cagijn mongol helnij зyj. Ulaanbaatar. 22-23, 26, 46, 88-89, 106-108,
- (Orch. 1985) Orchin cagijn mongol hel. Өвөрмонголн сурган hymyyzhlijн hevlelijн horoo. Hamтын бытеel. Hөh hot. 255,
- (Orch. 1987) Orchin cagijn mongol helnij yg зyjн bajгуулalt. Ulaanbaatar. 112,
- (Orch. 1997) Orchin cagijn mongol hel. Ih deed surгуулиудын bagsh оyuутan nart зoriулav. Ulaanbaatar. 278,
- (D. Otgo. 1979) D. Otgonsyren. YАriany najруулga, soyol. Ulaanbaatar. 07,
- (D. Otgo. 1997) D. Otgonsyren. Mongol helnij ygijn sangijn najруулga зyj. Ulaanbaatar. 49,
- (C. Өнө. 1998) C. Өнөrbayan. Orchin cagijn mongol helnij yg зyj. Ulaanbaatar. 102,
- (T. Pag. 1957) T. Pagva. “Zyrhний tol'tyn tajlbar”-yg sudalsan tuhaj temdeglel. Ulaanbaatar. 41,
- (T. Pag. 1959) T. Pagva. Helnij shinzhlelijн udirtgal. Ulaanbaatar. 39,
- (T. Pag. 1976) T. Pagva. Hel shinzhlelijн udirtgal. Ulaanbatar. 30, 34,
- (A. Pop. 1847) A. Popov. Grammatika kalmyckago yazyka. Sochinenie. Kazan'. 28,
- (N. Pop. 1955) N. Poppe. Introduction to Mongolian comparative studies. Helsinki. Pp. 15-16,
- (B. Pyr. 1988) B. Pyrev-Ochir. Orchin cagijn mongol helnij өггүлberзyjн holboh togtolcoo. Ulaanbaatar. 71-73,
- (B. Pyr. 2001) B. Pyrev-Ochir. Orchin cagijn mongol helnij өггүлberзyj. Ulaanbaatar.101,
- (G. I. Ram. 1908) G. I. Ramstedt. Sravnitel'naya fonetika mongol'skogo pis'mennogo yazyka i halhasko-urginskogo govora. Sanktpeterburg». 54
- (B. Rag. 1975) B. Ragchaа. Orchin cagijn mongol helnij bodit nerijn holboo yg. Ulaanbaatar. 152,
- (B. Rin. 1966) B. Rinchen. Mongol bichgijn helnij зyj. Ded devter. Avian зyj. Ulaanbaatar. 46. 398,
- (B. Rin. 1966) B. Rinchen. Mongol bichgijn helnij зyj. Gutgaar devter. Helbersudlal. Ulaanbaatar. 75,
- (A. D. Rud. 1905) A. D. Rudnev. Lekcii po grammatike mongol'skago pis'mennago yazyka. S. Peterburg». 28, 29
- (ZH. San. 2008) ZH. Sanzhaа, ZH. Nadmid. Mongol helnij aviazyj ba avialbarзyj. Ulaanbaatar. 144, 146,
- (ZH. San. 2011) ZH. Sanzhaа. Mongol helnij ih avialbar, aviany togtolcoo. Ulaanbaatar. 183, 245,

- (G. D. San. 1953) G. D. Sanzheev. Sravnitel'naya grammatika mongol'skih yazykov. Moskva. 18, 45,
- (B. Sum'. 1972) B. Sum'yaabaatar. Mongol hel, utga zohiol, aman zohiolyn nom zyj. Uaanbaatar. 35,
- (B. H. Tod. 1964) B. H. Todaeva. Baoan'skij yazyk. Moskva. 05,
- (B. H. Tod. 1951) B. H. Todaeva . Grammatika Sovremennogo mongol'skogo yazyka, Fonetika i morfologiya. Leningrad. 112, 116, 162,
- (D. Tөm. 1992) D. Tөmertogoo. Mongol helnij tьghen helzyj. 1. Ulaanbaatar. 82-94,
- (ZH. Tөm. 2001) ZH. Tөmөrceren. Mongol helnij ygijn sangijn sudlal. Ulaanbaatar. 22, 52—56, 139-141,
- (ZH. Col. 1965) ZH. Coloo. Zahchiny aman ayalguu. Ulaanbaatar. 70,
- (C. SHag. 2001) C. SHagdarsyren. Mongolchuudyn yseg bichgijn tovchoon. Ulaanbaatar. 201,
- (YA. SHmi. 1832) YA. SHmidt. Grammatika mongol'skoggo yazyka. Sanktpeterburg». 01, 06, 15, 25, 43, 43-44, 79-84,

Мұқабада - бұғытас. Моңғолия, Ховд аймағы, Мөст сұмыны.  
(фотосурет - Н.Баярхүү)

На обложке - «олений камень». Монголия, Кобдинский аймак,  
Мостинский сомон. (фотоснимок - Н. Баярхуу)

On the cover- Deer-stones, Mongolia, Hovd zone, Most-Samon region  
(photography - N.Bayarhuu)

Басуға 20.07.2020 қол қойылды . Офсеттік қағаз.  
Шартты баспа табағы 9,68. Пішімі 70x100  $\frac{1}{16}$ . Таралымы 500 дана.

---

**«Ғылым баспасы» ЖШС**  
Қазақстан Республикасы, 010000, Астана қ., Мостовая көш., 6.  
тел. +7 (7172) 57-49-83, 24-37-79